ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 921

танай ____________-ны №____________-т

НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Нийслэлийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Нийслэлийн Ардчилсан намын Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дах хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Нийслэлийн Ардчилсан намын мөрийн хөтөлбөр /....38..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Нийслэлийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

**НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМААС ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

АРДЧИЛСАН НАМ

# БҮТЭН УЛААНБААТАР
# БҮРЭН ХӨГЖИЛ

## НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

НИЙСЛЭЛИЙН
АРДЧИЛСАН НАМЫН
8488916 ХТО7584
УЛААНБААТАР ХОТ

**Улаанбаатар хот**
**2024 он**

## ГАРЧИГ


НЭГ. БҮТЭН УЛААНБААТАР .................... 3

1.1. Нийслэл Улаанбаатар хотын засаг захиргааны бүтцийг шинэчлэх, хотын удирдлагыг судалгаанд суурилсан шийдвэр гаргадаг, хариуцлагатай, нээлттэй болгох .................... 3
1.2. Орон сууцны хороолол, Гэр хорооллыг нэг стандарттай болгох .................... 4
1.3. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх .................... 6
1.4. Цахим технологийн ашиглалтыг бүрэн хөгжүүлэх .................... 6

ХОЁР. ГЭР ХОРООЛОЛД ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ .................... 7

2.1 Олон төвт хот болгон хөгжүүлэх .................... 7
2.2 Дэд бүтцийг гэр хороолold .................... 8
2.3 Гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцжуулах .................... 9

ГУРАВ. АЖЛЫН БАЙРТАЙ ГЭР ХОРООЛОЛ .................... 9

3.1 Нийслэл хотын хөрөнгө оруулалт, төсвийг гэр хороололд зарцуулах .................... 10
3.2 Гэр хороололд Бизнес эрхлэхэд таатай орчин бүрдүүлэх .................... 11
3.3 Ажлын байр бий болгох, эдийн засгийг тэлэх .................... 11

ДӨРӨВ. НОГООН ГЭР ХОРООЛОЛ .................... 12

4.1 Утаагүй тоосгүй хот .................... 12
4.2 Цэвэрхэн, хоггүй, хашаандаа модтой гэр хороолол .................... 12

ТАВ. ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ УЛААНБААТАР .................... 14

5.1 Түгжрэлгүй хот: .................... 14
5.2 Агаарын бохирдол .................... 16
5.3 Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй хот .................... 17
5.4 Эрүүл мэнд, боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр .................... 18
5.5 Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар, соёл, урлагийн байгууламжуудыг хамгаалах чиглэлээр: .................... 19


НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО
9023041590
УЛААНБААТАР ХОТ

# БҮТЭН УЛААНБААТАР
# БҮРЭН ХӨГЖИЛ

## НЭГ. БҮТЭН УЛААНБААТАР

Өнгөрсөн 8 жилийн хугацаанд Нийслэлийн Засаг даргыг олон удаа солисноор хотын засаглал тогтворгүй болж, Засаг Дарга бүр бүтцийн өөрчлөлт нэрээр мэргэжлийн газар, албадыг өөрчилснөөр Хотын тогтвортой хөгжил алдагдсан. Хотын удирдлагын зүгээс гаргаж буй шийдвэр оновчгүй болсноос, хэдхэн хоногийн настай шийдвэр гаргадаг нь иргэдийн бухимдлыг төрүүлсээр байна.

Дэлхийн улс орнуудын нийслэл хотуудтай харьцуулахад манай нийслэл Улаанбаатар нь:

- Засаглалын хямралд гүнзгий автсан
- Хамгийн үр ашиггүй засаглалтай
- Хэт олон дарга, удирдах ажилтан, албан хаагчтай
- Ажлын уялдаа муутай, үйл ажиллагааны давхардал, хийдэл ихтэй
- Ажлын хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал даамжирсан.

Иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээний зардал хэд дахин нэмэгдсэн ч иргэдэд хүрдэггүй, хугацаа тодорхой бус, албан тушаалтнууд хүнд суртал гаргаж иргэдийг чирэгдүүлдэг. Нэг цэгийн үйлчилгээ нь иргэдийн зөвхөн бичиг баримтыг л хүлээн авдаг газар болон хувирсан.

Нийслэл, дүүргийн төр захиргаа нь:

- Иргэдээ сонсдоггүй,
- Иргэдийнхээ өмнө тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэгдэггүй,
- Иргэдийн оролцооны эрх зүйн орчин тодорхойгүй,
- Иргэдийн саналыг ямар асуудлаар, ямар цар хүрээнд авах талаар тогтсон дүрэмгүй.

АН-ын засагласан 2012-2016 онд бид Улаанбаатар хотын дүрмийг боловсруулсан ч хараахан баталж чадаагүй байсан бөгөөд уг асуудал мартагдсан.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагаа нь иргэдэд нээлттэй биш, төсвийн зарцуулалт хаалттай, зэрэг олон сөрөг талууд нь иргэдийг ихээхэн хохироож байна.

Тиймээс бид 2016-2024 оныг Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт зогссон, гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүтээн байгуулалтын ажлыг саатуулсан, дэд бүтцийн ажлыг сааруулсан, хотын агаар орчны бохирдол улам нэмэгдсэн, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл алдагдсан ухралтын 8 жил байсан хэмээн дүгнэж байна.

### 1.1. Нийслэл Улаанбаатар хотын засаг захиргааны бүтцийг шинэчлэх, хотын удирдлагыг судалгаанд суурилсан шийдвэр гаргадаг, хариуцлагатай, нээлттэй болгох

1. Нийслэлийн нутгийн захиргааны болон нийслэлийн өмчит, аж ахуйн тооцоот байгууллагуудын чиг үүргийн давхардал, үйл ажиллагааны хийдлийг арилгаж, захиргааны төвлөрлийг 50 хүртэлх хувиар бууруулна.

АРДЧИЛСАН НАМ
НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7584
УЛААНБААТАР ХОТ

1117145633
УХА0612 9077278

2. Хот төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгох шинжлэх ухаан, судалгаа, хөгжлийн тинк танк төвийг байгуулж, түүнээс гарах судалгаа, төлөвлөгөө, тооцооллыг нийслэлийн бүх шатны шийдвэр гаргах үйл ажиллагаанд тусгах зохицуулалт, зохион байгуулалтыг журам боловсруулж хэрэгжүүлнэ.

3. Улаанбаатар хотын удирдлага аливаа суурь шийдвэр гаргахдаа судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, нийгмийн бүлгүүдийн санаачилгыг тусгаж, иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлнэ.

4. Улаанбаатар хотын олон нийтэд үзүүлэх төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй болгох зорилгоор засаг захиргааны нэгжийг шинэчлэн зохион байгуулж, тухайн нэгж бие даан асуудлаа шийдвэрлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож эдийн засгийн хувьд бүрэн бие даах нөхцлийг бүрдүүлнэ.

5. Нийслэл Улаанбаатар хотын нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын үйл ажиллагаа, тогтолцоог Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэчилнэ.

6. Нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны төрийн албан хаагчдыг эрхэлдэг ажлынхаа чиглэлээр сурч боловсрохыг дэмжиж, жил бүр сургалтад хамруулна.

7. Нийслэл хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын төслүүдийг үргэлжлүүлнэ. Техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн санхүүжилт шийдэгдсэн богино хугацаанд үр ашиг өгөх төслүүдийг хэрэгжилтүүдийг эрчимжүүлнэ.

## 1.2. Орон сууцны хороолол, Гэр хорооллыг нэг стандарттай болгох

Монгол Улсын Их Хурлаар батлагдсан "Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөө, 2030 оны төсөөлөл" бодлогын бичиг баримт хүрээнд хот суурин газрын хот байгуулалт, газрын харилцааны бодлогыг иргэдэд ил тод, нээлттэй болгож, нэн тэргүүнд хүүхдүүд, ахмадууд, тусгай хэрэгцээт хүмүүст ээлтэйгээр хэрэгжүүлэн, дэд бүтцийг тэлж, дагуул хот бүхий олон төвт хот болгон, нийтийн тээврийг олон улсын жишигт хүргэж Орон сууцны хороолол, Гэр хорооллыг нэг стандарттай болгоно. Хот суурин газруудын гэр хорооллын цахилгаан, дулаан, цэвэр бохир усны инженерийн шийдлийг төвлөрсөн болон бие даасан хэлбэрийг хослуулан хэрэглэх боломжийг олгоно.

Иргэдийн амьдрах, ажиллах, амрах боломжтой, хүний төлөө хот байхын тулд сургууль, эмнэлэг болон бусад олон нийтийн байгууламж зэрэг нийгмийн дэд бүтэц рүү гэрээсээ **10** хүртэл минутын зайд байх нөхцлийг бүрдүүлэх зорилт тавьж ажиллана.

### Хотын барилгажсан хэсгийн дэд бүтэц, орон сууцны хорооллыг шинэчлэх

8. Улаанбаатар хотын хуучин орон сууцуудыг шинэчлэн барилгажуулах, инженерийн дэд бүтцийг иж бүрэн шинэчлэх, хуучны угсармал орон сууцны дулаан алдагдлыг бууруулах ажлыг хэрэгжүүлнэ.

9. Хот суурин газруудад сэргээгдэх буюу нар, салхи, усны цэвэр эрчим хүчний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх бүс нутагтаа эрчим хүчийг тогтвортой нийлүүлэх бодлогыг түлхүү хөгжүүлнэ.
10. Мэдээллийн технологийн дэд бүтцийг өргөжүүлж, өргөн зурвасын, өндөр хурдны интернэт сүлжээг бий болгож зарим бүс нутагт 5G технологийг нэвтрүүлж эхэлнэ.
11. Улаанбаатар хотын орон сууцны хорооллууд болон хот орчмын (дагуул хотууд) суурин газруудын хатуу хучилтгүй зам талбайн дэд бүтэц болох байгалийн чулуун хучилттай зам талбай, ус зайлуулах шугам, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийг олон улсын стандартаар барина.
12. Төлөвлөлтөнд суурилсан газар доорхи болон дээрхи олон давхар авто зогсоолыг орон сууцны хорооллуудад хувийн хэвшилтэй хамтран барьж байгуулна.
13. Нийслэл Улаанбаатар хотод 100,000 орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх замаар барилгын салбарт ажиллагсадыг бодлогоор дэмжинэ.

**Дэд бүтэцтэй гэр хороолол**

14. Гэр хороолол болон орон сууцны халаалтыг цахилгаан эрчим хүчээр халаах технологийг дэмжиж эх үүсвэрийн тодорхой хэсгийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.
15. “Эрчим хүч үйлдвэрлэгч иргэд” хөдөлгөөнийг гэр хороололд өрнүүлж, иргэд хашаандаа нарны эрчим хүч үйлдвэрлэж илүүдэл эрчим хүчээ төвийн сүлжээнд борлуулах боломжийг бүхий л талаар дэмжинэ.
16. Гэр хорооллын цахилгаан, дулаан, цэвэр бохир усны инженерийн шийдлийг хамтран бүлэг бүлгээрээ бие даасан хэлбэрээр хэрэгжүүлэх технологийг хэрэгжүүлнэ.
17. Хот суурин газруудын ойролцоо усан сангийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлж, бичил цаг уурын орчин бүрдүүлж, хуримтлагдсан усыг ногоон байгууламжийн усжуулалтанд ашиглаж эхэлнэ.
18. Нийслэлийн гэр хорооллын иргэдийг хувийн орон сууцтай болгох чиглэлээр хувийн хэвшлийн оролцоог хангаж ажиллана.
19. Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, уг төслийн 2 дахь үе шатыг хэрэгжүүлнэ.
20. Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийг шийдэж айл бүрийг хашаандаа сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлнэ. Хашаандаа хувийн тохилог орон сууц барих санаачлагыг бодлогоор дэмжинэ.
21. Нийслэлийн гэр хорооллын инженерийн дэд бүтэц (цэвэр ус, бохир ус ариутгах татуурга, интернетийн шилэн кабель)-д холбож халаалтыг төвлөрсөн болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй хувийн орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, байшингаа барихад дэмжлэг үзүүлж ажиллана.
22. Хийн нөөцийг түшиглэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бага оврын цахилгаан станц байгуулна.

23. Газар чөлөөлөх ажлыг эрчимтэй хэрэгжүүлж, иргэдэд ойр цэцэрлэг, сургууль, эмнэлэг барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

24. Гэр хорооллын дундах авто замуудыг чанартай тавих, үерийн усны суваг шуудуу тавих ажлыг эрчимжүүлнэ.

### 1.3. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх

25. Нийслэлийн иргэд Улаанбаатар хотын Захирагчийг шууд сонгодог болно.

26. Нийслэл, дүүргийн удирдлага аливаа шийдвэр гаргах, зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд эрх, ашиг сонирхол нь зөрчигдөж буй иргэд, оршин суугч, олон нийт, аж ахуй нэгжийн саналыг харгалзаж, зөвшилцөн шийдвэрлэх тогтолцоо, дүрмийг боловсруулж хэрэгжүүлнэ.

27. Нийслэл, дүүргүүдийн удирдлага улирал бүр үйл ажиллагааны тайлангаа иргэд, олон нийтэд тайлагнадаг болно.

28. Улаанбаатар хотын иргэд, олон нийтийн санаа бодлыг тандах социологийн олон төрөлт судалгааг улирал тутам хийж, нийслэлийн бүх шатны шийдвэр гаргахад тусгадаг болно.

29. Шилэн дансны тухай хуулийг сэргээн хэрэгжүүлж, иргэдэд нийслэлийн төсвийн урсгал зардал, төсвийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг бүрэн ил тод болгоно.

30. Иргэд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдсон төлөөлөгчдөөрөө дамжуулан саналаа илэрхийлдэг байна.

АРДЧИЛСАН НАМ
НИЙСЛЭЛИЙН ... ХОРОО
9023041590
8488916 ХТО7584
УЛААНБААТАР ХОТ

### 1.4. Цахим технологийн ашиглалтыг бүрэн хөгжүүлэх

31. Нийслэлийн сүлжээ, интернетийн серверийн хүчин чадлыг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулна.

32. Хотоос алслагдмал дүүрэг, хорооны иргэдийн цахим хэрэглээ, үйлчилгээг тэгш хүртээмжтэй болгох орчны хөгжүүлэлт хийнэ.

33. Иргэдийн улсын бүртгэлийг бүрэн цахимжуулах, хөгжүүлэх, хаягжуулна.

34. Эрүүл мэндийн салбарт цахим шинэчлэлт хийж, шат болгоны үйлчилгээг нэгдсэн болгон эмнэлэгийн үйлчилгээг хялбаршуулан ачааллыг бууруулна.

35. Сургалтын тэгш хүртээмжийг хангах зорилгоор алслагдмал сургууль цэцэрлэгийн сурагчдын цахим сургалтын хүртээмжийг нэмэгдүүлнэ.

36. Иргэдийн цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах хамгаалалтын систем бий болгоно.

37. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш хүртээмжийг хангах зорилгоор тусгай зориулалтын цахим хуудас технологийн хэрэгцээг бүх шатны төрийн үйлчилгээнд нэвтрүүлнэ.

1117145633
УХА0612 9077278

38. Шуудангийн тогтолцоог Олон Улсын түвшинд хүргэж, хүргэлтийн системийг сайжруулан шуудан түгээлтийг 3 дахин нэмэгдүүлнэ.

## ХОЁР. ГЭР ХОРООЛОЛД ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ

Нийслэл Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөө нь 2013 онд Монгол Улсын их хурлаар батлагдсан боловч өнгөрсөн 8 жилд дорвитой ажил хэрэгжсэнгүй. Нэн ялангуяа гэр хорооллын иргэдэд чиглэсэн ажил огт хийгдээгүй бөгөөд дахин төлөвлөлтийн ажил бүрэн зогссон.

39. Нийслэлийн Засаг даргын сонгуульт хугацааны мөрийн хөтөлбөрийн зайлшгүй мөрдөн хэрэгжүүлэх баримт бичиг нь тухайн хот суурин газрын хот төлөвлөлтийн "Ерөнхий төлөвлөгөө" байна.

40. Хот байгуулалтыг боловсронгуй болгох зорилгоор шинжлэх ухааны судалгааны Хот төлөвлөлтийн "Судлан-Хөгжүүлэх" (Research & Development) байгууллагыг Засаг даргын шууд удирдлаган доор ажиллуулна.

41. Интернетийн орчинд хот төлөвлөлтийг ил тод, нээлттэй болгож, олон нийтийн хяналттай иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, үр бүтээлтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ.

42. Хот орчмын бүсийн төлөвлөлтөнд тодотгол хийж, газар тариалан, фермерийн үйлдвэрлэлийг дэмжих үйлдвэрийн бүсүүдийг бий болгож, ложистик болон биржийг хотуудын дэд бүтэцтэй уялдуулан төлөвлөж хэрэгжүүлнэ.

43. Гэр хороолold түүхий эд боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрлэлийг хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн зохион байгуулж, ажлын байрыг эрс нэмэгдүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ
НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО
9023041590
УЛААНБААТАР ХОТ

### 2.1 Олон төвт хот болгон хөгжүүлэх

Улаанбаатар хотыг ерөнхий төлөвлөгөөнд Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэх замаар нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилго тавьж, хотын дунд болон захын бүсийн гэр хорооллын нутаг дэвсгэрт дэд төвүүдийн байршлыг тодорхойлж, төлөвлөж, хөгжүүлэхээр заасан.

44. Олон төвт хот болгон хөгжүүлэх хөтөлбөрийг дэд бүтэц, орон сууц, төр, нийгмийн үйлчилгээ, ногоон байгууламж, худалдаа, үйлчилгээ, оршин суугчдын ажил эрхлэлт зэрэг асуудлыг нэгдмэл байдлаар авч үзэн, хэрэгжилтийг салбаруудын харилцан уялдаа холбоо бүхий багц үйл ажиллагааны хүрээнд хөгжлийн тасралтгүй эргэх холбоо бүхий үйл явцыг дэмжих удирдлага зохион байгуулалтаар хангана.

Олон дэд төвтэй болсноор хотын хүн ам, эдийн засгийн бага нягтралтай буюу гэр хорооллын хүн ам төвлөрсөн хэсэгт, бизнес эрхлэх боломжийг бүрдүүлсэн 6 дэд төвийн (Баянхошуу, Сэлбэ, Дамбадаржаа, Дэнжийн Мянга, Толгойт, Шархад дэд төвүүд) сүлжээг газрын эзэд, оршин суугчид болон төр, хувийн хэвшлийн хамтын

1117145633
УХА0612 9077278

ажиллагаанд тулгуурлан байгуулж хотын эдийн засгийг тэлэх шинэ боломжийг бий болгоно. Үүнд:

- Төрийн үүрэг: Дэд бүтцийн шугам сүлжээ тавих, нийгмийн барилга байгууламжийг барих ажилд тэргүүлэх үүрэгтэй оролцоно.
- Газар эзэд, оршин суугчдын оролцоо: Дэд бүтэц, нийгмийн зориулалттай барилга байгууламж, орон сууц барих зэрэгт зориулан газрын эрхийг шилжүүлэн шинэчлэн зохион байгуулах, төлөвлөж хэрэгжүүлэх үйл явцад тэргүүлэх үүрэгтэй оролцоно.
- Хувийн хэвшлийн үүрэг: Дэд төвд хөрөнгө оруулж, хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүрэгтэй оролцоно.

45. Олон төвт хот болгох хөтөлбөрийн зорилтыг биелүүлэхийн тулд дараах зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1) Батлагдсан дэд төвүүдийн хүрээнд үйлчилгээ үзүүлэх, орон сууц, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ төвлөрсөн, нийгмийн үйлчилгээний хүртээмжтэй, тав тухтай дэд төвүүдийг байгуулна.
2) Дэд төвүүдийг ногоон, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн, үр дүнтэй хөгжүүлэхийн тулд хорт утааны ялгаралтыг багасгах, нийгмийн дэд бүтэц, нийтийн тээврийн чанар, хүртээмжийг сайжруулах, эрчим хүчний зарцуулалт багатай барилга байгууламж, орон сууцны нийлүүлэлтийг дэмжих бодлого, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.
3) Хот суурины газрыг дахин хөгжүүлэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгон дэд төвийг хөгжүүлэхэд газрын эзэд, төр, хувийн хэвшлийн хамтын үйл ажиллагааг харилцан ашигтай байдлаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
4) Гэр хорооллын бүсэд эдийн засгийн үйл ажиллагааг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагч, үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчдийг үр ашигтай санхүүгийн зохицуулалтаар дэмжиж, эдийн засгийн өрсөлдөх чадвартай болгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.
5) Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн үр ашигтай байх дэд төвийг байгуулахад хорт утаа бага ялгаруулах, нийгмийн дэд бүтэц, нийтийн тээврийн чанар, хүртээмжийг сайжруулсан, эрчим хүчний хэмнэлттэй олон төрлийн орон сууцыг нэг маягийн зураг төслөөр хөгжүүлэх чиглэлийг дэмжинэ.

**2.2 Дэд бүтцийг гэр хороолold**

46. Газрыг хөгжүүлэхэд батлагдсан газар ашиглалтын хязгаарын хүрээнд дахин төлөвлөх, зохион байгуулах аргачлалуудыг ашиглан үе шатаар хэсэгчлэн хөгжүүлнэ.

47. Инженерийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг газрын эздийн хүсэл зорилго хамтын ажиллагааны хүрээнд тулгуурлаж хэрэгжүүлнэ

АРДЧИЛСАН НАМ
НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО
9023041590
УЛААНБААТАР ХОТ

1117145633
УХА0612 9077278

48. Дэд төвийн газрыг дэд бүтэцжүүлэхэд хотхон хорооллын гол болон салбар шугамыг эргэн нөхөгдөх нөхцөлөөр санхүүжүүлж, гэр хорооллын дэд бүтэцжүүлэх санг байгуулна.

49. Иргэдийн бүлгийг орчноо сайжруулахад чадавхжуулах, тэдний санаачилгыг дэмжих нийгмийн чиглэлийн үйл ажиллагааг холбогдох ТББ-аар дамжуулан хэрэгжүүлнэ.

50. Өндөр давхрын бус Зохистой нягтрал бүхий тохилог орон сууцны хороолол, хотхонтой, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ бүхий хотын дэд төвийг байгуулж, ажлын байр нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдын сонирхлыг татварын бодлогоор дэмжин эдийн засгийн хөшүүргээр татаж, үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

**2.3 Гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцжуулах**

51. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрыг ашиглах чиглэл, нягтрал, орон сууцны төрөл, төлөвлөлтийн хязгаарын хүрээнд дэд төвийг хөгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлнэ.

52. Газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаанд сонирхогч талуудын үүрэг, хариуцлага оролцооны түвшнийг жигд хангана. Нийгмийн байгууламж байгуулах, олон нийтийн зориулалттай гудамж талбай байгуулах орон зайг гаргаж, хөгжүүлэхэд улсын болон хувийн хөрөнгө оруулалтын зааг ялгааг тодорхой байлгаж талуудад харилцан ашигтай байх нөхцлийг бүрдүүлнэ.

53. Дэд төвийг хөгжүүлэхэд газар ашиглалт, хот байгуулалтын нийтэд ойлгомжтой, ил тод, нээлттэй журамыг боловсруулж, хашааг орон сууцаар солих бодлогыг хэрэгжүүлнэ.

54. Хүлэмжийн хийн ялгарал багатай, ногоон хөгжлийн үзэл баримтлалд дэд төв байгуулах бүхий л үйл ажиллагааг нийцүүлж, дэд төвийн иргэдийг орон сууцжуулах замаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хурдасгана.

## ГУРАВ. АЖЛЫН БАЙРТАЙ ГЭР ХОРООЛОЛ

Нийслэлийн 2024 оны төсвийн 2016 оны төсөвтэй харьцуулахад 6 дахин нэмэгдсэн байна. Нийслэлийн 2024 оны шууд орлого нь 1.1 их наяд төгрөг байхад зарлага нь 5.3 их наяд төгрөг байна. Нийслэлийн төсвийг 2017-2024 онд 8н удаа хэлэлцэн баталсан ба эдгээрийг 14н удаа тодотгосон байна. Энэ нь Нийслэл хотын удирдлагад төсвийн сахилга бат, төрийн санхүүгийн чадвар байхгүйг харуулж байна. Мөн нийслэлийн төсвийг 15 удаа тодотгохдоо зарлагыг нэмэгдүүлж байсан боловч орлого нь бодитоор нэмэгдээгүй байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын хувьд 2020-2024 онд дийлэнх хувь нь Сонгинохайрхан дүүрэгт хуваарилагдсан атал Сүхбаатар дүүрэгт 2023 онд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын 0.3%-ыг эзэлж буй нь хөрөнгө оруулалтын бодлогоор дүүргүүдийг жигд хөгжүүлэх бодлого алдагдсан. Нийслэлийн Засаг даргын хариуцдаг нийслэлчүүдэд төрийн үйлчилгээг хүргэх зориулалттай Нийслэлийн төсвийн

урсгал зардал нь 2016 оныхтой харьцуулахад 3.2 дахин өссөн байна. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт 2016 оноос 2024 оны хооронд **20 дахин** нэмэгдсэн.

### 3.1 Нийслэл хотын хөрөнгө оруулалт, төсвийг гэр хороолold зарцуулах

55. Төсвийн сахилга батыг сайжруулж нийслэлийн төсвийн урсгал зардлыг 50 хувиар тanana.

56. Нийслэлийн төсвийн 2025-2028 оны хөрөнгө оруулалтын 75-80 хувийг Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, гэр хорооллын дэд бүтцийг хөгжүүлэхэд зарцуулна.

57. Төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг ач холбогдлоор нь эрэмбэлж, үр ашигтай хуваарилалтын бодлого, болон холбогдох журмыг боловсруулж хэрэгжүүлнэ.

58. Нийслэл, дүүргүүдийн төсвийг уялдуулж, төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалттай болгоно.

59. Нийслэлийн харьяаны орон нутгийн өмчит компаниудын засаглалыг сайжруулж, нээлттэй, хариуцлагатай, олон нийтийн оролцоотой болгон хувьчлах замаар үр ашгийг нэмэгдүүлж, бүрдүүлсэн орлогыг төсвийн зардлын дарамтыг бууруулахад зарцуулна.

60. Нийслэлд ажлын байр шинээр нэмэгдүүлэх аж ахуй нэгж, байгууллага, иргэний санал, санаачилгыг дэмжиж, хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг нэмэгдүүлэх бодлогыг баримтална.

61. Газрын төлбөрийн орлогын эрх зүйн болон санхүүгийн зохицуулалтыг бүрэн шинэчилж нийслэлийн төсвийн татварын орлогын 30 хүртэлх хувийг бүрдүүлдэг болно.

62. Нийслэлийн төсвийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлж гүйцэтгэх, хяналт тавих бүх үе шат, үйл явцад иргэдийн санал санаачилгыг авч, иргэдийн оролцоог хангана.

63. Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан 100 хувь дүүргүүдэд хуваарилна.

64. 2012-2016 оны хооронд хэрэгжүүлсэн "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн хоёр дахь үе шатыг Азийн Хөгжлийн Банк болон олон улсын банк, санхүүгийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

65. Нийслэлийн өмнө тулгамдаж буй суурь асуудлуудыг гадаад, дотоодын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих, төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар шийдвэрлэж, төсвийн ачааллыг багасгана.

66. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Нийслэлийн төсөвтэй уялдуулан нэгдмэл болгох хөтөлбөр хэрэгжүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ
НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО
УЛААНБААТАР ХОТ

1117145633
УХА0612 9077278

### 3.2 Гэр хороололд Бизнес эрхлэхэд таатай орчин бүрдүүлэх

67. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, экспортын үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг гаргана.

68. Жижиг дунд болон бичил үйлдвэр эрхлэгчдийг гадаад зах зээлд гаргах, хил орчмын худалдаанд идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлнэ.

69. Гэр хороололд иргэд, ААН-ын бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн, өгөөжтэй санхүүгийн зуучлалыг хөгжүүлнэ. Санхүүгийн үйлчилгээний хүртээмж, үйлчилгээг ашигласнаар иргэн, ААН-д бий болох ашгийн бодит хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтын арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

70. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжин, хүнсний найман нэрийн дэлгүүрт тусгай зөвшөөрөл олгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

71. Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын ойр орчимд аж үйлдвэрийн парк байгуулах ажлыг дэмжинэ.

### 3.3 Ажлын байр бий болгох, эдийн засгийг тэлэх

72. Ажилгүйдлийн түвшинг 5%-аас бага байлгах хөдөлмөр эрхлэлтийн бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэн ажиллана.

73. Цагаар ажиллах, гэрээр ажиллах, зайнаас ажиллуулах, сүлжээний маркетинг бүхий бараа, үйлчилгээний борлуулалт хийх зэрэг хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэрийг дэмжих замаар эмэгтэйчүүд, оюутан залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

74. Ажил олгогчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг бүрэн хангах мэргэжилтэн бэлтгэх нөхцөлийг бүрдүүлнэ.

75. Нийслэлд нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэн, халамжийн хөтөлбөрүүдийг хөдөлмөр эрхлэлтэй уялдуулан хугацаатай болгоно.

76. Ядуурлыг бууруулах хөтөлбөрийг хороо, дүүрэг, нийслэлийн түвшинд тодорхой зорилт, шалгуур үзүүлэлтээр гаргаж, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулна.

77. Бага орлоготой, ядуу өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх, ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөрт хамруулах, ажлыг байранд зуучлах тогтолцоог бүрдүүлнэ.

78. Бага орлоготой, ядуу айл өрхөд зориулсан хүнсний хангамжийн хөтөлбөр хэрэгжүүлж, шим тэжээлийн дутагдлаас хамгаална.

79. Ажлын байр шинээр бий болгох хувийн хэвшлийн санал санаачлагыг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

80. Мэргэжилтэн, ажилтан бэлтгэх цогц бодлого хэрэгжүүлнэ. МСҮТ-үүд, Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд байгуулагдсан мэргэжилтэй ажиллах хүч

81. Өрх бүр хашаандаа мод тарих, тэдгээрийг төрөөс худалдаж авдаг тогтолцоотой болно.

82. Хот тохижилт, нийтийн аж ахуйн ажилд тухайн хороо дүүргийн иргэдийг сайн дурын үндсэн дээр хөлсөөр ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

## ДӨРӨВ. НОГООН ГЭР ХОРООЛОЛ

Улаанбаатар хотод нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ 4-6 $м^2$ байгаа нь 1.5 сая хүнтэй том хотод маш бага үзүүлэлт юм. Ногоон хот гэдэг нь байгалийн эко системийн бие даасан тогтвортой бүтэц, үйл ажиллагаанд загварчлагдсан хүн төрөлхтөний суурин юм.

**4.1 Утаагүй тоосгүй хот**

83. Гэр хороололд байрлах ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэнгийн тоог 5 дахин нэмэгдүүлнэ.

84. Гэр хороолол дахь эрчим хүчний хүчин чадлыг судалгаан дээр үндэслэж үе шаттайгаар нэмэгдүүлэх, дэд станцуудыг өргөтгөнө. Ингэснээр гэр хорооллын иргэд эрчим хүчээр дулаанаа шийдэж нүүрснээс татгалзах нөхцлийг бүрдүүлнэ.

85. Гэр хороололд цахилгаан ашиглан халаалтын асуудлаа шийдсэн айл өрхийн цахилгааны төлбөрийн асуудлыг үе шаттайгаар шийднэ.

86. АХБ-ны санхүүжилтээр боловсруулсан гэр хорооллын хөгжлийн стратегийн бодлогын бичиг баримтыг хэрэгжүүлж, дулааны алдагдалгүй орон сууц байшин барих ажлыг урамшуулан дэмжиж, утаа бууруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

87. Улаанбаатар хотод бүсчлэл тогтооно. Гэр хороололд сайжруулсан нүүрсийг хориглож цахилгаан, сэргээгдэх эрчим хүчээр халаах шинэлэг технологийг нэвтрүүлнэ.

88. Гэр хороололд айл өрхийн халаалтыг шийдвэрлэх нарны эрчим хүчээр халаах тоног төхөөрөмжийг нэвтрүүлж буй иргэн, аж ахуйн нэгжийг гаалийн татвараас чөлөөлж жил бүр урамшуулал олгоно.

89. Гэр хорооллын гудамжны бохирдлыг байхгүй болгож үерийн болон гудамжны ус зайлуулах шугамыг хийж хэрэгжүүлнэ.

90. Байгальд ээлтэй барилга барих арга технологиудыг дэмжинэ. (утаа ялгаруулдаггүй барилга)

91. Хотын дүүрэг болгонд агаарын чанарыг тухайн байршилд нь шалгах төхөөрөмж байршуулж, ард иргэдийг хувийн унаанаас татгалзахад нөлөөлнө.

**4.2 Цэвэрхэн, хоггүй, хашаандаа модтой гэр хороолол**

Улаанбаатар хотын хүн амын хурдацтай өсөлт нь хог хаягдлын хэмжээг нэмэгдүүлж, одоо байгаа хог хаягдлын менежментийн дэд бүтцэд дарамт учруулж

Улаанбаатар хотын хүн амын хурдацтай өсөлт нь хог хаягдлын хэмжээг нэмэгдүүлж, одоо байгаа хог хаягдлын менежментийн дэд бүтцэд дарамт учруулж байна. Дэд бүтцийн хүртээмжгүй байдлаас шалтгаалан хог хаягдлыг цуглуулах байршлууд, тээвэрлэлтийн хүртээмж, устгах байгууламжууд дутагдалтай байна. Тиймээс нийтийн орон зайд хог хаягдлыг хуримтлуулах, хууль бус хог хаягдлыг нэмэгдүүлах, хог хаягдлыг зохисгүй хаях, ил шатааснаас агаар, хөрс, усны бохирдолыг нэмэгдүүлсээр байна. Энэ нь хүн амын эрүүл мэндэд эрсдэл учруулж, байгаль орчныг доройтуулж байна

Улаанбаатар хот жилдээ 1,5 сая тонн хог хаягдал ялгаруулдаг тооцоо бий. Иймээс хог хаягдлын менежментийг боловсруулж асуудлыг шийдвэрлэхэд дараах арга хэмжүүнүүдийг авах шаардлагатай.

Үүнд:

92. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин боловсруулах ажлыг зохион байгуулж, иргэдтэй хамтран ажиллана
93. Иргэдийг хашаандаа хогоо энгийн, бордооны, дахин боловсруулах, болон үнсний хог гэх мэт ангилан хаяхыг дадал болгоно.
94. Иргэдийн ангилсан хогийг тодорхой хуваарийн дагуу очиж тээвэрлэх
95. Хог хаягдлын тээвэрлэлтийн нэмэгдүүлж, хогийг ил задгай хаяхгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.
96. Төвлөрсөн хогийн цэгүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлж, хогийг ангилан хаях хөтөлбөрийг боловсруулж, мөрдүүлнэ.
97. Хотын хэмжээнд хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх ажиллагааг сайжруулахын тулд тогтолцооны өөрчлөлтийг хийнэ.
98. Гэр хороололыг ногоон байгууламжтай болгох ажлын хүрээнд хашаандаа мод тарья их хөдөлгөөнийг өрнүүлж гэр хорооллыг ногоон хороолол болгоно.
99. Дээврийн борооны усыг нөөцөлж, усалгааны энгийн системийг ашиглах аргыг боловсруулж иргэдийг мэдээллээр хангаж дэмжиж ажиллана.
100. Хашаандаа хүлэмжийн аж ахуй эрхэлж мод үржүүлгийн аж ахуй эрхэлж орлого олох ажлыг дэмжинэ.

# ТАВ. ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ УЛААНБААТАР

**5.1 Түгжрэлгүй хот:**

Түгжрэлийг бүрдүүлэгч бүхий л хүчин зүйлсүүдийг зөв зохион байгуулалтад оруулах "Түгжрэлийн менежмент" цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Эдгээр нь Улаанбаатар хотын тэлэлт, төмөр замын тээвэр, масс тээвэр, нийтийн тээвэр болох автобус, таксины үйлчилгээ, авто зам, гудамж зам, дугуйн зам, аюулгүй байдал, хувийн тээвэр, терминал ложистик болон зорчигчдын зорчилтын оновчтой тогтолцоог хэрэгжүүлэх бодлого, шийдлүүдээс бүрдэнэ.

Улаанбаатар хотын тэлэлт

101. Улаанбаатар хотыг TOD концепциор тэлж хөгжүүлэх ба "Нэг бүс - Нэг хот" үзэл баримтлалаар хөгжүүлнэ.
102. Улаанбаатар хотын төвийн бүсэд автомашины хэрэглээг сааруулах бүс болгох зорилтын хүрээнд нийт 9.6км 3 шугамын багтаамж ихтэй нийтийн тээврийн хэрэгсэл LRT барьж байгуулна.
103. Хотын төвийн зургаан дүүргийг эмх цэгцтэй, зөв зохион байгуулалттай хөгжүүлэх боломжийг үүсгэнэ.
104. Хотын хэт төвлөрлийг задалж, дагуул хаяа хотуудад төрийн байгууллагууд, томоохон зах худалдаа үйлчилгээний төвүүд, их дээд сургуулиудыг салбар, чиглэл бүрээр нь тархаан байршуулах ажлыг эхлүүлнэ.
105. Налайхыг үйлдвэр технологиор, Майдарыг соёл урлагаар, Зуунмодыг наадам спортоор, Хөшигийн хөндийг боомт ЖДҮ хөгжүүлэх инноваци технологиор гэх мэтээр өөр өөрийн онцлогт тохируулж хөгжүүлнэ.
106. Хотын дэд бүтэц, эрчим хүч, төмөр зам, авто замын томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг нэн даруй эхлүүлнэ.

Масс тээвэр

107. Масс тээвэр ашиглалтад орсноос хойш бага багаар зорчигч нэмэгддэг тул ямар масс тээврийн аль чиглэлийн шугамыг эхэлж барихыг нарийн судлана.
108. Улаанбаатар хотын нийтийн тээврийн салбарт бүрэн шинэчлэл хийж, MRT, LRT, BRT зэрэг олон сонголттой тээврийн хэрэгслүүдийг хот төлөвлөлт, нийтийн тээврийн нягт уялдаатай байдлаар хөгжүүлэх үндсийг тавина.

Нийтийн тээвэр автобус, такси

109. Нийтийн тээврийг онцгойлон анхаарч, бодлогоор хөгжүүлнэ.
110. Бодит нөхцөл байдалд өглөө, оройн ачааллтай үед автобусны хүрэлцээ муу, зорчигчид багтдаггүй, чиглэл ойлгомжгүй, жолооч нар давхих, бууж суухад төвөгтэй, тав тухгүй гээд олон асуудалтай голчлон хотын төвөөр явж гэр хороололд төдийлөн хүрч очдоггүй байдлыг даруй анхааран ажиллах болно.
111. Зөвхөн "Энхтайваны" өргөн чөлөөнд бус нийтийн тээвэр давуу зорчих 10 гудамж замыг холбоно.
112. Их, бага, дунд багтаамжийн автобустай болгон парк шинэчлэлтийг тухай бүрт хийж тухтай, шуурхай зорчуулдаг болгоно.

113. Нийт зорчилт эргэлтийн 80 хүртэлх хувийг нийтийн тээврээр гүйцэтгэх тогтолцоог бий болгох ба цагийн хуваарийн дагуу зорчуулах, автобусны буудал, үйлчилгээний соёл, мэдээлэл, чанар хүртээмжийг дээшлүүлэх менежментийг хэрэгжүүлнэ.

114. Такси үйлчилгээ эрхэлж буй компаниудыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах ажлыг төрийн бодлогоор дэмжинэ.

Авто зам

115. Улаанбаатар хотын авто замын мастер төлөвлөгөөг шинэчилэн баталж гол артер замуудыг нэн даруй бий болгоно.

116. Одоо байгаа хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөн сайжруулах ба гэр хорооллын гол гудамж замыг өргөтгөн, хатуу хучилттай болгох ба гүүр, гарц, далан барих ажлуудыг үе шаттай хийж хэрэгжүүлнэ.

117. Хотын гол, туслах, хороолол доторх авто замыг нэг стандартад оруулан аюулгүй байдлыг хангаж, замын алдааг засна.

118. Туулын эргийн дагуух нэгдүгээр зэргийн замыг барьж байгуулна.

Гудамж зам

119. Хотын явган хүний зам хүртээмжтэй биш ба эвдрэлтэй явган алхахад хүндрэлтэй байдаг бөгөөд өвлийн улиралд халтиргаа ихтэй, зуны улиралд усанд автдаг тул нэг стандартад нийцүүлэн янзалж явган зорчигчийн замыг шинэчилнэ.

120. Явган зорчигчийн зам нарийн, бордюр нь хэт өндөр, алхахад шон, шат, хашаа их таардаг, хог шороотой, машин явахдаа шавхай цацдаг байдлыг нэг бүрчлэн янзалж гудамж замын төлөвлөлтийг цогцоор нь/гэрэлтүүлэг, хөтөч хавтан, туузан хашлага, ус зайлуулагч, ногоон байгууламжтай гэх зэргээр/ бий болгох ажлыг хийнэ.

121. Алхахад саад болж буй хайс, хашааг чөлөөлөн, аюулгүй зорчуулах ба явган зорчигчидод зориулсан гүүрэн болон нүхэн гарцыг ихээр байгуулж хүүхдийн тэрэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэд зорчиход саадгүй болгоно.

122. Иргэдийн хүслийн замын хэрэгцээ шаардлагад нийцүүлж явган алхахад зориулагдсан шинэ амралт зугаалгын бүс ихээр байгуулах бөгөөд зарим гудамжуудыг явган хүнд зориулагдсан, автомашингүй гудамж болгон тохижуулан нийтийн эзэмшлийн ашигтай талбайг хотын бүх газарт хүртээмжтэйгээр нэмэгдүүлнэ.

Дугуйн зам

123. Хотын дугуйн замууд нь хоорондоо холбогддоггүй ба ихэнхидээ явган зорчигчийн замаас хагасалж хийсэн болохоор иргэдийн дунд скүүтер, дугуйн ослууд их гарч байгаа тул үүнийг нэн яаралтай шийдвэрлэнэ. (дугуйн замыг гүүр болон бусад байгууламжаар хийх)

124. Дугуйн замыг явган хүний замаас тусад нь төлөвлөх бөгөөд дугуйн замуудыг хооронд нь бүрэн холбож, замын хөдөлгөөнд хэрхэн аюулгүй зөв оролцох талаар дүрэм журмыг боловсруулан, мөрдүүлнэ.

125. Хотод хэвтээ болон босоо тэнхлэг дагуу гүйхэд, скүүтэр болон дугуй унахад зориулсан дугуйн өргөн чөлөө бүхий тууш замуудыг байгуулах ба дугуйг зөвхөн хобби байдлаар биш нийтийн хэрэглээ болгох талаар ажлуудыг хэрэгжүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ
НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО
9023041590
УЛААНБААТАР ХОТ
1117145633
УХА0612 3077278

126. Дугуйн замыг стандартын дагуу тохижилт, гэрэлтүүлэгтэйгээр тохижуулах ба түрээсийн дугуйн болон скүүтерийн бизнес санаачилгыг бүрэн дэмжиж, дугуйн зогсоолын дэд бүтцийг өргөжүүлэн, дугуйн бүртгэлийн ажлыг эхлүүлэн хэрэгжүүлнэ.

Аюулгүй байдал

127. Хүүхдүүдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор зорчих хэсгийн гарц, гэрлэн дохио, тэмдэг тэмдэглэл, хурд сааруулагч, туузан хашлага, хяналтын камертай болгож хотхон, хороолол доторх аюулгүй байдлыг сайжруулна.

128. Тээврийн хэрэгслээс үүдэлтэй агаар орчны бохирдлын хяналтыг сайжруулж, дуу чимээний бохирдлыг үүсгэгч чанга дуу чимээтэй автомашин, мотоцикл, тээврийн хэрэгслийг дууны зохицуулалттайгаар тодорхой гудамж замуудад замын хөдөлгөөнд оролцуулах буюу цагийн хуваарийн дагуу дууны хязгаарлалттай замын хөдөлгөөнд оролцуулан шийднэ.

Терминал ложистик

129. Нэгдсэн тээвэр, түгээлт хийдэг компани байдаггүй тул байгууллага бүр тус тусдаа тээвэрлэлт гүйцэтгэдэг тул нэгдсэн тээвэр түгээлт хийдэг тогтолцоог бий болгох үүднээс ачаа тээврийн нэгдсэн хоршоо, зохион байгуулалтыг дэмжинэ.

130. Ачаа тээшийг олон дамжсан тээврээр гүйцэтгэдэг байдлыг цэгцэлж нэг дамжлагыг хасах терминал ложистикийн нэгдсэн төвүүд барих ажлыг бодлогоор дэмжиж терминал дагуух худалдаа, тээвэрлэлтийг зохион байгуулна.

## 5.2 Агаарын бохирдол

Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн хүйтэн хотуудын нэг бөгөөд дулааны үйлдвэрлэлийн гол эх үүсвэр нь нүүрс юм. Хүйтний улиралд гэр хорооллоос үүдэлтэй агаарын бохирдол нь 60% байдаг.

АРДЧИЛСАН НАМЫН
9023041590
8488916 ХТО7584
УЛААНБААТАР ХОТ

131. Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр өгөөжтэй, аюулгүй ажиллагааг бүрэн хангасан шинэ технологийн халаалт, дэд бүтцийн системийг нэвтрүүлнэ.

132. Сэргээгдэх эрчим хүч, шинэ технологийн инновацыг дэмжиж ажиллана.

133. Нарны эрчим хүчийг хуураадаг панелин дээвэр болон эрчим хүч нөөцлөгч батарейн импортыг татварын бодлогоор дэмжинэ.

134. Агаарын бохирдол ихтэй гэр хорооллын хэсэгт оршин суудаг төлбөрийн чадамжгүй иргэдийн дулааныг сэргээгдэх эрчим хүчээр шийдэх шийдлүүдэд татаас болон санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

135. Цахилгаанаар халаалтаа шийдэх технологиудыг сонгон худалдан авалт хийсэн иргэн, ААН-үүдэд татварын урамшууллын системийг бий болгох, урт хугацаатай зээл авах эдийн засгийн боломжит нөхцлийг бүрдүүлнэ.

136. “Утаагүй Улаанбаатар” аяныг өрнүүлж, нүүрснээс татгалзаж, сэргээгдэх эрчим хүчээр халаалтаа шийдсэнээр гарах үр өгөөжийг нийтэд таниулах, арга технологиудыг танилцуулах төсөл хэрэгжүүлнэ.

137. Төвийн шугамд холбогдоогүй хэсгүүдэд нэгдсэн судалгааг хийж, үе шаттайгаар төвийн шугамд холбоно.

138. Цахилгаан хөдөлгүүрт автомашины ашиглалтыг дэмжих зорилгоор дугаарын хязгаарлалтаас чөлөөлж, 15-аас дээш жил явсан дизель хөдөлгүүрт автомашинуудыг хотын (төв) бага тойруу руу явахыг үе шаттайгаар багасгана.
139. Улаанбаатар хотод цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх 20 цэг байгуулна.
140. Цахилгаан тээврийн хэрэгслийн импортыг татварын бодлогоор дэмжинэ.

### 5.3 Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй хот

**Иргэдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:**

141. Хэв журам сахиулах, гэмт хэрэг ба захиргааны зөрчилтэй тэмцэх ажлыг хотын удирдлагатай хамтарч шууд хариуцна.
142. Аливаа барилга байгууламж, гудамжинд нийтийн гарцтай, хүүхдийн тоглоомын талбай, иргэдийн амралтын талбайтай байх шаардлагыг хатуу мөрдүүлнэ.
143. Тусгай зориулалтын зам, шат, хаалга, бие засах газрууд байгуулах ажлыг дэмжиж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй хот болгоно.
144. Сургууль, цэцэрлэгийн орчинд авто замын хурд сааруулагчийг суурилуулна.
145. Иргэдийг байгалийн гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор гамшгийн үед байрлах, хоргодох цэгүүдийг тогтоож, онцгой байдлын алба саадгүй хүрч ажиллах орчинг бий болгоно.
146. Нөхөн сэргээх шаардлагатай хөрсний элэгдэл, эвдрэлд орсон газруудыг ТББ, иргэдийн оролцоотой нөхөн сэргээж, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.
147. Иргэдийн нөхөрлөлийг дэмжиж, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх тухай бүхий л санаачлагыг дэмжиж ажиллана.
148. Тоосжилтыг бууруулах чиглэлээр тогтмол арга хэмжээ авч ажиллана.
149. Хуучин барилга байгууламжийн насжилтын судалгаа гаргаж, барилгын хийцийг хүчитгэх, дулаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дахин төлөвлөх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Хуучин орон сууцны гадна фасад, дээврийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
150. Улс, нийслэлийн төсвийн дэмжлэгтэйгээр гэр болон орон сууцны хорооллын дунд шинээр зам барих, зам засварын ажлыг эрчимжүүлж ажиллана.
151. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусдын адил бизнес эрхлэх, сурч, хөдөлмөрлөх, бие даан амьдрахад нь туслах, сэргээн засах, нийгмийн харилцаанд ороход туслан дэмжих зэргээр тэдний хэрэгцээнд нийцсэн олон талт мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.
152. Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах, нийгмийн үр дүнтэй оролцоог дэмжих, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
153. Хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагчдыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
154. Тусгай хэрэгцээт (хөгжлийн бэрхшээлтэй) иргэдтэй ажиллах мэргэжилтэн, дохионы хэлний орчуулагч, тусгай сургуулийн багш, мэргэжилтнүүдийг бэлтгэх төлөвлөгөөт арга хэмжээ авч, нийгмийн баталгааг нь эрс дээшлүүлнэ.

155. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан сэргээн засах, хөгжлийн цогцолбор төвүүдийг нийслэл, орон нутагт байгуулна.

156. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг нэмэгдүүлсэн үйлчилгээнд хөнгөлөлт, дэмжлэг үзүүлдэг болно.

157. Эмнэлгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дэд бүтэц, орчин бий болгоно.

158. Үйлчилгээний газар, шинээр баригдаж байгаа барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог хөгжлийн бэрхшээлтэй хүн чөлөөтэй зорчих олон улсын стандартын шаардлагад нийцүүлж өөрчилнө.

159. Ахмадын асрамжийн төвлөрсөн үйлчилгээг төрөлжүүлж, одоо байгаа асрамжийн үйлчилгээний үнэ тарифыг үе шаттай нэмэгдүүлнэ.

160. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар алслагдсан бүс нутагт дутагдалтай мэргэжилтнүүдийг бүрдүүлэх "Ахмад мэргэжилтний алба" ажиллуулах санаачилга, хөдөлгөөн өрнүүлнэ.

161. Ахмадын коллеж, сургалтын төв байгуулж, дахин ур чадваржуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

162. Ахмад настанд зориулсан сэргээн засах, эмчилгээ, сувилгааны цогцолбор төвүүдийг нийслэл, дүүргүүдэд байгуулж, хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

163. Өрх толгойлсон эх, эсвэл эцэгт хүүхдийг эрсдэлээс хамгаалах зорилгоор эргэн төлөгдөх нөхцөл бүхий тэтгэлэг олгох тогтолцоо, богиносгосон ажлын цагийн хуваарийг мөрдөх боломж бүрдүүлнэ.

164. Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих бодлогын хүрээнд хүүхдээ асран хамгаалж байгаа 3 хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хүүхдээ өсгөсөн жилийн үнэлэмжийг шинэчлэн тогтооно.

**5.4 Эрүүл мэнд, боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр**

165. Нийслэлийн иргэд харьяалал харгалзахгүйгээр бусад дүүргийн эмнэлгээс эрүүл мэндийн үйлчилгээг авдаг болгоно.

166. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох дэд бүтцийг бий болгоход онцгойлон анхаарна

167. Улаанбаатар хотын дүүрэг бүрд бага насны хүүхэд 500 метрийн радиус дотор цэцэрлэг сургуульдаа хүрэх боломжтойгоор хотын ерөнхий төлөвлөгөөнд тусгасны дагуу цэцэрлэг сургуулийг нэмж барин хүртээмжийг жигд болгоно.

168. Эмч багш нарын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулдаг индексийн урамшууллыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

169. Төрийн бус өмчийн сургууль болон алслагдсан сургуулиудад автобус ажиллуулж, хүүхдийн сургуульдаа аюулгүй ирж, очих нөхцөлийг бүрдүүлнэ.

НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО
УЛААНБААТАР ХОТ

1117145633
УХА0612 9077278

170. Ерөнхий Боловсролын Сургуулиудыг Цогцолбор сургуулийн бүтцээр ажиллуулж менежментийг нь сайжруулахыг дэмжинэ.

171. Нийслэлийн бух хороонд цэцэрлэг сургуультай болно.

172. Сургууль бүрийг 2-оос дээшгүй ээлжээр хичээллэдэг болгоно.

173. ЕБС-ын үндсэн хичээлээс гадна сурагчдын оюун ухаан, бүтээлч чадварыг хегжүүлэх, мэдээллийн технологийн орчин үеийн мэдлэг олгох зорилгоор хиймэл оюун ухааны, кодчилол, роботчлолын паборатори, эд юмсын интернет гэх мэт хичээл сургалтыг нэмэлтээр ордог болгоно.

174. Хороо бүрд урьдчилсан сэргийлэх эмч ажиллуулж, иргэдийн эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, эрүүл мэнд, биеийн тамирын өрөв, талбайг тохижуулж, спортоор хичээллэх боломжийг бий болгоно.

**5.5 Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар, соёл, урлагийн байгууламжуудыг хамгаалах чиглэлээр:**

175. Хот, суурин газрын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн үйлчилгээ гэрт ойр байх, хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээнд нийцсэн стандартыг хэрэгжүүлнэ.

176. Хотын дүүрэг болон захын хэсэгт ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгүүдийг нэмэгдүүлнэ.

177. Явган хүний болон дугуйн замын системийг хөгжүүлэх, ногоон байгууламжтай хослуулна.

178. Хотын соёлын өв, соёлын дурсгалт барилгуудыг нураахгүйгээр арчлах, сэргээн засварлах ажлыг шат дараалалтай хийнэ.

179. Соёлын өвийг хамгаалах төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж, хотын аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлнэ.

180. Номын сан, музей, соёлын төвүүдийг өргөжүүлж, оршин суугчдын соёлын хэрэгцээг хангана.

181. Дүүрэг бүрд иргэдийн амрах, зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн тоглоомын талбай, боловсон бие засах газар бүхий цэгүүд байгуулна.

182. Спортын байгууламж, заал талбайг спортын төрөл төрлөөр олшруулж, менежментийг нь спортын холбоод, клубүүдэд, хариуцан хамтарч ажиллах, клубүүдийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

183. Газрын нэгдсэн үзлэг зохион байгуулж, ашиглалт, эзэмшлийн зөрчилтэй газруудыг эргүүлэн авч, нийтийн зориулалттай ногоон байгууламж амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх газруудыг байгуулна.

184. Зуслангийн газрыг өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ
НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7584

185. Залуучуудын хөгжлийн "Community center" байгуулж, чөлөөт цагаа өнгөрөөх, хамтдаа хөгжих, суралцах орчныг бүрдүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ
НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7584
УЛААНБААТАР ХОТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 917

танай ____________-ны №____________-т

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох

байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Баянгол дүүргийн Ардчилсан намын хорооны Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дах хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянгол дүүргийн Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр /.6. хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Баянгол дүүргийн Сонгуулийн хороонд.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

# БАЯНГОЛ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН 2024 ОНЫ ОРОН НУТГИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ “БАЯНГОЛ 100” МӨРИЙН ХӨТӨЛБӨР

## Гэр бүл

1. “Өрх бүр баялаг бүтээгч” үндэсний хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ.
2. Гэр бүлийн гишүүн бүрт гэр бүлийн боловсрол олгох “Монгол гэр бүл” боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ.
3. Ажил, хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ өргөжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах мэдлэг, ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
4. Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих бодлогын хүрээнд хүүхдээ асран хамгаалж байгаа 3 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийг дэмжиж ажиллана.
5. Хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
6. Түрээсийн орон сууц хөтөлбөрийг Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ.
7. Залуу гэр бүл, гэр хорооллын айл өрхүүд, бусад зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн “тохилог орон сууц” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
8. Хүний хөгжлийн төвийг хороо бүрт байгуулна.

## Хүүхэд

9. Өрх, хороонд үзүүлэх 0-5 насны хүүхдийн тусламж, үйлчилгээг чанаржуулах, хүртээмжийг сайжруулах, хөхөөр хооллолтыг дэмжих “Эрүүл, чийрэг хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
10. Хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран, тогтмол хэрэгжүүлнэ.
11. Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, тэдний санаа бодлыг мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд тусгах зорилгоор насны онцлогт тохирсон нийгмийн үйл ажиллагаанд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх боломжийг дэмжинэ.
12. Хүүхдэд тулгарч буй дээрэлхэх, үе тэнгийнхэний дарамт, шахалт болон эрүүл мэнд, сэтгэцийн бусад сорилт, бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлнэ.
13. Хүүхдийг цахим дарамт, мөлжлөг, зохисгүй контент зэрэг цахим гэмт хэрэг, аюулаас хамгаалах үйл ажиллагаа, оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулна.
14. Хүүхдэд ээлтэй амьдрах орчны стандартуудыг баталж, мөрдүүлнэ.
15. Баянгол хүүхдийн зуслангийн өргөтгөлийн барилгын угсралтын ажлыг хийж, байнгын ашиглалтад оруулна.

## Оюутан, Залуучууд

16. Залуучуудын хөгжлийн “Community center” байгуулж, чөлөөт цагаа өнгөрөөх, хамтдаа хөгжих, суралцах орчныг бүрдүүлнэ.
17. Монголын цахиурын хөндий буюу технологийн шийдэл ашиглаж, нийгэмд тулгамдсан хэрэгцээ, шаардлагыг шийдвэрлэж буй хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдийг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ

АРДЧИЛСАН НАМ
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
УЛААНБААТАР ХОТ

85

18. Оюутныг сургалтын зээлд хамруулах ажлыг дэмжинэ.
19. Оюутан, сурагчид зайнаас дэлхийн шилдэг сургуулиудад сонгосон мэргэжлээрээ суралцахад дэмжинэ.
20. Иргэд ажиллангаа суралцах, суралцангаа хөдөлмөр эрхлэх хөтөлбөр хэрэгжүүлж, 7 хоногийн цалингийн системийн зарчмаар төгсөгчдийг өөрөө өөртөө ажлын байр бий болгох, бизнес эрхлэх боломжийг бүрдүүлнэ.
21. Дэлхийн томоохон их сургуулийн хөтөлбөрөөр академик англи хэлийг богино хугацаанд эрчимтэй сургах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
22. Гадаад улсын их, дээд сургуульд суралцах оюутны тоог үе шаттай нэмэгдүүлэх ажилд дэмжлэг үзүүлнэ.

## Ахмадууд

23. Ахмадын сургалтын төв байгуулж, дахин ур чадваржуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
24. Ахмадын эрүүл мэндийн тогтолцоог сайжруулна.
25. Ахмад настанд зориулсан сэргээн засах, эмчилгээ, сувилгааны цогцолбор байгуулж, хувийн хэвшилтэй хамтран ажиллана.
26. Ахмадын түрээсийн орон сууц хөтөлбөрийг Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ.

## Тусгай хэрэгцээт хүмүүс

27. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн бусдын адил бизнес эрхлэх, сурч, хөдөлмөрлөх, бие даан амьдрахад нь туслах, сэргээн засах, нийгмийн харилцаанд ороход туслан дэмжих зэргээр тэдний хэрэгцээнд нийцсэн олон талт мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.
28. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн асран хамгаалагчдыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
29. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан сэргээн засах, хөгжлийн цогцолбор төвийг байгуулна.
30. Үйлчилгээний газар, шинээр баригдаж байгаа барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог хөгжлийн бэрхшээлтэй хүн чөлөөтэй зорчих олон улсын стандартын шаардлагад нийцүүлж өөрчилнө.
31. Хөгжлийн бэрхшээлтэй хүн тогтмол орлого олох хөтөлбөр хэрэгжүүлнэ.
32. Бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, хүүхэд бүрт тохирох шаардлагатай сэргээн засах хөгжлийн үйлчилгээ үзүүлдэг болно.
33. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан түрээсийн орон сууц хөтөлбөрийг Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ.

## Нийгмийн бодлого

34. Бүх шатны төрийн албан хаагчдыг эрхэлдэг ажлынхаа чиглэлээр сурч боловсрохыг дэмжиж ажиллана.
35. Багш нарын хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
36. Төрийн албанаас эрт тэтгэвэрт гарч буй иргэд жижиг, дунд, бичил бизнесийн салбарт ажиллах, баялаг бүтээх боломжийг бүрдүүлнэ.
37. Бага орлоготой, ядуу өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг хөдөлмөрт бэлтгэх, ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөрт хамруулах, ажлын байранд зуучлах тогтолцоог бүрдүүлнэ.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ... ХОРОО
УЛААНБААТАР ХОТ

38. Бага орлоготой, ядуу айл өрхүүдэд зориулсан хүнсний хангамжийн хөтөлбөр хэрэгжүүлж, шим тэжээлийн дутагдлаас хамгаална.

## Эрүүл мэнд

39. Сэргийлж болох болон амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчлөл, нас баралтыг бууруулж, урьдчилан сэргийлнэ.
40. Агаарын бохирдлоос үүдэлтэй амьсгалын замын халдварт өвчнийг бууруулна.
41. Хуурамч, чанаргүй хүнсний бүтээгдэхүүний хяналтын тогтолцоог сайжруулна.
42. Бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, эрүүл аж төрөх дадлыг хэвшүүлнэ.
43. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх шинэ хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
44. Яаралтай, түргэн тусламжийн үйлчилгээг тэлж, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шилжүүлэх замаар иргэдэд ойр болгоно.
45. Нас баралтыг бууруулах зорилгоор жендэрт суурилсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үйл ажиллагааг өргөжүүлнэ.
46. Өрхийн эрүүл мэндийн төвд ажиллах эмчийг бодлогоор дэмжиж, тоог нэмэгдүүлнэ.
47. Эрүүл мэндийн салбарыг бүрэн цахимжуулж, мэдээллийн нууцлал, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг холбогдох төрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

## Боловсрол

48. Цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй байх стандартийг үе шаттай хэрэгжүүлнэ.
49. Цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг үе шаттай нэмэгдүүлж, сургууль, цэцэрлэггүй хороодын тоог бууруулна.
50. Цахим шилжилтийг бүрэн хэрэгжүүлж, боловсролын сургалтын байгууллагууд сургалтыг танхим ба цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулах боломжийг бүрдүүлнэ.
51. Нийгмийн хариуцлагын хүрээнд "Хүүхэд бүрт компьютер" хөтөлбөр хэрэгжүүлэх санал, санаачилгыг дэмжинэ.
52. Хичээлээс гадуурх сургалт, дугуйлангийн хамрагдалтыг 75 хувьд хүргэж, суралцагчийн сонирхол, чадварыг нээн хөгжүүлэх сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг өргөтгөнө.
53. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг 50 хувиар бууруулна.
54. Эко сургуулийн үйл ажиллагааг хэвийн явуулж, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулна.
55. Багшийн ажлыг хөнгөвчлөх зорилгоор боловсролын салбарт хиймэл оюун ухааныг нэвтрүүлж, гэрийн даалгавар болон үнэлгээг бүрэн автоматжуулна.

## Гадаад суугаа Монголчууд

56. Гадаадад суралцаж, ажиллаж байгаа болон эх орондоо эргэн ирж байгаа залуучуудад зориулсан хөтөлбөр хэрэгжүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
УЛААНБААТАР ХОТ

57. Гадаадад ажиллаж байгаа иргэдийн мэргэшсэн байдлыг харгалзан өөрийн туршлага, шинэ мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг дүүрэгтээ нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

## Бизнес, хөдөлмөр эрхлэлт

58. Баялаг бүтээгчдээ дэмжиж, монгол хүний орлогыг нэмэгдүүлнэ.
59. Дүүрэгт бизнес хөгжүүлэх төвөөр дамжуулан бизнес эрхлэгчдийг дэмжинэ.
60. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх бизнес, төсөл, арга хэмжээний жагсаалтыг шинэчилж, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, нийгмийн зорилтот бүлгийг харгалзан үздэг зарчмыг дэмжиж ажиллана.
61. Старт-ап бизнес эрхлэгчдийг урамшуулах, бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, мэдээллийн технологийн үйлчилгээний экспортыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
62. Ажилгүйдлийн түвшинг 5 хувиас бага түвшинд байлгах хөдөлмөр эрхлэлтийн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
63. Цагаар ажиллах, гэрээр ажиллах, зайнаас ажиллуулах, сүлжээний маркетинг бүхий бараа, үйлчилгээний борлуулалт хийх зэрэг хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэрийг дэмжих замаар эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
64. Гэр хороололд ахуй үйлчилгээний төвүүдийг байгуулж, жижиг, өрхийн бизнес эрхлэгчдийг дэмжинэ.

## Байгаль орчин

65. Ус, агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
66. Хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн эко төлбөрийн эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.
67. Иргэдийн мод тарих санаачилгыг дэмжиж, бүртгэлийг цахимжуулан нийгмийн хөнгөлөлт эдлэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.
68. Орчноо ногооруулсан иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бий болгоно.
69. "Ногоон байгууламж" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
70. Агро паркын үйл ажиллагааг жигдрүүлж, улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар тохижилт, ногоон байгууламжийг хийж гүйцэтгэнэ.
71. “Шинэ өргөө” тохижилт, үйлчилгээний компаний хүчин чадлыг хоёр дахин нэмэгдүүлж, хог ангилан хаядаг тогтолцоог нэвтрүүлнэ.

## Хууль ба шударга ес

72. Өмчийн эрхийг баталгаажуулж, хувийн өмчийг хамгаалахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
73. Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
74. Газар олгох, ашиглах, эзэмших, өмчлөх үйл ажиллагааг ил тод болгоно.
75. Хүний заяагдмал эрхийг хамгаалах, иргэдэд хүний эрхийн талаар ойлголт өгөх, сурталчлан таниулах үйл ажиллагааг дэмжинэ.
76. Олон нийтийн сүлжээнд иргэний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тогтоохгүй байх төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

## Цахим төрийн үйлчилгээ

77. Иргэн, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ.
78. Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, нэгтгэх замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.
79. Төрийн байгууллага, удирдах албан тушаалтан жил бүр иргэдэд нээлттэй, ил тод ажлын тайлангийн сонсгол хийдэг болно.
80. Цахим өргөдөл, гомдлын “18001222” төвийн үйл ажиллагааг сайжруулна.
81. Төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох хөтөлбөрийг холбогдох төрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
82. Хорооны цогцолбор байргүй хороодод шинээр хорооны цогцолбор байрыг улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэнэ.

## Аюулгүй орчин

83. Дүүргийн эрсдэл бүхий газрууд, автобусны буудлуудыг камержуулж, цагдаагийн байгууллагатай шууд, хялбар байдлаар холбогдох тоноглол хийсэн “ногоон бүс” буюу аюулгүй бүс бий болгох ажлыг дэмжинэ.
84. Нийтийн эзэмшлийн зам, талбай дахь камержуулалтын ажлыг суурилуулах журам, эрх зүйн баримт бичгийг боловсруулахад хувь хүний нууцыг хадгалахтай холбоотой асуудлыг анхаарна.
85. Иргэний аюулгүй, эрүүл орчинд амьдрах эрхийг баталгаажуулах хүрээнд нийтийн орон сууц, сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжтай ойролцоо шатахуун түгээх станц болон хийн түлшний түгээгүүр байрлуулахыг хориглоно.
86. Дүүргийн гудамж, зам талбай, орон сууцны хороолол, гэр хороололд гэрэлтүүлгийг орчин үеийн шийдлээр иж бүрэн улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэнэ.

## Онцгой байдлын салбар

87. Гэр хорооллын гал унтраах ангийг шинээр байгуулна.
88. Онцгой байдлын алба хаагчдад нэн шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багж, хувцас хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулна.

## Түгжрэлийн шийдэл

89. Дүүргийн түгжрэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлж, тээврийн төлөвлөлтийг олон улсын жишигт хүргэнэ.
90. Сургуулийн хүүхдэд зориулсан тээврийн хүртээмж, менежментийг сайжруулна.
91. Авто замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, зогсоолын хүрэлцээг шийднэ.
92. Авто замын торлосон сүлжээ бодлогын хүрээнд “Гудамж” төслийг үргэлжлүүлэн авто зам, гүүр, гүүрэн гарц, хотхон, хорооллын орц, гарц, уулзваруудыг шинээр байгуулна.

## Барилга бүтээн байгуулалт

93. Хуучны орон сууцны дулааны алдагдлыг бууруулах бодлого хэрэгжүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
УЛААНБААТАР ХОТ

94. Зарим гудамжийг явган хүнд зориулсан худалдаа, үйлчилгээний “авто машингүй гудамж” болгоно..

95. Үерийн далан, дунд голын урсацын дагуу далан байгуулах, авто зам, дугуйн зам барих, орчны тохижилт бүхий бүтээн байгуулалтын ажлыг улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ.

96. Дүүргийн 34 хороо тус бүрт нэгдсэн иж бүрэн тоглоомын талбай байгуулж, хороодын явган зам, дугуйн замыг иж бүрэн шинэчлэх ажлыг улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар үе шаттай хэрэгжүүлнэ..

## Гэр хорооллын хөгжил

97. Баянгол дүүргийн гэр хорооллын инженерийн дэд бүтэц (цэвэр ус, бохир ус ариутгах татуурга, интернэтийн шилэн кабель)-д холбож, халаалтыг төвлөрсөн болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй амины орон сууц болгон хөгжүүлэх ажлыг улс нийслэл дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, амьдран суух байшингаа барихад урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлээр санхүүжүүлэх санал санаачлагыг холбогдох төрийн байгууллагад гаргана.

98. Гэр хороололд төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүдийг байгуулна.

99. Яндан, нүхэн жорлонг жилд 20-оос доошгүй хувиар бууруулах төсөл хэрэгжүүлнэ.

100. Гэр хорооллын дундах гудамжны өнгө төрхийг сайжруулан сэргээж, хайс, хашааг нэгдсэн байдлаар тохижуулна.

АРДЧИЛСАН НАМ
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
УЛААНБААТАР ХОТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 922

танай ____________-ны №______________-т

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
АРДЧИЛСАН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Баянзүрх дүүргийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Баянзүрх дүүргийн Ардчилсан намын Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дах хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянзүрх дүүргийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөр /22. хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Баянзүрх дүүргийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

АРДЧИЛСАН НАМ

# БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМ

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

# ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**ЗОРИЛТ:**
НЭГ. ИРГЭНДЭЭ ОЙРХОН БАЯНЗҮРХ
ХОЁР. НОГООН БОДЛОГОТОЙ БАЯНЗҮРХ
ГУРАВ. ДЭВШИЛТЭД ЭДИЙН ЗАСАГТАЙ БАЯНЗҮРХ
ДӨРӨВ. НЭЭЛТТЭЙ, ЦАХИМ БАЯНЗҮРХ
ТАВ. ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТТЭЙ БАЯНЗҮРХ
ЗУРГАА. ЭЕРЭГ ХАНДЛАГАТАЙ БАЯНЗҮРХ

## НЭГ. ИРГЭНДЭЭ ОЙРХОН БАЯНЗҮРХ

Эрүүл мэнд:

**1.1. Эрүүл амьдралын дадлыг хэвшүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, цахим эрүүл мэндийн үйлчилгээг өргөжүүлнэ.**

1.1.1. Иргэд, залуучуудад амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх чиглэлээр ААН, байгууллага, хамт олон, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж хамтран ажиллана.

1.1.2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулж өвчлөлийг бууруулна.

1.1.3. Товлолт дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдлыг бууруулна.

1.1.4. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанаржуулахад дэмжлэг үзүүлж ажиллана.

1.1.5. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, оношилгоог эрчимжүүлж, эмчилгээнд бүрэн хамруулах, эрүүлжүүлэх ажлыг сайжруулна.

1.1.6. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, нэр төрлийг нэмэгдүүлж, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулна.

1.1.7. Харъяа эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмжийн дутагдалыг арилгах, хуучирсан тоног төхөөрөмжийн шинэчлэлийг Дүүргийн ОНХСан, Олон Улсын байгууллагын тусламжтай хийж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

1.1.8. Цахим эрүүл мэнд, эрүүл мэндийн мэдээллийн нэгдмэл байдал, хэрэглээг нэмэгдүүлэх замаар иргэдийн төрөөс эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах үйл ажиллагааг хөнгөвчилнө.

1.1.9. Баянзүрх дүүрэгт Хүүхдийн нэгдсэн эмнэлэг байгуулна.

1.1.10. Хороодын өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй болон сэргээн засал хийх шаардлагатай иргэдэд зориулсан тоног төхөөрөмж бүхий чийрэгжүүлэлтийн өрөө, зорчих хэсгийн дэд бүтэц, орчинг сайжруулна.

1.1.11. Хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настнуудад гэрээр үзлэг оношилгоо, асаргаа сувилгаа хийдэг болгох тал дээр анхаарч, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Биеийн тамир, Спорт:

**1.2. Иргэдэд эрүүл амьдрах зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэх замаар нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.**

1.2.1. Нийтийн биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөнөөр хичээллэгч, эрүүл амьдралын хэв маягтай иргэдийг хөхүүлэн дэмжиж бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн чанарын түвшиний суурь үзүүлэлтийг нэмэгдүүлнэ.

1.2.2. Дүүргийн иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлж Олон Улсын Чанартай тэмцээн уралдаанд оролцох баг, тамирчдыг дэмжин ажиллана.

1.2.3. Иргэдийг нийтийн биеийн тамир, спорт, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх ажлыг эрчимжүүлж, дүүргийн хэмжээнд зохион байгуулах уралдаан, тэмцээний төрлийг нэмж, үйл ажиллагааг өргөжүүлэн зохион байгуулсанаар тамирчдын оролцоо өссөн байна.

1.2.4. Спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлж, арчилал хамгаалал, сайжруулалтын ажлуудыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.2.5. Олон Улс, Улс, Нийслэлийн чанартай спортын тэмцээн уралдаанд дүүргийн иргэдийг идэвхитэй хамруулж амжилттай оролцсон иргэдийг төр, хувийн хэвшлийн дэмжлэгтэй шагнан урамшуулж алдаршуулах ажлыг зохион байгуулна.

Боловсрол:

**1.3. Улс, нийслэл, дүүргийн төсөв, гадаадын болоод дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих замаар цэцэрлэг сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх, Боловсролын чанарыг нэмэгдүүлж хүүхэд, залуучуудын сурах хүсэл эрмэлзэл, авьяас, ур чадварыг нээн илэрүүлэх оролцооны клубуудыг нэмэгдүүлнэ.**

1.3.1. Боловсролын чанар, хүүхэд залуучуудыг чадавхижуулах инкубатор төв, клубуудыг нэмэгдүүлэн, сургууль бүрийн спорт урлагийн секц дугуйланг дэмжиж ажиллана.

1.3.2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхэд бүр суралцах тэгш боломжоор хангана.

1.3.3. Тодорхой шаардлага хангасан сургуулийг бага, дунд, ахлах сургууль болгон бие даасан хэлбэрээр төрөлжүүлэн хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

1.3.4. Сургууль, цэцэрлэггүй хороодод шинээр цэцэрлэг, сургууль барих төсөв зардлыг улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалт, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр шийдвэрлэж хотын ерөнхий төлөвлөгөөнд тусгуулан нэмж барьсанаар боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж бүх хороодыг цэцэрлэг, сургуультай болгоно.

1.3.5. Хороо бүрт сурагч, оюутан залууст зориулсан нийтийн интернэттэй оюуны чадавхи нэмэгдүүлэх сургалт, хөгжлийн төв бүхий номын санг байгуулна.

1.3.6. Сурагчидад сонирхол, авьяас чадвартаа тулгуурлан мэргэжлээ зөв сонгоход нь туслах зорилготой мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтуудыг тогтмол явуулна.

1.3.7. Дүүргийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн хүүхдүүдэд эх орноо хайрлах, хүрээлэн буй орчноо хамгаалах, уламжлалт зан заншил, хотын соёлтой иргэн болж төлөвших талаарх мэдлэг олгох чиглэлээр клуб ажиллуулах, зан үйлийн кабинет, булан байгуулна.

1.3.8. Хүүхэд залуучуудын байгаль орчноо хамгаалах үзлийг төлөвшүүлж, экологийн боловсролыг дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулж, байгальд ээлтэй сургууль, цэцэрлэгүүдийн тоог нэмэх бодлого хэрэгжүүлнэ.

1.3.9. Хүүхэд эрүүл аюулгүй суралцах орчинг бий болгох хүрээнд сургууль, цэцэрлэг орчмын гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагч, тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлж ажиллана.

1.3.10. ЕБС, СӨБ-ийн багш нарын мэргэжил, ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад, дотоодод туршлага солилцуулах ажлыг зохион байгуулна.

1.3.11. Хүүхдийн хөгжил, хамгааллын асуудлал, урлаг, спорт цогцоор нь шийдвэрлэх "Хөгжлийн төв"- барина.

1.3.12. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарыг ээлжтэй болгох замаар цэцэрлэгийн ажиллах цагийн зохицуулалтыг уян хатан болгож эцэг эхчүүдийг ажлаа тайван хийх боломжоор хангана.

1.3.13. Тэтгэвэрт гарсан ахмадууд болон 35-с дээш насны ажилгүй иргэд, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дүүргийн хөгжилд шаардлагатай мэргэжилээр дахин

мэргэшүүлэх сургалтад хамруулж ажлын байранд зуучлах хөтөлбөр гаргаж хэрэгжүүлнэ.

1.3.14. Алслагдсан хороодод МСҮТ байгуулах ажлыг бодлогоор дэмжих, төгсөгчдийг ажлын байраар хангахад аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллана.

1.3.15. Мэдээлэл холбоо, нано, биотехнологи, Ландшаф, Урбанист чиглэлээр суралцагч оюутан залуусын тоог нэмэгдүүлэх, гадаад улсын чиглэлийн их дээд сургууль, боловсролын байгууллагад солилцоогоор суралцагсадыг нэмэгдүүлэх, энэ чиглэлийн шинээр байгуулагдаж буй үйлдвэр аж ахуйн газрыг бодлогоор дэмжиж ажиллана.

1.3.16. Оюутан, залуучуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, ажил мэргэжлээрээ өсөх, боломжоо нээхэд нь дэмжлэг үзүүлэх, бие даан ажиллаж, амьдрах чадвартай иргэн хүн болоход нь чиглэгдсэн эрдэм шинжилгээ, урлаг, спорт, соёлын олон төрөлт арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

1.3.17. Ерөнхий боловсролоо амжилттай сайн төгсөгчдийг тэтгэлэгт хамруулах хөтөлбөр хэрэгжүүлэх болон сургалтын зээлд хамруулах боломжийг нэмэгдүүлнэ.

1.3.18. Хүмүүнлэгийн хөтөлбөр хэрэгжүүлж оюутан сурагчидаа хамруулсан боловсролын байгууллагуудыг бодлогоор дэмжинэ.

1.3.19. Сургууль бүрийг англи хэлний гадаад багштай болгох “Дэлхийд Гарцтай Баянзүрх” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.3.20. Оюутан, сурагчид зайнаас дэлхийн шилдэг их сургуулиудад сонгосон мэргэжлээрээ суралцах эрх зүйн орчин, техникийн болон санхүүгийн тогтолцоог бүрдүүлнэ.

1.3.21. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалтийг хүүхэд, залуучуудад тогтмол зохион байгуулна.

1.3.22. Нийгмийн хариуцлагын хүрээнд “Хүүхэд бүрд компьютер” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хувийн хэвшлийн дэмжлэгтэй зохион байгуулна.

1.3.23. Сургуулийн автобусны тоо хэмжээг нэмэгдүүлэх, дүүргийн хэмжээнд хүүхэд сургуульдаа аюулгүй ирж буцах нөхцлийг бүрдүүлнэ.

<u>Хөдөлмөр эрхлэлт, Нийгмийн бодлого:</u>

**1.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нэмэгдүүлэх чиглэлээр үйлдвэрлэл, старт-ап компуниудын үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ. Иргэдийг тэгш боломж, хүртээмжтэй байдлаар нийгмийн халамж, үйлчилгээг авах эрх зүйн боломжийг бүрдүүлнэ.**

1.4.1. Иргэдийг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гараны бизнесийг дэмжин, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ... ХОРОО
9023041596
8488916 ХТО 574
УЛААНБААТАР ХОТ

1.4.2. Өрхийн бизнесийг нэмэгдүүлэх, зорилтод бүлгийн иргэдийг ажлын байраар хангах, нэгдэн нийлж бизнес эрхлэх боломжоор хангаж буй иргэдийн нэгдэл, холбоо, ААН, байгууллагыг бодлогоор дэмжин ажиллана.

1.4.3. Оюутан, залуучуудыг цагаар хөдөлмөр эрхлэх, тэдний цагийн үнэлгээг сайжруулах боломж нөхцөлийг бүрдүүлэхээр хөдөлмөрийн бирж ажиллуулна.

1.4.4. Ажлын байрны үзэсгэлэн яармагийг цахимаар болон бусад хэлбэрээр тогтмол зохион байгуулж хэвшинэ.

1.4.5. Худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий тусгай бүс, төрөлжсөн байршлуудад үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах бичил, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжин ажлыг байрыг нэмэгдүүлнэ.

1.4.6. Дүүргийн хэмжээнд ажлын байр бий болгож буй аж ахуйн нэгж байгууллагуудад дэмжлэг үзүүлж, төр хувийн хэвжлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

1.4.7. Баянзүрх дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж буй МСҮТ-ийн үйл ажиллагааг сурталчилан таниулж, төгсөгчдийг ажил олгогчидтой холбоно.

<u>Гэр бүл, хүүхэд, залуучууд:</u>

**1.5. Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжиж, идэвхтэй, бүтээлч иргэнийг төлөвшүүлнэ.**

1.5.1. Баянзүрх Дүүргийн Засаг Даргын дэргэд Залуучууд, Эмэгтэйчүүд, Ахмадууд, Хөршийн холбоог байгуулж найрсаг, хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэх чиглэлд анхаарч ажиллана.

1.5.2. Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.

1.5.3. Байгууллагын дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, эцэг эх, олон нийтэд гэр бүлийн боловсрол, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.

1.5.4. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

1.5.5. Хүүхдийн оролцооны болон өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангаж ажиллана.

1.5.6. Нутаг дэвсгэрийн нэгж бүрд байх нэг цэгийн үйлчилгээний төвөөр дамжуулан хүүхэд хамгааллын цогц үйлчилгээг үзүүлнэ.

1.5.7. Гэр бүл, хүүхэд, залуучуудад хамаарах хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
2304159
916 ХТО7574
УЛААНБААТАР ХОТ

1.5.8. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, аюул, гэмтлээс урьдчилан сэргийлэх, хамгааллын үйлчилгээг үзүүлнэ.

1.5.9. Хүүхдийн эсрэг, гэр бүлийн болон жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд зохион байгуулна.

1.5.10. Хүүхдийн болзошгүй эрсдэл болон эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд иргэд, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг сайжруулна.

1.5.11. Хүүхдийн эсрэг, гэр бүлийн болон жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих бодлого баримтлана.

1.5.12. Залуучуудын хөгжлийн төвүүдээр дамжуулан тэдний хөгжил, оролцоог дэмжинэ.

1.5.13. Өсвөр үе, залуучуудын сөрөг зан үйл, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хувь хүний хөгжлийг дэмжих сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.

1.5.14. Зорилтот бүлгийн залуучуудад амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх, нийгэмшүүлэх зохион байгуулна.

1.5.15. Залуучуудын сайн дурын болон хүмүүнлэгийн ажилд оролцох оролцоог дэмжиж, хамтран ажиллана.

Соёл урлаг:

**1.6. Баянзүрх дүүргийн хэмжээнд байдаг соёлын төв, заал, танхимын арчлал, хамгаалал, менежментийг сайжруулж бүх насныханд чиглэсэн соёл урлагын арга хэмжээг дэмжиж ажиллана.**

1.6.1. Хүний нөөцийн чадавхи сул, үйл ажиллагаа нь зогсонги соёл, урлагийн байгууламжуудын менежментийг сайжруулах, шаардлагатай тохиолдолд олон нийтийн болгож өргөжүүлнэ.

1.6.2. Чөлөөт өрсөлдөөний зарчимд нийцүүлэн мэргэжлийн соёл, урлагийн байгууллагуудаа нэмэлт орлого олох боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

1.6.3. Мэргэжлийн урлагийн сургалт, сургууль төгсөгч, дадлагажигч нарт эзэмшсэн ур чадвараа хөгжүүлэх, уран бүтээлээ олны хүртээл болгоход дэмжлэг үзүүлнэ.

1.6.4. Нүүдлийн аж ахуйд суралцах, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ, хөтөлбөрүүдийг дэмжинэ.

1.6.5. Хувь хүний эрх чөлөө, ардчилал, чөлөөт эдийн засгийн ач холбогдлыг таниулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО

1.6.6. Түүх соёлын өвийг бүртгэлжүүлж, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

1.6.7. Иргэдэд хадгалагдаж байгаа соёлын биет өвийг бүртгэж, үнэмлэхжүүлнэ.

1.6.8. Ногоон байгууламж бүхий соёл, амралтын хүрээлэн, нийтийн эзэмшлийн талбайд иргэд оршин суугчдийг хамруулсан тэмдэглэлт баяр, амралтын өдрийн үзэсгэлэн яармаг, фестиваль, наадам зохион байгуулах ААН, байгууллагын санал санаачлагыг дэмжинэ.

1.6.9. Соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг хотын хөгжлийн индексийн өнөөгийн хэмжээнд төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

1.6.10. Олон улс болон улсын чанартай тэмцээн уралдаанд шалгарсан сургууль, анги хамт олныг бодлогоор дэмжинэ.

## ХОЁР. НОГООН БОДЛОГТОЙ БАЯНЗҮРХ

Ногоон байгууламжтай дүүрэг:

**2.1 Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдрахад таатай дүүрэг болно.**

2.1.1. Баянзүрх дүүргийн ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг бий болгоно.

2.1.2. Хороо бүрт 500 метр дотор амарч, тухлах ногоон байгууламж, цэцэрлэгтэй болох боломжийг бүрдүүлнэ.

2.1.3. Баянзүрх дүүрэгт Мод үржүүлгийн газар байгуулна.

2.1.4. Гэр хорооллын айл өрх хашаандаа болоод гадна орчиндоо мод тарих, ногоон байгууламж байгуулах санал санаачилгыг дэмжиж ажиллана.

2.1.5. Явган хүн зорчих хэсэг, ногоон байгууламж, дугуйн зам, зогсоолын төлөвлөлт, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, иргэд явган явах, дугуйгаар зорчих орон зайг нэмэгдүүлнэ.

2.1.6.“Иргэн бүр нэг мод” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Цэнгэг агаартай дүүрэг:

**2.2. Агаар, орчны бохирдлыг бууруулж, байгальд ээлтэй, үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэх замаар эрүүл, аюулгүй орчинтой дүүрэг байна.**

2.2.1. Агаар, орчныг бохирдуулагч эх үүсвэрийг багасган, байгальд ээлтэй эрчим хүчний хэмнэлттэй технологийг нэвтрүүлж, агаарын бохирдлыг одоо байгаагаас 80 хүртлэх хувиар бууруулна.

1117145633
УХА0612 9077278

АРДЧИЛСАН НАМ
БАЯНЗҮРХ ... НАМ

2.2.2. Гэр хорооллын айл өрхийн дулаан хангамжийг бусад /төвлөрсөн дулаан, хий, эдийн засгийн өгөөж бүхий сэргээгдэх эрчим хүч, цахилгаан болон бусад/ эх үүсвэрт шилжүүлэх замаар хатуу түлшний хэрэглээг бууруулна.

2.2.3. Агаар, орчны бохирдлыг бууруулах дэвшилтэд техник технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах тогтолцоог сайжруулна.

2.2.4. Сайжруулсан шахмал түлшнээс гарсан хаягдал үнсийг дахин боловсруулах технологит шинэчлэлтийг иргэн, хувийн хэвшлийн дэмжлэгтэй хийж, орчны агаарын чанарт үзүүлж буй нөлөөллийг багасгана.

2.2.5. Олон улсын байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ногоон-төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх иргэд, төрийн бус байгууллагын оролцоо, санаачлагыг дэмжин нэмэгдүүлэх замаар агаарын бохирдолыг бууруулах нөлөөллийн ажлыг хэрэгжүүлнэ.

2.2.6. Агаарын бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцооний клуб, холбоо, нэгдэлийг нэмэгдүүлж, эрүүл, аюулгүй орчинд амьдрах зөв дадлыг дүүргийн иргэдэд төлөвшүүлнэ.

2.2.7. Гэр, байшин сууцны дулаан алдагдлыг бууруулахад олон улсын байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.2.8. Агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулна.

<u>Хөрс, орчны бохирдолгүй дүүрэг:</u>

**2.3. Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар бохирдлын бүх эх үүсвэрийг багасгаж, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.**

2.3.1. Бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг нэмэгдүүлэхэд захиргааны болон урамшууллын аргыг хослуулан хэрэглэнэ.

2.3.2. Ахуйн хэрэглээний болон цахилгаан станцуудаас гарах үнс, лаг, хог хаягдлыг дахин ашиглаж, хоёрдогч бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

2.3.3. Хог хаягдлыг ангилан ачих, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж, стандартыг бий болгох, дахин боловсруулах үйлдвэрт шилжүүлэх, хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийг цэвэрлэж, нөхөн сэргээж үйл ажиллагааг илүү боловсронгуй болгоно.

2.3.4. Аюултай хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, саармагжуулах, устгах тогтолцоог бий болгоно.

2.3.5. Дахивар түүхий эдийг дахин боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг төрөлжүүлэх, технологийн шинэчлэл хийх, хөгжүүлэх, хаягдалгүй технологи бүхий эрчим хүч гаргах, байгаль орчинд хор нөлөөгүй үйлдвэрийг байгуулах иргэн, ААН, байгууллагыг дэмжинэ.

УХА0612 9077278

8.

2.3.6. Хатуу хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.

2.3.7. Орчны бохирдлын хяналт шинжилгээний сүлжээг өргөжүүлж, судалгааны ажлыг тогтмол хийж, байгальд ээлтэй, үр ашигтай, дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.

Ногоон хэрэглээтэй дүүрэг:

**2.4. Экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан байгаль орчинд сөрөг нөлөөгүй, ногоон хэрэглээтэй өрхийн тоог нэмэгдүүлэх бодлого баримталсан дүүрэг байна.**

2.4.1. Нарны эрчим хүчнээс цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх замаар өрх өөрийн цахилгааны хэрэглээг хангах, илүү гарсан цахилгааныг эрчим хүчний дэд станциудад нийлүүлэх замаар нэмэлт орлого олох боломжтой тогтолцоог бүрдүүлнэ.

2.4.2. Нүхэн жорлонгоос үүдэлтэй хөрсний бохирдол хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийн судалгааг хийж, урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг арилгах, хөрсийг дахин сэргээх, МОН-9189 төслийн стандартийг хэрэглээнд нэвтрүүлнэ.

2.4.3. Өрх ахуйн хог, хаягдлаа анхнаас нь ангилж хаях тогтолцоог нэвтэрүүлнэ. Мөн хог ангилж хаях процессийн сургалтыг дүүргийн хэмжээнд явуулж хог ангилах ногоон соёлыг иргэддээ төлөвшүүлэх нөлөөллийн ажлыг үе шаттай явуулна.

2.4.4. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр эрхлэх иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг бодлогоор дэмжин ажиллана.

2.4.5. Хог хаягдлын тогтолцоо, менежмент, стандартийг дүүргийн хэмжээнд бүхэлд нь шинэчлэн сайжруулна.

2.4.6. Хүлэмжийн аж ахуй эрхлэж тухайн бүс нутагтаа бизнес эрхлэж байгаа өрхийг ногоон зээлд хамруулах болон бусад чиглэлээр дэмжлэг үзүүлнэ.

2.4.7. Мод үржүүлэг, ойжуулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудыг газар, усны төлбөрөөс чөлөөлж, татварын хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчин бий болгоно.

2.4.8. Төв суурин газруудыг элсний нүүлтээс хамгаалах ойн зурвасыг агро ойн аж ахуйтай хослуулан хөгжүүлнэ.

2.4.9. Байгалийн ба таримал ойн бүтээмжийг нэмэгдүүлэх, эрсдэл, сөрөг нөлөөллөөс хамгаалах ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.4.10. Ундны усны хамгаалалтыг сайжруулж, гүний усны хэрэглээг бууруулж, гадаргын усыг хуримтлуулан ашиглах боломж, технологийг нэмэгдүүлнэ.

2.4.11. Хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулж хөв цөөрөм, усан сан байгуулна.

2.4.12. Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.

2.4.13. Барилга байгууламжийн дээврийн хур борооны усыг цуглуулах технологийн шийдлийг дэмжиж, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын ахуйн хэрэгцээ, ногоон байгууламжийн усалгааны хэрэглээг хэвшүүлнэ.

2.4.14. Гадаргын усны тоо, бүртгэлийг жил бүр хийж, булаг шандны эхийг хамгаалах, айл өрхийг ус, үерт автахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авна.

2.4.15. Гэр хорооллын иргэд өөрийн эзэмшил газартаа шинээр байшин баривал ипотекийн зээл авахад нь бодлогоор дэмжинэ.

## ГУРАВ. ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСАГТАЙ БАЯНЗҮРХ

Чинээлэг иргэн:

**3.1. Оюутан залуус, багш, эмч болон төрийн үйлчилгээний албан хаагчид, залуу гэр бүл, өрх толгойлсон эцэг, эхчүүдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд бодлогоор дэмжлэг үзүүлэх замаар чинээлэг иргэнтэй дүүрэг байна.**

3.1.1. Оюутан, залуучуудыг цагийн ажил эрхлэх нөхцөл боломжоор ханган, тусгайлсан хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.1.2. Багш, эмч болон төрийн үйлчилгээний бусад албан хаагчдыг орон сууцжуулах, бага хувийн зээлд хамрагдах бодлогыг дэмжинэ.

3.1.3. Эрчимжсэн мал аж ахуй, хүлэмжийн аж ахуй болон фермерийн аж ахуй эрхлэх санал санаачлагыг дэмжин, сургалт, төсөл хөтөлбөрт хамруулан, өрхийн орлогыг нэмэгдүүлэх бодлого баримтална.

3.1.4. Гадаадад ажиллаж амьдарч байгаад ирсэн иргэдийн үйлдвэрлэл эрхлэх бүтээлч санал санаачлагыг дэмжих, тэдний мэдлэг туршлагыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.

3.1.5. Хөдөлмөрийн хэлтсийн үйл ажиллагааг иргэдэд ойртуулж сайжруулна.

3.1.6. Хөдөлмөрийн зах зээлд дутагдалтай байгаа ажлын байрны чиглэлийн сургалтыг зохион байгуулж, сертификат олгоно.

3.1.7.Төрийн болон ТББ, Хөдөлмөрийн хэлтэс, Аж ахуй нэгж байгууллагатай хамтран иргэдийг ажилд зуучлах үйлчилгээг бодлогоор дэмжинэ.

3.1.8. Ажил олгогч, ажил хайгчийн ажлын уялдаа холбоог хангаж сайжруулах

3.1.9.Оюутан залуус, эмэгтэйчүүдийг хагас цагийн ажлаар хангах тал дээр ААН, байгууллагуудтай хамтарч ажиллах

3.1.10. Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж үзэсгэлэн худалдааг тогтмол зохион байгуулна.

Бизнес хөгжил:

АРДЧИЛСАН НАМ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО

**3.2.ААН, Байгууллагуудын бизнест оролцох бус бодлогоор дэмжих, төрийн дарамтгүй бизнесээ өргөжүүлэх боломжийг олгож ажлын байр нэмэгдүүлэх чиглэлд хувийн хэвшилтэй хамтран ажиллана.**

3.2.1. Их, дээд сургуулийн оюутнуудыг сурахын хажуугаар чиглэлийн салбартаа хагас цагаар ажиллах боломжийг бүрдүүлнэ.

3.2.2. Залуучуудыг нийгэм, эдийн засгийн хөгжилд оролцоотой байх, идэвхитэй амьдралын хэвшлийг сурталчилан таниулах компанит ажлыг тогтмол зохион байгуулна.

3.2.3. Төр хувийн хэвшлийн түншлэлийг гүнзгийрүүлэн, олон улсын болон төрийн бус байгууллагатай хамтран эдийн засгийг хөгжүүлж, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зорилго бүхий төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана.

3.2.4. Өрхийн үйлдвэрлэгч, бичил бизнес эрхлэгч иргэн, аж ахуй нэгжүүдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, гадаад дотоодын үзэсгэлэн худалдааанд хамруулан оролцуулах ажлыг зохион байгуулна.

3.2.5. Аялал жуулчлалын таатай орчинг бүрдүүлэх зорилгоор иргэд, аж ахуйн нэгжээс аялал жуулчлалын чиглэлээр хийгдэх шинэ санал, санаачилгыг дэмжин, төсөл хөтөлбөрт хамруулна.

3.2.6.Боловсруулах үйлдвэр болон барилгын материалын үйлдвэрлэл явуулах хил хязгаарыг тогтоож, бохирдол ихээр үүсгэдэг үйлдвэрийг суурьшлын бүсээс гаргаж, иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлэн, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.

3.2.7.Дүүргийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх санал санаачилгыг дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

3.2.8. Жижиг дунд үйлдвэр, бичил бизнес эрхлэгчдийг бодлогоор хөхүүлэн дэмжиж, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

3.2.9.Шинээр сургууль төгссөн болон ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг үзүүлж, ажлын байраар хангах нөхцлийг дүүргийн аж ахуй нэгж, байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

3.2.10.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эх үүсвэрээс санхүүждэг төсөл хөтөлбөрөөр дамжуулан дүүргийн бүтээн байгуулалтад чиглэсэн байгаль орчныг хамгаалах ажилд олон нийтийг хамруулах ажлуудыг Зохион байгуулна.

3.2.11.Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг "Аж ахуй эрхлэлт" сургалтанд хамруулж, үйлдвэрлэгч өрхийн санал санаачлагыг дэмжиж ажиллана.

3.2.12. Хөгжлийн бэршээлтэй иргэний ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.2.13.Иргэдийн ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх ажлын орчин нөхцлийг сайжруулах санал санаачлагыг дэмжиж ажиллана.

3.2.14. Орон нутгийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах, нээлттэй, олон нийтийн оролцоотой болгох хэсэгчилэн болон бүтэнээр хувьчлах замаар өгөөжийг нэмэгдүүлж, бүрдүүлсэн орлогыг дүүргийн голлох шаардлагатай чиглэлд захиран зарцуулан менежмент хийнэ.

3.2.15. Хөрөнгө оруулагчдийн эрх ашгийн хамгаалж тогтолцоог сайжруулах, дүүргийн нийгмийн салбарт болоод бизнес орчины гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлд онцгойлон анхаарна.

3.2.16. Бараа бүтээгдэхүүн борлуулах боломжтой цахим орчинг бүрдүүлж, тээвэрлэх, түгээх ложистик тогтолцоог сайжруулна.

3.2.17. Баянзүрх дүүргийн үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулж бага өртөгтэй үйлдвэрлэл явуулах, ажлын байр **“Монголд үйлдвэрлэв”** худалдааны цогцолбор төв байгуулна. /Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор бага түрээстэй болон түрээсгүй ажлын байр бий болгох/

3.2.18. “Өрх бүр үйлдвэрлэгч” хөтөлбөр боловсруулж Гачуурт тосгон, Хонхор зэрэг алсдагдсан хороодод сүүний болон жимс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн чиглэлээр кластер хийж, фермерийн аж ахуйг хөгжүүлнэ.

3.2.19. Үндэсний үйлдвэрлэгчиддээ тулгуурлан хямд өртөг бүхий хүнсний болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн борлуулах цэгүүдийг хороо бүрт ажиллуулна.

Үйлдвэрлэл, инноваци:

**3.3. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн, дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулалж, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.**

3.3.1. Баянзүрх дүүрэгт бизнес, инновацийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлнэ.

3.3.2. Хүүхэд залуучуудын хөгжлийн төв, шинэ төсөл хөтөлбөр бойжих боломж бүхийн хабуудыг үе шаттай байгуулж хөрөнгө оруулалт, эрх зүйн орчиныг сайжруулна.

3.3.3. Баянзүрх дүүрэгт гадааны бизнесийн хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж мэдээлэл технологи, инновацийн эдийн засгийн тусгай бүс байгуулах ААН, байгууллагатай хамтран ажиллана.

3.3.4. Инноваци, гарааны бизнесийн цахим мэдээллийн санг Баянзүрх дүүргийн хэмжээнд бий болгож хөгжүүлнэ.

3.3.5. Баянзүрх дүүрэгт инновацийн соёлыг бий болгох, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ

3.3.6. Баянзүрх дүүргээс гарсан инновацийн бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах, соёлыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг дэмжин зохион байгуулна.

3.3.7. Их, дээд, сургууль болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран бүтээлч залуучуудыг дэмжин хөдөлмөрийн зах зээлд бэлтгэнэ.

3.3.8. Баянзүрх дүүрэгт тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд шинэ санаа, технологийг санал болгож буй оюутан залуусийн төсөл хөтөлбөрийг судлан боломжит тохиолдолд дэмжиж хамтран ажиллана.

3.3.9. Хүүхэд, залуучуудын инновац, энтерпренершип сэтгэлгээг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.3.10. Баянзүрх дүүргийн гарааны бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг дотоод болон гадаадын зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлнэ.

## ДӨРӨВ. НЭЭЛТТЭЙ, ЦАХИМ БАЯНЗҮРХ

Ил тод, Нээлттэй байдал:

**4.1.Мэдээллийн технологийн цогц шийдлийг ашиглан төр, иргэн, хувийн хэвшил, гадаад хамтын ажиллагааг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх, хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлж, ил тод, нээлттэй байдлыг хангасан цахим засаглалыг бэхжүүлсэн дүүрэг болно.**

4.1.1. Мэдээллийг цахимжуулж, иргэдэд төрийн үйлчилгээг цогц байдлаар, цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бий болгож хэрэгжүүлнэ. /Алсын хараа-2050, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, 9.4.7, Шинэ сэргэлтийн бодлого, 6.1-д орсон/

4.1.2. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад үзүүлдэг үйлчилгээг цахим хэлбэрт бүрэн шилжүүлнэ.

4.1.3. Төрийн харъяа байгууллагын /хороо, газар, хэлтэс, алба/ албан хэрэг хөтлөлт, албан бичиг солилцох, тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг хянах тогтолцоо, үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, сүлжээг бий болгоно хэрэглээнд хэвшүүлнэ.

4.1.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор хяналтын камерын нэгдсэн төв бий болгож, мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн дүүргийн хэмжээнд хөгжүүлнэ. / Алсын хараа-2050, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, 7.3.8-д тусгагдсан/

4.1.5. Дүүргийн бүх шатны төлөвлөлт, төлөвлөгөөг боловсруулах, батлах, шийдвэр гаргахад иргэд, олон нийтийн оролцоог хангаж, иргэдийн мэдээлэл олж авах

сувгийг нээлттэй, хүртээмжтэй, ил тод болгоно. /Алсын хараа-2050, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа 9.4.3-д тусгагдсан/

4.1.6. Иргэдийн санал, хүсэлтийг авах, шилжүүлж шийдвэрлүүлэх, камерийн хяналтын, дуудлагын CALL CENTER төвийг үйлчилгээнд нэвтрүүлнэ.

4.1.7. Төрийн албан хаагчдийн суудаг хаалгыг шилэн болгож иргэдтэй харилцах хандлагыг эерэгжүүлж, үйлчилгээний соёлд сургана.

4.1.8. Иргэд нэг газраас бүх үйлчилгээг авах боломж бүхий дүүргийн үйлчилгээний нэгдсэн төвтэй болно.

4.1.9. Хорооны ажилтан, Хэсгийн ахлагч нарын ур чадварыг нэмэгдүүлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн ангилалд оруулж урамшууллыг нэмэгдүүлэх санаачлагыг гаргаж, ажлын хэрэгцээг хангаж, төрийн үйлчилгээг айл өрхөд хэрхэн хүргэж байгаад хяналт тавих тогтолцоог бүрдүүлнэ.

4.1.10. Дүүргээс хороодод эрх мэдэл, тодорхой чиг үүргийг шилжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. Дүүргийн харъяа байгууллагуудын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашиг, уялдаа холбоо, үйл ажиллагааны хурдыг сайжруулна.

4.1.11. Хороо бүрийн "Иргэний танхим"-ыг түшиглэн, "Жижиг дунд үйлдвэр, худалдаа үйлчилгээг дэмжих цогц төв" байгуулан, бизнес эрхлэх хүсэлтэй иргэдийг мэдээ, мэдээллээр хангаж, зөвлөгөө өгч, дэмжин ажиллана.

Гадаад хамтын ажиллагаа:

**4.2. Баянзүрх дүүргийн нийгэм, эдийн засаг, дэд бүтэц, ногоон байгууламжийн хөгжилд гадаад улс, хот, тосгон, дүүрэгтэй байгуулсан санамж бичиг, гэрээ, хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.**

4.2.1. Баянзүрх дүүрэг болон гадаад улс орнуудын хот, тосгон, дүүргүүдтэй хийсэн санамж бичиг, хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг сайжруулан дүгнэх, идэвхитэй хамтран ажиллах, шинээр гадаад улс орнуудын хот, тосгон, дүүргийн захиргаатай холбоо тогтоож хамтын ажиллагааг тэлэх ажлыг тухайн чиглэлийн төрийн бус байгууллагаар хэрэгжүүлэн ажиллана.

4.2.2. Баянзүрх дүүрэгтэй хамтын ажиллагааны гэрээтэй олон улсын байгууллага, улс орны хот, тосгон, дүүргийн төлөөлөгчийг холбогдох төсөл, хөтөлбөрийн үр дүнг өгөөжтэй сайн гарах зорилгоор тодорхой хугацаанд монгол улсад ажиллуулна.

4.2.3. Дэлхийн хотуудын ухаалаг дэд бүтэц, хүнд ээлтэй тохижилт, ногоон байгууламж, хог хаягдлын менежментийн сайн туршлагыг нутагшуулах зорилгоор Олон улсын чиглэлийн мэргэжлийн экспертүүдийг урьж дотооддоо мэргэжилтэн сургаж бэлтгэнэ.

4.2.4. Дүүргийн дэд бүтэц, ногоон байгууламж, бүтээн байгуулалт, нийгмийн хөгжлийн ажилд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдийг(volunteer) татан оролцуулна.

АРДЧИЛСАН НАМ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО

14.

Иргэний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:

**4.3. Баянзүрх дүүргийн хөгжлийн хөтөлбөр, шийдвэр гаргалтад иргэний нийгмийн байгууллагын оролцоо, санал, санаачлагыг нэмэгдүүлнэ**

4.3.1. Дүүргийн удирдлагын шийдвэр гаралтанд иргэний нийгмийн оролцоо, мэргэжлийн холбоод, иргэдийн оролцоог хангана.

4.3.2. Олон нийтийн цагдаа болон “Хөршийн холбоо”-ны үйл ажиллагааг идэвхжүүлэн дэмжиж, орчны аюулгүй байдлыг сайжруулна.

4.3.3. Дүүргийн “Сайн дурын ажилтан хөтөлбөр” хэрэгжүүлж гадаад дотоодын иргэд, ААН, ТББ-тэй хамтран ажиллана.

4.3.4. Дүүргийн иргэний баримтлах хэм хэмжээ, биеэ авч явах соёлын хэмжүүрийг дээшлүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх олон нийтийн арга хэмжээг идэвхжүүлнэ.

4.3.5. Дүүрэг болон хороонд тулгамдаж буй асуудлаар Нийслэл, Засгийн Газарт санал хүргүүлж хөрөнгө оруулалт, холбогдох төсөл, хөтөлбөрт хамрагдана.

4.3.6. Гадаадын болон улс орнуудаас боловсруулсан төслийн хүрээнд хийж болох ажлыг санаачлан хэрэгжүүлнэ.

4.3.7. Дүүрэг, хорооны гудамж, өрхийн хаягжилтыг шинэчлэн сайжруулах

4.3.8. Хороог төсөвтэй болгож үйл ажиллагааг иргэн төвтэй байлгаж үйл ажиллагааг сайжруулах, тэдний хүлээх үүрэг, хариуцлага чиглэлийг тодорхойлж хяналт тавих

4.3.9. Хороо бүр технологийн дэвшилийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ашиглах

4.3.10. Улсын бүртгэгч нарыг сэлгэж ажиллуулдаг болгоно.

4.3.11. Хөршийн холбоог байр, орц, давхар, гудамж бүрээр нь холбож тэднийг идэвхжүүлэх

4.3.12. Иргэдээс санал авч ажлын төлөвлөгөөнд тусгадаг болох

4.3.13. Иргэдийг сонирхолын бүлгээр ангилж үйл ажиллагаа зохион байгуулах

## ТАВ.САЙН ТӨЛӨВЛӨЛТТЭЙ БАЯНЗҮРХ

**5.1. Иргэнд ээлтэй сайн төлөвлөлтийг Баянзүрх дүүрэг шинэчлэн зохион байгуулна. Нийслэлийн хамгийн идэвхитэй бүс дүүргийн хувьд цогц, тогтвортой, хүртээмжтэй, хэмнэлттэй, дасан зохицох чадвартай амьдрахад таатай ногоон орчин бүхий Баянзүрхийг бий болгоно.**

Гэмт хэрэг зөрчилгүй, аюулгүй тайван дүүрэг:

5.1.1. Гэр хорооллын гудамж талбайг эко нарны зай хураагуур бүхий гэрэлтүүлгээр бүрэн хангаж харанхуй гудамжгүй Баянзүрх дүүрэг болно.

5.1.2. Баянзүрх дүүргийн газар нутгийн гудамж талбай, байшин, барилга, зам талбайн зорчих хэсгийн огтлолцол бүрт хяналтын камерийн системийг үе шаттайгаар бүрэн нэвтэрүүлнэ.

5.1.3. Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр дэх хяналтын камер, гэрэлтүүлгийн арчлал хамгааллыг зөв, тасралтгүй ажиллагаатай байлгах чиглэлийн нэгж, бүтэцийг зохион байгуулах, гэрээгээр хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль хяналтын байгууллагатай уялдаа холбоотой ажиллуулах

5.1.4. Хороодыг нэртэй болгож, гудамж, талбай, өрхийн хаягжилтыг сайжруулах

<u>Стандартчилагдсан Баянзүрх:</u>

**5.2. Баянзүрх дүүргийн стандартийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан мөрдүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.**

5.2.1. Хүндээ ээлтэй, аюулгүй амгалан хотын олон улсын стандартийг үндэслэн үе шаттайгаар нэвтрүүлсэн байна.

5.2.2. Хүүхдийн тоглоомыг талбайн аюулгүй байдлын стандартыг боловсруулж мөрдүүлнэ.

5.2.3. Дүүргийн өнгөний стандартыг боловсруулж нэвтрүүлсэн байна.

5.2.4. Ногоон барилга, байгууламжийн стандарт боловсруулж үе шаттайгаар нэвтрүүлсэн байна.

5.2.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй дэд бүтцийг хөгжүүлэх хот, дүүргийн стандартын хэрэгжилтийг бүрэн хангуулж иргэнд ээлтэй, оновчтой төлөвлөлтийг бий болгоно.

5.2.6. Явган болон дугуй, цахилгаан дугуйгаар зорчих задгай болон туннель зам байгуулна.

5.2.7. Баянзүрх дүүргийн хүн амын төвлөрөлтэй уялдуулан аюулгүй байдлын стандартыг бүсчлэн үнэлгээ, дүгнэлт гаргадаг байна.

5.2.8. Эвдрэлтэй зам, хүүхдийн тоглоомын талбай, муу усны нүх, цахилгааны под станц, түүний ойр орчмын ил задгай цахилгааны утас зэргийн бүртгэл судалгааг тогтмол гаргаж аюулгүй байдлыг хангаж ажиллана.

5.2.9. Хороолол дундах авто машины замын урсгалд зохицуулалт хийж түгжрэлгүй зорчих боломжийг бүрдүүлнэ.

<u>Аялал жуулчлал, соёлын бодлого:</u>

**5.3. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлал ногоон бүс, соёл, түүх дурсгалын барилга байгууламж газруудыг олон улсын байгууллага, хувийн хэвшилтэй хамтран сэргээн засварлаж, шинэчлэн бүтээн байгуулах, таниулан сурталчилах, аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлэхэд онцгойлон анхаарна.**

5.3.1. Дарь-Эх цогцолборыг Улаанбаатар хотын төвийн бүст байрлах хоёр дахь өндөрлөг аялал жуулчлалын цогцолбор бааз болгох хөгжүүлэх ажлыг үе шаттай үргэлжлүүлнэ

5.3.2. Баянзүрх дүүргийн зулангийн бүст байрлах амралт, жуулчны бааз, хүүхдийн зусланг бүртгэлжүүлж маркетинг сурталчилгааны шинэ стандарт шаардлага тавьж үйл ажиллагааг идэвхижүүлнэ.

5.3.3. Баянзүрх дүүргийн аялал жуулчлалыг хөгжүүлэх санал санаачлага бүхий төсөл, хөтөлбөрийн уралдаан, шалгаруулалтыг үе шаттай зохион байгуулж бодит төсөл болгох хөгжүүлэхэд анхаарч ажиллана.

5.3.4. Аялал жуулчлалын бүс орчмын түүх соёлын газруудаа засаж сэргээн иргэд очиж чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжоор хангах, авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлнэ.

5.3.5. Ногоон бүс болох Гачуурт чиглэлд Монголын Аялал Жуулчлалын холбоотой хамтран ажиллаж дүүргийн аялал жуулчлалын онцлогийг гарган аялал жуулчлалын бүсийг эдийн засгийн өгөөжтэй байдлаар өргөн хүрээнд хөгжүүлнэ.

5.3.6. Баянзүрх Хайрханыг тохижуулан "Хайрхан хөгжлийн төв" байгуулна.

5.3.7. Мал аж ахуй бүхий хороодын малчидын амьдрал ахуйтай танилцан мал маллах нөхцөл чиглэлийг тогтоож өгөх, нутаг дэвсгэрийг заан тогтоож өгөх

Орон сууц, нийтийн аж ахуй:

**5.4. Хот, дүүрэг дахин хөгжүүлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэн инженерийн болон нийгмийн бүтцээр хангах ажлыг эрчимжүүлж, иргэдийг эрүүл, аюулгүй орчинд стандартын шаардлага хангасан орон сууцанд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.**

5.4.1. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг сэргээн засварлах, иргэдийг стандартын шаардлагад нийцсэн орон сууцанд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.4.2. Агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах, иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор амины орон сууцны хорооллыг хөгжүүлж, хэсэгчилсэн болон бие даасан хангамжийг нэвтрүүлнэ.

5.4.3. Дулааны алдагдлаа бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй сууц шинээр барих сонирхолтой хувь хүн, хуулийн этгээдэд холбогдох зээл тусламж, санхүүгийн эх үүсвэр шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО

5.4.4. Иргэдэд дулаан алдагдлыг бууруулах чиглэлээр сургалт сурталчилгаа, ухуулан таниулах үйл ажиллагааг тогтмол явуулах, шаардлагатай ном товхимол, гарын авлагаар хороодоор дамжуулж хангана.

5.4.5. Нийгмийн зорилтот бүлэг, орлогын түвшин, эрэлт хэрэгцээнд нийцсэн түрээсийн олон төрөлт болон иргэдийн орлогод нийцсэн ногоон орон сууцны шинэ хорооллуудын бүтээн байгуулалтын ажлыг хийх иргэн, ААН-ийг бодлогоор дэмжиж хамтран ажиллана.

Дэд бүтэц:

**5.5. Баянзүрх дүүргийн хэмжээнд дэд бүтцийн хангамжийн эх үүсвэрүүдийн хүчин чадлын нэмэгдүүлэх, дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөн шинэчилж, орчны бохирдлыг бууруулан үерийн эрсдлийг бууруулах, иргэдийн амьдрах орчныг сайжруулна.**

5.5.1. Баянзүрх дүүргийн үерийн эрсдэлийн бүс, зам талбайн судлагааг тогтмол гаргаж эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулж иргэдийг үер усны эрсдэлээс урьдчилан сэргийлж, амьдрах орчинг сайжруулна.

5.5.2. Үерийн эрсдэлийн хохирлын үнэлгээг боловсруулж, голуудын эргийн хамгаалалт, далан, суваг, усан сан, хөв, цөөрөм, хөрсний усны шугам сүлжээ, барилга байгууламжийг тодорхойлон хохирлын үнэлгээтэй уялдуулан барьж байгуулна.

5.5.3. Зам, талбайн ус зайлуулах шугам сүлжээ, барилга байгууламжгүй хороолол, хотхоныг нэгдсэн сүлжээнд холбуулж, оршин суугчдын аюулгүй орчинг бүрдүүлнэ. Шинээр болон өргөтгөн шинэчлэх авто зам, замын байгууламжийг ус зайлуулах шугам сүлжээтэй барих стандартыг мөрдүүлж, ашиглалтыг сайжруулна.

5.5.4. Гэр хороолол дундах сайжруулсан чулуун замыг нэмнэ.

5.5.5. Үер, усны эрсдэлтэй бүсийг чөлөөлж, мэдээлэх, иргэдэд үерийн гамшиг, эрсдэл, хор хохирлын мэдлэг, мэдээлэл олгож, хөндлөнгийн хяналт, хариуцлагыг сайжруулж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

5.5.6. Инженерийн бэлтгэл арга хэмжээний төлөвлөлт, ашиглалт, хамгаалалтын хууль, эрх зүйн орчинг сайжруулж, шаардлагатай машин механизм, тоног төхөөрөмжөөр хангана. Стандартын шаардлага хангасан үер, ус зайлуулж нөөцлөх, нөөцлөгдсөн усыг дахин ашиглах эко систем, технологийг нэвтрүүлнэ.

5.5.7. Зүүн дөрвөн зам, Офицерийн тойргийн дамжин өнгөрөх чадал, урсгалыг нэмэгдүүлэхийн тулд барилгын ажил(Гүүрэн зам, Зам өргөтгөл) хийнэ.

5.5.8. Одоо байгаа шугам сүлжээг өргөтгөн шинэчилэх, шинэ техник технологийг нэвтрүүлж, бохирдуулагч ангилалын үйлдвэрүүдийн хаягдал усны хяналтын менежментийг сайжруулж, төвлөрсөн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн аюулгүй байдал, байгальд нийлүүлэх усны чанар, стандартыг хангана.

5.5.9. Бохирдуулагч ангилалын үйлдвэрүүдийн хаягдал усны хяналтын менежментийг сайжруулж, одоо байгаа ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн шинэчилж, шуудуу ухалгүй доторлох, шинэ техник технологи нэвтрүүлэх чиглэлд нийслэл, засгийн газрын холбогдох агентлаг, газартай хамтран ажиллана.

5.5.10. “Бохир усны шугам хоолойн засвар үйлчилгээ, удирдлага, шинэчлэлтийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийг олон улсын байгууллага, нийслэл, засгийн газрын холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

Эрчим хүч:

**5.6. Сэргээгдэх эрчим хүч, байгальд ээлтэй, шинжлэх ухаан, дэвшилтэт технологид суурилсан технологийг дулааны эх үүсвэрт ашиглах шинэ технологийг нутагшуулах төслийг хэрэгжүүлнэ. УБДС-тэй хамтран төвлөрсөн дулаан хангамжийн системийн төв магистраль шугамуудыг өргөтгөх, шинэчлэх ажлыг боломжит хэмжээнд хүртэл нэмэгдүүлэх чиглэлээр анхаарч ажиллана.**

5.6.1. Шинэ сэргэлтийн бодлогын 2.1-д “Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх, шугам сүлжээг шинээр барьж байгуулан, хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлнэ” гэсний дагуу холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран дулааны эрчим хүчийг үйлдвэрлэх, түгээх эх үүсвэр, шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажлыг эрчимжүүлнэ.

5.6.2. Амгалан дулааны станцаас дулаан түгээж буй төв магистраль болон салбар шугамаас хангах хэрэглэгчдийн судалгааг тус станц болон УБДС-тэй хамтран хийж шинээр барих, шугамын урт, дулаан нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлнэ.

5.6.3. УБДС-тэй хамтран төвлөрсөн дулаан хангамжийн системийн төв магистраль шугамуудыг өргөтгөх, шинэчлэх ажлыг боломжит хэмжээнд хүртэл нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

5.6.4. Орон сууцны хорооллуудын дулааны төв магистраль шугамууд, насос станцуудыг өргөтгөн шинэчилнэ. Шинээр дулааны ачаалал нэмэгдэж байгаатай холбогдуулан орон сууцны хорооллуудын дулааны хэрэглээг хэвийн хэмжээнд хангахын тулд дулааны төв магистраль шугамууд, насос станцуудыг өргөтгөн шинэчилэх тооцооллыг хийлгэсний үндсэн дээр ажлыг хийж гүйцэтгэнэ.

5.6.5. Амины орон сууцны төслүүд, гэр хорооллын дахин төлөвлөлттэй уялдуулан нарны эрчим хүчийг цахилгаан ба дулааны эрчим хүчийг ашиглан эрчим хүчийг хангах тархмал эх үүсвэрүүдийг дэмжин, гадны ба дотоодын төсөл хөтөлбөрүүдийг хувийн хэвшил болон гадны хөрөнгө оруулагчидтай хамтран хэрэгжүүлж ажиллана.

5.6.6. Гэр хороолол, зуслангийн бүсийн өргөжин тэлж буйтай холбоотойгоор тэдгээр хэрэглэгчдийн эрчим хүчний хангамжийг найдвартай болгох зорилгоор УБЦТС компанитай хамтран одоо байгаа дэд станцуудыг өргөтгөх, шинээр барих төслийг хэрэгжүүлнэ.

5.6.7. Байршлын хувьд нарны нөөц ихтэй гэр хорооллын газруудад бага чадлын хуримтлуур бүхий нарны эх үүсвэрүүдийг тархмал хэлбэрээр суурилуулах төслийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана.

5.6.8. Өсөн нэмэгдэж буй гэр хороолол, зуслангийн бүсийн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний найдвартай, тасралтгүй байдлыг хангахын тулд УБЦТС компанитай хамтран ажиллана.

## ЗУРГАА.ЭЕРЭГ ХАНДЛАГАТАЙ БАЯНЗҮРХ

<u>Хөршийн холбоо:</u>

**6.1. Өрх, Иргэн хоорондын харилцаа холбоог сайжруулах зорилго бүхий хөршийн холбоог хороо, байр, гудамж бүрт байгуулах санаачилга гарган ажиллана.**

6.1.1. Ахмадын холбооны үйл ажиллагааг өргөжүүлж бие биенээсээ суралцаж, харилцан туслах, хөгжих боломжийг бүрдүүлнэ.

6.1.2. *Хөршийн холбоо үүсгэсэнээр иргэд хоорондын харилцаа, холбоо тэлж* өрхийн амжиргааг дэмжих хоршоод байгуулагдах, эрүүл мэнд, биеийн тамир, урлаг спортын сонирхолын бүлэгүүд бүрдэнэ.

6.1.3. Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх сонирхолын бүлэгүүд, иргэдийн үе үеийн нэгдэл, хамтрал, нөхөрлөлийг дэмжих төсөл, хөтөлбөр тэмцээн уралдааныг тогтмол зохион явуулна.

6.1.4. Айл, өрх хоорондын харилцаа холбоог дэмжих, аюулгүй, амгалан, нөхөрсөг орчинд амьдарч болох нөхцлийг бүрдүүлнэ.

6.1.5. Иргэдийг нийгэмд хэрхэн өөрийгөө илэрхийлэх, хоггүй цэвэр орчинг бүрдүүлэх, эрүүл мэндийн боловсрол, бусдыг хэрхэн хүндэтгэх, олон нийтийн ажиллагаанд оролцох чиглэлийн соён гэгээрүүлэх арга хэмжээг улирал бүр зохион явуулж тогтмол оролцдог иргэн, хүүхэд, залуучуудын идэвхи санаачлагыг дэмжин ажиллана.

6.1.6. Ахмад настануудын ажил эрхлэлтийг дэмжих, амьдарч буй хороо, бүсд шаардлагатай байгаа ажлын байрны судалгаа эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн сургалтанд хамруулна.

6.1.7. Баянзүрх дүүргийг ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлэх чиглэлд ахмадуудын оролцоог хангуулж ландшап(landshaft) хийх мэрэгшүүлэх сургалтад хамруулж ажлын байртай болгох чиглэлд бодлого гарган хэрэгжүүлнэ.

6.1.8. Баянзүрх дүүргийн иргэдийг амьдрах орчинг сайжруулах, сэтгэл санааг өөдрөг байлгах, сэтгэцийн эрүүл мэндэд эерэгээр нөлөөлөх уулзалт, сургалтыг тогтмол зохион байгуулж иргэдийн амьдрах орчиндоо сэтгэл хангалуун байх аз жаргалын индексийг нэмэгдүүлэх чиглэлд төрийн бус байгууллага болон олон улсын байгууллага, бусад нэгжийн дэмжлэгтэй төсөл хөтөлбөрийг зохион байгуулна

6.1.9. СӨХ-н ажлын бүтээмжиийг дээшлүүлэх, оршин суугчдын сэтгэл ханамжтай байдлаар дүгнэх үзүүлэлтийг боловсруулж нэвтэрүүлэх, хөршийн холбоотой уялдуулан ажилладаг байх тогтолцоог бүрдүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО

6.1.10. Гадаадад сурч, ажиллаж байгаад эх орондоо эргэн ирсэн гэр бүл, залуучуудад зориулсан дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

6.1.11. Хороо тус бүрт иргэд ашиглах боломжтой утасгүй сүлжээг тавих

6 Бүлэг, 23 Дэд бүлэг, 227 Зорилт бүхий

**Баянзүрх Дүүргийн Ардчилсан Намын Мөрийн Хөтөлбөр**

---o0o---

АРДЧИЛСАН НАМ

УЛААНБААТАР ХОТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 1006

танай ____________-ны №____________-т

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
АРДЧИЛСАН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Сонгинохайрхан дүүргийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Сонгинохайрхан дүүргийн Ардчилсан намын Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор иргүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дах хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сонгинохайрхан дүүргийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөр /..40....... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Сонгинохайрхан дүүргийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМ

***Алдагдсан 8 жилийн***
***Алдааг засна!***

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН**
**АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР 2024**

АРДЧИЛСАН НАМ
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8486916 ХТО7582
УЛААНБААТАР ХОТ

**АГУУЛГА**


1. УХААЛАГ ЗАСАГЛАЛТАЙ ДҮҮРЭГ
2. АЖИЛ ОРЛОГОТОЙ ДҮҮРЭГ
3. ЗӨВ ТӨЛӨВЛӨЛТТЭЙ ДҮҮРЭГ
4. ЭКО ДҮҮРЭГ
5. ЭЭЛТЭЙ ДҮҮРЭГ

Ардчилсан нам нийслэлийг удирдсан 2012-2016 жилүүдэд төр засаг нь иргэдээ сонсдог, иргэнд тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэдэг, Нийслэлийн төр захиргааны үйлчилгээг иргэндээ ойртуулж, Гэр хорооллын дахин төлөвлөлт, Нийтийн тээврийн салбарын цогц шинэчлэл, төрийн үйлчилгээний нэг цэгийн үйлчилгээ зэрэг томоохон өөрчлөлт шинэчлэлийг та бүхэнтэй хамтран эхлүүлсэн билээ.

Бид энэ удаа иргэдийн төлөө дүүргийн захиргааг хариуцлагатай, иргэдээ чирэгдүүлдэггүй болгох, иргэдээ ажилтай орлоготой, агаар, хөрс, тоосжилт, орчны бохирдлыг цогцоор нь шийдвэрлэх, гэр хорооллын дахин төлөвлөлт зэрэг томоохон өөрчлөлтийн төслүүдийг санал болгож байна.

**Хүүхэд багачуудад**

Бид хүүхдэд ээлтэй хотын стандартыг мөрдүүлж "нэгдүгээрт хүүхэд" зарчмаар ажиллана. Хамран сургах тойрог буюу хүүхэд багачууд алхаад очих зайд цэцэрлэг, бага сургууль байгуулах ажлыг дахин үргэлжлүүлнэ. Хүүхдүүдийн боловсролын чанарт онцгой анхаарсан тусгай бодлого гарган ажиллана. Хүүхдийг бүтээлч, шинийг санаачлагч болгож төлөвшүүлэх зорилгоор технологийн лаборатори, зохион бүтээгчдийн төв, хүүхэд хөгжлийн ордон байгуулж хүүхэд бүрийн авьяас чадварыг хөгжүүлэхэд онцгой анхаарна.

**Залуучуудад**

Бид залуучуудаа дэмжиж, сурч боловсрох, хөгжин дэвших орчин нөхцөлийг бүрдүүлнэ. Залуус чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, нийтийн биеийн тамираар хичээллэх, спортын болон соёл урлагийн байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлнэ.

**Ахмад настнуудад**

Ахмадууд ажил амьдралын арвин туршлагаа хуваалцах, орлогоо нэмэгдүүлэх, ажил хөдөлмөр хийх боломжийг бий болгоно. Бид "Ахмадын орон сууц" хөтөлбөрөө үргэлжлүүлж "Ахмадын ажлын байр" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Ахмадын асрамж сувиллын жишиг төв барина.

**Хөгжлийн бэрхшээлтэй (тусгай хэрэгцээт) иргэдэд**

Тусгай хэрэгцээт иргэд рүү чиглэсэн дэд бүтэц, нийгмийн амьдралд идэвхтэй оролцож ажиллаж амьдрах боломжийг бүрдүүлэхэд онцгой анхаарал хандуулна.

**Гэр бүлүүдэд**

Бид өрх бүрийг тогтмол ажилтай орлоготой болгох, өрхийн бизнес эрхлэлтийг бүх талаар дэмжиж ажиллана. Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны түрээсийн бодлогыг дэмжиж хэрэгжүүлнэ. Дүүргийн эргэн тойронд иргэд амрах, чөлөөт цагаа

тав тухтай өнгөрүүлэх бодлогыг баримтална. Гэр бүлтэй залууст төлбөрийн чадвартаа тохирсон орон сууцтай болох хувилбаруудыг дахин эхлүүлнэ.

**Бизнес эрхлэгчдэд**

Бид аж ахуй эрхэлж байгаа хувь хүн, байгууллага, гарааны бизнес эрхэлж буй залуус, албан бус секторт ажиллаж байгаа иргэдийг орлогоо нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, шинэ технологи нэвтрүүлэхэд төрийн хүнд суртал, олон давхар хяналтыг зохистой түвшинд багасгаж үйл ажиллагааг нь бүх талаар дэмжинэ.

# 1. УХААЛАГ ЗАСАГЛАЛТАЙ ДҮҮРЭГ

**Өнөөгийн нөхцөл байдал:**

Улаанбаатар хот засаглалын хямралд орсон, дэлхийн хотуудтай харьцуулахад хамгийн үр ашиггүй засаглалтай байна. Хэт олон дарга, удирдах ажилтантай боловч ажлын уялдаагүй, санхүүгийн иж бүрэн нарийвчилсан тайлагнал тааруу, үйл ажиллагааны давхардал, хийдэл ихтэй, хариуцлага алдсан албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэдэггүй.

Иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээний санхүүжилт хэд дахин нэмэгдсэн ч иргэдэд хүрдэггүй, хугацаа тодорхой бус, албан тушаалтан хүнд суртал гаргаж иргэдийг чирэгдүүлдэг.

Иргэдээ сонсдоггүй, сонсон ч асуудлыг нь шийдвэрлэдэггүй, иргэдийн оролцооны эрх зүйн орчин тодорхойгүй, иргэдийн саналыг ямар асуудлаар, ямар цар хүрээнд авах талаар тогтсон дүрэмгүй. Бүх төрлийн үйлчилгээнд цахим технологийг ашигладаг болох, орчин үеийн шуудан харилцаа, хүргэлтийн системийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

**Бидний хийх ажлууд:**

Ажлын чиг үүрэг нь тодорхой, цомхон, мэргэшсэн ажлаа мэддэг төрийн албан хаагчидтай захиргаатай болно. Хууль зөрчсөн, иргэдийг чирэгдүүлсэн албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэдэг болно. Иргэдэд үйлчлэх үйлчилгээнд орчин үеийн технологи нэвтрүүлэн, иргэдийн түгээмэл саналыг шийдвэр гаргалтанд тусгаж олон талын оролцоотой ажиллахыг зорино.

### 1.1 Дүүргийн удирдлагыг сайн засаглалтай, хариуцлагатай, шийдвэр гаргалтыг шуурхай, нээлттэй болгох чиглэлээр:

1.1.1 Төрийн үйл ажиллагааны давхардал, хийдлийг арилгаж, үр ашигтай, нээлттэй хариуцлагатай, бүтцэд шилжиж ажиллана.

1.1.2 Нийтийн албан тушаалтнуудын гаргасан шийдвэр, үйл ажиллагаанд үнэлгээ хийж, ил тод болгон, хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлага тооцдог болно.

1.1.3 Дүүргийн удирдлагын шийдвэр гаргалтанд мэргэжлийн холбоод, судалгааны байгууллагууд, эрдэмтэн судлаачид, иргэдийн сонирхлын бүлгүүдийн оролцоог хангана.

1.1.4 Дүүргийн удирдлага болон төрийн бүхий л үйл ажиллагааг явуулдаг газрууд улирал тутам үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа олон нийтэд нээлттэй, ил тод тавьдаг болж цахим хуудсандаа тогтмол байршуулна.

### 1.2 Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүртээмжтэй болгох чиглэлээр:

1.2.1 Төрийн бүхий л үйлчилгээг иргэдэд ойртуулах, нэг цэгийн болгох бөгөөд төрийн албан хаагчийн ёс зүйг сахиулж, хүнд сурталгүй албан хаагч ажиллана.

1.2.2 Жишиг цогцолбор хорооны төвүүдийг шинээр барихад дэмжиж ажиллана. Ингэснээр дэлхийн бусад хотуудад байдаг коммунити центрийн загвараар иргэд төрийн үйлчилгээ, спорт заал, хурал уулзалтын танхим, хүүхдийн өдөр өнжүүлэх, төрөл бүрийн дугуйлан, эмнэлэгийн үйлчилгээ бүхий цогцолбор үйлчилгээг авдаг болно.

1.2.3 Иргэдэд үйлчлэхдээ улс төрийн аль нэг нам, эвсэлд хамаарч байгаа эсэхээс үл хамааран төрийн үйлчилгээг чирэгдэлгүй ижил хүргэхэд онцгой анхаарч ажиллана.

**1.3 Иргэд, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:**

1.3.1 Дүүрэг хөгжүүлэх, тохижуулах асуудлаар шийдвэр гаргахдаа иргэдийн түгээмэл саналд үндэслэдэг болно.

1.3.2 11-11 дуудлагын төвийг дахин ажиллуулна.

## 2. АЖИЛ ОРЛОГОТОЙ ДҮҮРЭГ

**Өнөөгийн нөхцөл байдал:**

Монгол Улсын аж ахуйн нэгжүүдийн 90% нь нийслэлд байрладаг ч Сонгинохайрхан дүүргийн хувьд аж ахуйн нэгж байгууллага цөөн, тэр хэмжээгээр ажлын байр, иргэдийн орлого тааруу байдаг.

**Бидний хийх ажлууд:**

Бид бизнес эрхлэхэд таатай, иргэд нь тогтмол ажилтай орлоготой дүүрэг болох эрхэм зорилго тавина.

**2.1 Бизнес эрхлэхэд таатай орчин бүрдүүлэх чиглэлээр:**

2.1.1 Зөвшөөрлөөс бүртгэл рүү гэсэн зарчим баримтлана. Олон шат дамжлага хүнд суртал бүхий зөвшөөрлын системийг халж бизнес эрхлэхийг хүссэн хүн бүхэн бүртгүүлээд үйл ажиллагаагаа явуулж эхлэх боломжтой байх орчныг дэмжиж ажиллана.

2.1.2 Алслагдсан хороодод аж ахуй эрхлэх байдлыг дэмжихийн зэрэгцээ ажлын байр бий болгож буй аж ахуйн нэгжүүдийг хуулийн хүрээнд дэмжиж ажиллана.

2.1.3 Дүүрэгтээ гадаадын жуулчдад зориулсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгож, аюулгүй байдлыг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.1.4 Хувийн хэвшилтэй хамтран иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг танилцуулах үзэсгэлэн худалдааны Сонгинохайрханд үйлдвэрлэв төв байгуулахад дэмжиж ажиллана.

**2.2 Эдийн засгийг тэлэх, ажлын байр бий болгох чиглэлээр:**

2.2.1 Авто тээврийн худалдаа, үйлчилгээний төвийг хөгжүүлнэ.

2.2.2 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байр” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
2.2.3 Хөнгөн үйлдвэрлэл, технологийн парктай болно.
2.2.4 Хог дахин боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана.
2.2.5 Өрхийн санхүүг дэмжихийн тулд тэдэнд байгаа газар, хашаанд тулгуурлан хүлэмжийн аж ахуй эрхлэх, түүнийг худалдан борлуулах тогтолцоог дэмжиж ажиллана.
2.2.6 Дүүрэгтээ хөдөлмөр зуучлалын төв бий болгож, ажилгүй иргэдийг зуучилж, байршуулдаг тогтолцоог бий болгоно.
2.2.7 Залуусын гарааны бизнесийг бодитойгоор дэмжиж ажиллана.

## 3. ЗӨВ ТӨЛӨВЛӨЛТТЭЙ ДҮҮРЭГ

**Өнөөгийн нөхцөл байдал:**

Дүүргийн төлөвлөлт тааруу, ил тод биш. Олон нийт төлөвлөлтийг мэддэггүй учир ухаалаг оролцоо, хяналтын тогтолцоо байдаггүй. Үүний үр дүнд хүүхдүүдийн тоглох талбай, настан буурлуудын нарлах орон зай, ногоон байгууламж, дэд бүтэц муу байна.
Явган болон унадаг дугуйгаар аюулгүй зорчих дэд бүтэц баригдаагүй. Нийтийн тээвэр, такси үйлчилгээ зэргийг цогцоор хөгжүүлээгүйгээс болж авто хөдөлгөөний түгжрэл сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэн.

**Бидний хийх ажлууд:**

Бид дүүргээ зөв төлөвлөж, түүнийг ил тод, нээлттэй болгож, иргэд, мэргэжлийн байгууллагуудын оролцоог хангахад дэмжиж ажиллана. Нэн тэргүүнд хүүхдүүд, ахмадууд, тусгай хэрэгцээт хүмүүст ээлтэйгээр хэрэгжүүлэхийг зорьж явган алхах болон дугуйн замуудтай, амарч зугаалах таатай орчинтой дүүргийг байгуулна.

### 3.1 Төлөвлөлт, хөгжлийн чиглэлээр:

3.1.1 Төлөвлөлтийг ил тод, нээлттэй болгож, олон нийтэд шилэн болгох.
3.1.2 Барилгажилтыг дэмжихгүй нийтийн эзэмшлийн байршлуудыг шинэчлэн тодорхойлж, уг байршилд шинээр байшин барилга бариулахгүй байх шийдвэр гаргаж, иргэдэд танилцуулна.
3.1.3 Гэр хорооллын иргэдэд төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны хангамжид холбогдсон амины орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлнэ.
3.1.4 Нийтийн бие засах газрыг байгальд ээлтэй болгож хүрэлцээг эрс нэмэгдүүлнэ.
3.1.5 Сэргээгдэх эрчим хүч, байгаль орчинд ээлтэй дэд бүтцийн шийдлүүдийг дэмжинэ.
3.1.6 Замын дагалдах дэд бүтэц болох ус зайлуулах шугам, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийг олон улсын стандартаар барина.
3.1.7 Дүүрэгт авто зогсоолын тоог төрөлжүүлж, нэмэгдүүлж, автозамын өргөтгөл, шинэчлэлийн ажлыг тогтмол хийнэ.

3.1.8 Осол аваар гардаг замуудад хяналтын камер, хурд хэмжигч, хурд сааруулагч байршуулна.

3.1.9 Гудамжуудыг иргэд, аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт хийж, тохижуулж, өөрсдийн нэрээр нэрлүүлэх боломжтой болгоно.

3.1.10 Гэр хорооллын цахилгаан хүчдэлийн уналттай өрхүүд, огт цахилгаанд холбогдоогүй айл өрхүүдийг тогтвортой цахилгаан хангамжтай болгоно.

3.1.11 Баянхошуу, Толгойт бүсүүдэд стандарт шаардлагад нийцсэн хүнсний болон барааны худалдаа үйлчилгээний цогцолбор төв байгуулах

## 3.2 Гэр хорооллыг дахин төлөвлөх, орон сууцны орчныг сайжруулах чиглэлээр:

3.2.1 Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үргэлжлүүлж, орон сууцжуулах олон хувилбарт бодлого хэрэгжүүлнэ.

3.2.2 Гэр хорооллын дахин төлөвлөлтөөс чөлөөлөгдсөн газар дээр иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэх цэцэрлэгт хүрээлэнгүүдийг байгуулна.

3.2.3 Цэвэр усны түгээлт, ариутгах татуургын хүртээмжийг тогтвортойгоор шинэчлэн сайжруулж ухаалаг хүртээмжтэй болгоно.

3.2.4 Ашиглалтын шаардлага хангахгүй болсон орон сууцнуудын дахин төлөвлөлтийн төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

3.2.5 Гэр хорооллыг инженерийн дэд бүтэц /цэвэр ус, бохир ус ариутгах татуурга, интернэт шилэн кабель/-д холбож, халаалтыг төвлөрсөн болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй, дулаан алдагдал багатай амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг дэмжих зорилгоор иргэдийн амьдран суух байшингаа барихад нь дэмжлэг үзүүлж ажиллана.

3.2.6 Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээр айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон, амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.

3.2.7 Орлогод нь нийцсэн төлбөр бүхий ''Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг дэмжиж нэн тэргүүнд залуу гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудыг дэмжих бодлого баримтлана.

3.2.8 Гэр хорооллын яндан цөөрүүлэх, утаа угаарыг багасгах бодлогыг дэмжин хувийн хэвшилтэй хамтран ажиллаж шинэ дэвшилтэт технологи, инновацийн шинэ санааг дэмжинэ.

3.2.9 Гэр хорооллыг өвлийн цагт цахилгаанаар халаах чадвартай болгох үүднээс цахилгаан дамжуулах чадамжийг нэмэгдүүлж, эрсдэлгүй аюулгүй дэд бүтцээр хангана.

## 3.3 Хот доторх хөдөлгөөнийг сайжруулах чиглэлээр:

3.3.1 “Бүхний түрүүнд явган зорчигч” зарчмыг хэрэгжүүлж иргэд явган алхах боломжийг бүрдүүлэх зорилгоор авто зам бүхий газар бүр явган хүний зам төлөвлөж ажиллана.

3.3.2 Иргэдийн чөлөөтэй зорчих эрхийг хязгаарласан, хотын өнгө үзэмжид сөргөөр нөлөөлсөн хашаа, хаалтуудыг буулгах, чөлөөлөх шийдвэртэй арга хэмжээнүүдийг авна.
3.3.3 "Унадаг Дугуйтай Улаанбаатар" хөтөлбөрийг дэмжиж ажиллана.
3.3.4 Нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулж, төлөвлөлтийг бүсчлэлд тулгуурлан цагийн хуваарийн дагуу явуулдаг болгоно.
3.3.5 Тэргэнцэртэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийтийн тээврээр саадгүй зорчих стандартыг тогтоож, хэвшүүлнэ.
3.3.6 5 шарын төмөр замтай уулзварын түгжрэлийг бууруулахын тулд цэргийн хотхоноос "хорин хоёр" явах замтай холбогдох шинэ уулзваруудыг нэмэгдүүлэх ажлыг хийнэ.

## 4. ЭКО ДҮҮРЭГ

**Өнөөгийн нөхцөл байдал**

Улаанбаатар хот нэг сая хүрэхгүй модтой, ногоон байгууламж муутайгаас агаар, хөрс, орчны бохирдол, тоосжилт зэрэг олон сөрөг үр дагавар бий болж байдаг. Ялангуяа Сонгинохайрхан дүүргийн агаарын болон хөрсний бохирдол иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх түвшинд ирээд байна.
Цэвэр ус, хог хаягдлын ачилт тээвэрлэлт хүрэлцээгүй, ангилан ялгалт хэвшээгүй, хог боловсруулах үйлдвэргүй, энэ чиглэлийн менежмент бүхэлдээ үгүйлэгдсээр байна.

**Бидний хийх ажлууд:**

Бид дүүргээ хүрээлэн буй орчин, байгаль экологитойгоо нягт шүтэлцээтэй ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, ус, агаар, хөрсний бохирдлыг эрс бууруулж, нөөцийг хэмнэлттэй, ухаалаг зарцуулах тогтолцоонд шилжсэн тогтвортой хөгжилтэй дүүргийг байгуулна.

### 4.1 Хүрээлэн буй орчныг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр:

4.1.1 Дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хөрсний чанарыг сайжруулах зорилгоор гэр хорооллын айл бүрт хашаандаа мод тарих, хүлэмжийн аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгоно.
4.1.2 Харшил үүсгэгч шарилж зэрэг нэр бүхий зэрлэг ургамлыг устгаж, иргэдийн эрүүл таатай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
4.1.3 Улаанбаатар хотын салхин талд байрладаг Улаан чулуут хогийн цэгийг шилжүүлж түүний газрыг үндэсний цэцэрлэгт хүрээлэн болгох ажлыг дэмжиж ажиллана.
4.1.4 Нарангийн энгэрийн чимээгүй хотыг ногоон байгууламжаар хүрээлэн тохижуулна.

**4.2 Агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:**

4.2.1 Гэр хорооллын янданг цөөрүүлэх зорилгоор орон сууцжуулах хөтөлбөрийг эрчимжүүлэн хэрэгжүүлж, ипотекийн зээлийн олголтыг гэр хорооллоос орон сууцанд орж буй зорилтот бүлэгт нэмэгдүүлнэ.
4.2.2 Нийслэлд агаарын бохирдлыг бууруулах зорилгоор "Өнтэй өвөлжье" төсөл хэрэгжүүлж, гэр хорооллын айлын дулаан алдагдлыг бууруулах, байгальд ээлтэй, дулаан алдагдал багатай сууцуудыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
4.2.3 Агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд "Эрчим хүч үйлдвэрлэгч иргэн" хөдөлгөөнийг гэр хороололд өрнүүлж, иргэд хашаандаа нар салхины сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэн хэрэглэхээс гадна илүүдэл эрчим хүчээ төвийн эрчим хүчний сүлжээнд худалдан борлуулахыг дэмжинэ.
4.2.4 Хүрээлэн буй орчинд ээлтэй бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.

**4.3 Нөөцийг тогтвортой ашиглах, хог хаягдлын менежентийг сайжруулах чиглэлээр:**

4.3.1 Усыг дахин ашиглах "Саарал ус"-ны технологийг нэвтрүүлнэ.
4.3.2 Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, хогийг ангилан хаях, нэгдсэн стандартад шилжүүлж, хог боловсруулах, буцаан ашиглах үйлдвэр байгуулна.
4.3.3 Аюултай хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, саармагжуулах, устгах тогтолцоог бий болгоно.
4.3.4 Орон сууцны хороолол дунд хог хаягдлыг ангилан байршуулах хэвшлийг нэмэгдүүлнэ. Иргэд дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж тушааснаар зарим үйлчилгээг (нийтийн тээвэр г.м) үнэ төлбөргүй авах хөшүүргийг нэвтрүүлнэ.
4.3.5 Хөрсний усны эрсдэлийг 90 хувь хүртэл бууруулна. Био цөөрөм, хөв цөөрөм байгуулах зэргээр олон улсын технологийг судлан эрдэмтэдтэй хамтран төсөл хэрэгжүүлнэ.
4.3.6 Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих, цахилгаан сүлжээн дэх нийлүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлнэ.
4.3.7 Эрчим хүчний хэмнэлтийг дэмжих, хэрэглээг зүй зохистой удирдах зорилгоор ухаалаг сүлжээг нэвтрүүлнэ.

## 5. ЭЭЛТЭЙ ДҮҮРЭГ

### Өнөөгийн нөхцөл байдал

Сүүлийн жилүүдэд гэмт хэргийн түвшин буурахгүй байгаагийн зэрэгцээ зам тээврийн осол, аваар их гарч байна. Хүүхдэд ээлгүй байна. Гэр хороололд харанхуй, цагдаагийн эргүүл, хараа хяналт бага байгаа нь гэмт хэрэг гарах үндэс болж байна. Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын ачаалал хэтэрсэн, хүүхдийн цэцэрлэгийн хүрэлцээ муу, суурь боловсролын байгууллагуудын сургалтын чанар, сурах орчин, түвшин харилцан адилгүй, ялгаа ихтэй байна.

Иргэд амарч тухлах цэцэрлэгт хүрээлэн байхгүй, иргэдийн ажиллаж, амьдрах орчинг сайжруулаагүй 4 жил өнгөрч байна.

**Бидний хийх ажлууд:**

Бид сурч хөгжих, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ авах боломж бүрдсэн, биеийн тамираар хичээллэдэг, авьяаслаг иргэдтэй, урлаг, гоозүйн үнэт капиталыг хуримтлуулсан, иргэндээ ээлтэй хот болгоно.

**5.1 Амьдрахад таатай, аюулгүй орчин бий болгох чиглэлээр:**

5.1.1 Хуучны угсармал орон сууцны дулаалгыг бүрэн дуусгана.
5.1.2 Орон сууцны дундах бетон болон тоосгон гражтай иргэдийг нэгдсэн дулаан зогсоолтой болгох зохион байгуулалтыг хуулийн хүрээнд дэмжиж ажиллана.
5.1.3 Гэр хорооллын айл өрхийн түлшний хэрэглээг аюулгүй болгоно.
5.1.4 Агаар дахь хорт хийн хэмжээг эрүүл ахуйн шаардлага стандартын хэмжээнд хүртэл багасгаж, халаалтын шинэ технологийг дэмжин агаарын бохирдолгүй болгоно.
5.1.5 "Гудамж" төслийг үргэлжлүүлэн дэмжиж авто замын уулзварыг шинээр барьж түгжрэлийг бууруулна.
5.1.6 Хүүхдэд ээлтэй хот болох цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.
5.1.7 Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцнуудыг буулгаж, шинээр барих дахин төлөвлөлтийн төслүүдийг хэрэгжүүлнэ.
5.1.8 Ногоон байгууламж, амралт зугаалгын бүс, цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлуудыг бүх талаар дэмжиж ажиллана.
5.1.9 Нүхэн жорлон, ядангийн тоог цөөлж "Хашаандаа сайхан амьдаръя" төслийг хэрэгжүүлнэ.
5.1.10 Улаанбаатар хотын гэр хорооллын болон хотын гудамжнуудыг бүрэн камержуулах, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх замаар гэмт хэргийн гаралтыг бууруулж, хяналтыг сайжруулна.
5.1.11 Цагдаагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, "Миний Цагдаа намайг хамгаална" гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
5.1.12 Төвөөс алслагдсан бүсийн иргэдэд гамшгаас хамгаалах системийг бий болгож аврах, гал унтраах ангийг шинээр байгуулахад дэмжиж ажиллана.
5.1.13 Улаанбаатар хотын соёлт иргэнийг төлөвшүүлэх чиглэлээр "Хотын соёл" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
5.1.14 Хөршийн холбоо, олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг идэвхжүүлэн дэмжиж орчны аюулгүй байдлыг сайжруулна.

**5.2 Эрүүл мэнд, боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр:**

5.2.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох дэд бүтцийг бий болгоход онцгойлон анхаарна.
5.2.2 Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлнэ.

5.2.3 Бага насны хүүхэд 500 метрийн радиус дотор цэцэрлэг, сургуульдаа хүрэх боломжийг төлөвлөж ажиллана.

5.2.4 Алслагдсан сургуулиудад автобус ажиллуулж, хүүхдийн сургуульдаа аюулгүй ирж, очих нөхцөлийг бүрдүүлнэ.

5.2.5 Хүүхэд хөгжлийн ордон байгуулж боловсролын тэгш бус байдлыг бууруулахад онцгой анхаарч ажиллана.

5.2.6 Сургууль бүрийг 2-оос дээшгүй ээлжээр хичээллэдэг болгоно.

5.2.7 ЕБС-ын үндсэн хичээлээс гадна сурагчдын оюун ухаан, бүтээлч байдлыг хөгжүүлэх, мэдээллийн технологийн орчин үеийн мэдлэг олгох зорилгоор хиймэл оюун ухаан, кодчилол, роботчилол, технологийн лаборатори, дизайны чиглэлийн суурь хөтөлбөрүүдийг хувийн хэвшилтэй хамтран явуулдаг тогтолцоог дэмжиж ажиллана.

5.2.8 Гэр бүл, хүний эрхийг хамгаалах чиглэлээр сургалт сурталчилгааг тогтмолжуулна.

5.2.9 Хороо бүрд урьдчилсан сэргийлэх эмч ажиллуулж, иргэдийн эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, эрүүл мэнд, биеийн тамирын өрөө, талбайг тохижуулж спортоор хичээллэх боломжийг бий болгоно.

5.2.10 Жирэмсэн эхчүүд, хүүхэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, ахмад настнууд уруу чиглэсэн нийгмийн болон эрүүл мэндийн бодлогыг дэмжиж эмнэлгийн үйлчилгээг сайжруулах хөтөлбөр боловсруулна.

5.2.11 Сургуулийн эргүүл төслийг үргэлжлүүлэн дэмжиж, сурагч хүүхдүүд сургуульдаа ирэх, гэрлүүгээ буцах замдаа халдлагад өртөхгүй аюулгүй байх үүднээс ухаалаг мэдээлэгчтэй сурагчийн үнэмлэхийг нэвтрүүлж, сургуулийн ойр орчим, автобусны буудал, сургуулийн автобусанд долгион дамжуулагч суурилуулна. Ингэснээр сурагчдын байршил, аюулд өртөж буй эсэх мэдээлэл нь аав ээжийнх нь гар утсанд ирдэг болно.

5.2.12 Гэр хорооллын дахин төлөвлөлтөөс чөлөөлөгдсөн газар дээр олон нийтийн номын санг байгуулах ажлыг дэмжиж ажиллана.

5.2.13 Мэдээллийн технологийн дэд бүтцийг өргөжүүлж, өргөн зурвасын, өндөр хурдны интернет сүлжээг ялангуяа гэр хорооллын бүсэд нэвтрүүлэхэд онцгойлон анхаарна.

## 5.3 Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар, соёл, урлагийн байгууламжуудыг хамгаалах чиглэлээр:

5.3.1 Соёлын өвийг хамгаалах төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж, дүүрэгт аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлнэ.

5.3.2 Иргэдийн амрах, зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх цэцэрлэгт хүрээлэн, авто машины зогсоол, саравч, хүүхдийн тоглоомын талбай, боловсон бие засах газрууд бүхий цэгүүд байгуулна.

5.3.3 Өвлийн спортын ордонг гадаад болон дотоодын хөрөнгө оруулалт, улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээр санхүүжүүлж байгуулах ажлыг дэмжиж ажиллана.

5.3.4 Хувийн хэвшлүүдтэй хамтран ахмадын сувилал байгуулахад дэмжиж ажиллана.

5.3.5 Газрын нэгдсэн үзлэг зохион байгуулж, ашиглалт, эзэмшлийн зөрчилтэй газруудыг эргүүлэн авч, нийтийн зориулалттай ногоон байгууламж болгоно.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 920

танай ____________-ны №_____________-т

СҮХБААТАР ДҮҮРГИЙН
АРДЧИЛСАН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Сүхбаатар дүүргийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Сүхбаатар дүүргийн Ардчилсан намын Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор иргүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дах хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сүхбаатар дүүргийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөр /.9.. хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Сүхбаатар дүүргийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

# СҮХБААТАР ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Улаанбаатар хот 2024 он

АРДЧИЛСАН НАМ
СҮХБААТАР ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7576
УЛААНБААТАР ХОТ

# СҮХБААТАР ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

## ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СҮХБААТАР ДҮҮРЭГ

1. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД СУУРИЛЖ НЭЭЛТТЭЙ, ХАМТРАН АЖИЛЛАХ БОДЛОГО
2. БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО
3. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ БОДЛОГО
4. АМЬДРАХАД ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ БОДЛОГО
5. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХ, ГАДААД ХАРИЛЦААГ БЭХЖҮҮЛЭХ БОДЛОГО

НАМ
СҮХБААТАР ДҮҮРГИЙН
НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7576
УЛААНБААТАР ХОТ

## НЭГ.

## ИРГЭДИЙН ОРОЛЦООНД СУУРИЛЖ НЭЭЛТТЭЙ, ХАМТРАН АЖИЛЛАХ БОДЛОГО

### 1.1. Ил тод байдал

1.1.1. Иргэд, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг бүрэн цахимжуулна.

1.1.2. Дүүргийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрүүдийг иргэдэд цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан мэдээлж, тайлагнаж ажиллана.

1.1.3. Иргэдэд төрийн үйлчилгээг “Хөдөлгөөнт оффис”-оор үргэлжлүүлэн үзүүлнэ.

1.1.4. Төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэд, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж, нэг удаагийн бүртгэлд үндэслэн төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болно.

1.1.5. Хороодын иргэний танхимуудаар дамжуулан төр засгийн тогтоол шийдвэрүүдийг тогтмол мэдээлж, иргэдийн хүсэл сонирхолд нийцсэн соёл, спорт зэрэг идэвхитэй зөв амьдралын дадлыг нэмэгдүүлэх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлнэ.

1.1.6. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааг хуульд заасанаар ил тод мэдээлнэ.

1.1.7. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт мэдээллийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэх, хариу өгөх хугацааг багасгана.

### 1.2. Хамтын ажиллагаа

1.2.1. Иргэдийн санал үндэслэн дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудыг төлөвлөж, хэрэгжүүлдэг тогтолцоог үргэлжлүүлнэ.

1.2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтээн байгуулалтын ажлуудыг иргэдээс цахимаар өгсөн саналуудад үндэслэн эрэмбэлэн төлөвлөж, хэрэгжилтийг ил тод мэдээлнэ.

1.2.3. Засгийн газар, Нийслэлээс хэрэгжүүлэх урт, богино хугацааны хөгжлийн бодлогуудыг орон нутагтаа хэрэгжүүлнэ.

1.2.4. Төрийн албан хаагчдийг чадавхжуулах замаар иргэдэд төрийн үйлчилгээг хүнд сурталгүй хүргэх боломжийг нэмэгдүүлнэ.

## ХОЁР.

## БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

### 2.1. Боловсрол

2.1.1. Хүүхэд хөгжил, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээрх байгууллагуудтай хамтран ажиллана.

2.1.2. Цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй байх нөхцлийг бүрдүүлнэ.

...НИЛСАН НАМ
СҮХБААТАР ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8480916 ХТО7576
УЛААНБААТАР ХОТ

2.1.3. Цэцэрлэг сургуулийн хүртээмжийг үргэлжлүүлэн нэмэгдүүлж, хүүхэд нэг км радиус дотор цэцэрлэг, сургуульдаа явах боломжийг бүрдүүлнэ.
2.1.4. Хүүхдийн эрхийг хамгаалах, тэдний хөгжих боломжийг нэмэгдүүлэх "Хүүхэдхөгжлийн төв"-ийг сургуулиудад байгуулна.
2.1.5. Хүүхдийг хотын соёлд суралцуулах, сөрөг зан үйл хорт зуршил, цахим халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг хийнэ.
2.1.6. Сургуулийн автобусны үйлчилгээг нэмэгдүүлж, хүүхэд сургуульдаа аюулгүй ирж буцах нөхцлийг хангана.
2.1.7. Сургууль, цэцэрлэгийн засвар, тохижилтын хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх цахим мэдээллийн сан бүрдүүлнэ.
2.1.8. Сургалтын орчинг сайжруулах чиглэлээр олон улсын хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
2.1.9. Багш, удирдах ажилтны нэр хүнд, мэргэжлийн ёс зүй, ур чадвар, арга зүй, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхаарч ажиллана.
2.1.10. Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах талаарх мэдээллийг хүүхэд, залуучуудад сурталчлан таниулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
2.1.11. Суралцагчдад сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, мэргэжлээ сонгоход нь туслах, зөвлөгөө өгөх мэргэжилтнүүдийг ажиллуулж, сургууль бүрд "Ирээдүйн ээзд кабинет"-ийг байгуулж, орчин нөхцлийг сайжруулна.
2.1.12. Сургалтын байгууллагын ажилтнуудын мэргэжил ур чадварыг дээшлүүлэх зорилгоор тэднийг гадаад, дотоодын урт, богино хугацааны туршлага солилцох сургалтуудад хамруулна.
2.1.13. Сургуулиудад өдөр өнжүүлэх үйлчилгээг үзүүлэх боломжийг бүрдүүлэх, анги танхимын хүрэлцээг нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.
2.1.14. Хичээлээс гадуурх хүүхдүүдийн сонирхол, авъяас чадварыг нээн хөгжүүлэх сонгон, дугуйлангийн үйл ажиллагааг дэмжинэ.
2.1.15. Сургуулийн өмнөх боловсрол болон бүрэн дунд боловсролын сургалтын чанарт тавих хяналтыг сайжруулна.

## 2.2. Эрүүл мэнд – Эрхэм баялаг

2.2.1. Бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, эрүүл аж төрөх дасгал хөдөлгөөн, зөв хооллолтыг дэмжин сурталчилах ажлуудыг зохион байгуулна.
2.2.2. Нэгдсэн эмнэлэгийг бүрэн ашиглалтанд оруулж үйл ажиллагааг нь жигдрүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулж нэмэгдүүлнэ.
2.2.3. Эрүүл мэндийн төв - Нэгдсэн эмнэлэгт орчин үеийн дэвшилтэд тоног төхөөрөмжүүдийг нэвтрүүлж, эрүүл мэндийн оношилгоо, шинжилгээ, мэс засал болон бусад тусламж үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай үзүүлнэ.
2.2.4. Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтыг хэрэгжүүлж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
2.2.5. Алсын зайн оношилгоо, үйлчилгээг шинэ түвшинд гаргаж, цахимжуулж хөгжүүлнэ.

...НИЛСАН НАМ
СҮХБААТАР ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041500
8488916 ХТО7576
УЛААНБААТАР ХОТ

2.2.6. Дүүргийн оношилгооны чадавхийг дээшлүүлж, иргэн бүр эрүүл мэндийн бүрэн оношилгоонд жил бүр хамрагдах нөхцлийг бүрдүүлнэ.
2.2.7. Чихрийн шижин, цусны даралт ихсэх, хорт хавдар, зүрх судасны өвчлөл зэрэг зонхилон тохиолдох халдварт бус өвчнүүдээс иргэдийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт жилд нэгээс доошгүй удаа хамруулах ажлыг зохион байгуулна.
2.2.8. Зорилтод бүлгийн иргэдийг БЗХӨ, ХДХВ, сүрьеэ, хепатитийн В, С вирус зэрэг халдварт өвчний эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулах ажлыг зохион байгуулна.
2.2.9. Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах, энэ төрлийн боловсрол олгох, эмчлэх "Эрүүл хүүхэд-Гэрэлт ирээдүй" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
2.2.10. Халдварт өвчнүүдийн дархлаажуулалтын ач тусыг иргэдэд таниулах, хамрагдалтыг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулна.
2.2.11. Ахмад настан, эмзэг бүлгийн иргэдийн суурь судалгаанд үндэслэн, эрүүл мэндийн байдлыг дэмжин хөтөлбөр, арга хэмжээнүүдэд хамруулна.
2.2.12. Ахмад настанд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлэх, иргэд, залуучуудын сайн дурын санаачлага, хөдөлгөөнийг дэмжин "Танд туслая" аяныг зохион байгуулна.
2.2.13. Ахмад настнуудын эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах, тэдний насны онцлогт тохирсон нийгмийн амьдралд татан оролцуулах ажлуудыг дүүргийн Ахмадын хөгжлийн төвөөр дамжуулан хэрэгжүүлнэ.
2.2.14. Эмнэлэгийн ажилтнуудын мэргэжил ур чадварыг дээшлүүлэх зорилгоор тэднийг гадаад, дотоодын урт, богино хугацааны туршлага солилцох сургалтуудад хамруулна.
2.2.15. Эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх зорилгоор "Эрүүл эр хүн-Жаргалтай гэр бүл" хөтөлбөр, эмэгтэйчүүдийн умайн хүзүү, хөхний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор "Эрүүл эмэгтэй-Жаргалтай гэр бүл" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

**2.3. Соёл, спорт**

2.3.1. Төрөөс соёлын талаарх баримтлах бодлогыг хэрэгжүүлж, хүүхэд, залуучууд, иргэдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлэх урлагийн наадам, чуулган, мэтгэлцээн, хэлэлцүүлэг зэрэг олон нийтийн арга хэмжээг дэмжин ажиллана.
2.3.2. Хүүхэд залуучуудын бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор биеийн тамир, спортын тэмцээн уралдааныг тогтмолжуулж, спорт заал, гадна талбайг нэмэгдүүлнэ.
2.3.3. Дүүргийн өсвөр үе, залуучуудын шигшээ багуудын үйл ажиллагааг дэмжинэ, өргөжүүлнэ.
2.3.4. Хүүхэд, залуучуудыг эх орныхоо түүхэн дурсгалт газрууд, соёлын өвтэй танилцах, их түүхийхээ мэдлэг олгох ажлуудыг зохион байгуулна.
2.3.5. Соёл, урлаг, спортын чиглэлээр онцгой амжилт гаргасан иргэдийг урамшуулах, алдаршуулах үйл ажиллагааг дэмжинэ.
2.3.6. Дүүргийн иргэдийн бие бялдрыг хөгжүүлэх, зөв соёлыг хэвшүүлэх зорилгоор "Спорт цогцолбор"-ыг ашиглалтад оруулж үйл ажиллагааг нь тогтмолжуулна.

...ЧИЛСАН НАМ
СҮХБААТАР ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7576
УЛААНБААТАР ХОТ

## ГУРАВ.

## ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ БОДЛОГО

**3.1. Тогтвортой өсөлт**

3.1.1. Жил бүр Дүүргийн төсвийг Улс, Нийслэлийн төсвийн бодлого, өсөлттэй уялдуулан оновчтой төлөвлөж, өрх бүрийн амьдралд бодитойгоор нөлөөлж, үр дүн гаргах төсвийн бодлого хэрэгжүүлнэ.

3.1.2. Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлуудыг оновчтой төлөвлөж, хөрөнгө оруулалтын хэмжээг жил бүр нэмэгдүүлнэ.

**3.2. Хөдөлмөр эрхлэлт**

3.2.1. Монголын цахиурын хөндий буюу технологийн шийдэл ашиглаж, нийгэмд хэрэгцээ, шаардлагыг шийдвэрлэж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийг дэмжиж хамтран ажиллана.

3.2.2. Орон нутгийн төсвийн татварын орлогыг бүрдүүлэгч татвар төлөгч, ажил олгогчдын чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, түүнийг шийдвэрлэхэд хамтран ажиллана.

3.2.3. Оюутан, залуучуудыг ажлын байраар хангаж байгаа аж ахуйн нэгжүүдийг дэмжин ажиллана.

3.2.4. Иргэдийн хөдөлмөр эрхлэх, бизнесээ эхлүүлэхэд нь туслах сургалтуудыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

3.2.5. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг технологийн шийдлээр дэмжихэд анхаарч, тэдний бүтээгдэхүүн үйлчилгээг борлуулах борлуулалтыг дэмжин улирлын чанартай худалдааг зохион байгуулна.

3.2.6. Дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн орчин нөхцлийг сайжруулж, үйлдвэрлэл эрхлэгчдийн байнгын хамтын ажиллагааг бий болгож, сургалт, судалгаа, үзэсгэлэн худалдааг тогтмол зохион байгуулна.

3.2.7. Зах зээлд инноваци шингэсэн шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг амжилттай нэвтрүүлж борлуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийг дэмжин гадаад, дотоодын зах зээлд таниулах үзэсгэлэн худалдаанд хамруулна.

3.2.8. Гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх, бизнес инкубацын үйл ажиллагаагаар бойжуулах, томруулах бодлого хэрэгжүүлэх, хамгийн бага түрээс төлөх сувгуудийг бий болгох.

3.2.9. Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчидтэй хамтран ажиллаж, үйл ажиллагааг нь дэмжинэ.

## ДӨРӨВ.

## АМЬДРАХАД ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ БОДЛОГО

**4.1. Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин – Бүтээнбайгуулалт**

...НИЛСАН НАМ
СҮХБААТАР ДҮҮРГИЙН
НАМЫН ХОРОО
9023041590
8486916 ХТО7576
УЛААНБААТАР ХОТ

4.1.1. Иргэдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор биеийн тамир спортын үйл ажиллагаануудыг явуулах боломжтой цэцэрлэгт хүрээлэн бүхий Спорт цогцолборыг ашиглалтанд оруулна.

4.1.2. Хүүхэд залуучуудын байгаль экологийн мэдлэгийг нэмэгдүүлэх, иргэдийн эх дэлхийгээ хайрлан хамгаалж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцлийг нэмэгдүүлнэ.

4.1.3. Хүүхэд залуучууд, ахмад настнуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, авъяас чадвараа хөгжүүлэх, тэдний эрхийг хамгаалах нөхцөл бүхий төвүүдийг нэмж байгуулна.

4.1.4. Ахмадуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор ахмадад зориулсан төвүүдийг байгуулах, олон талын идэвхи санаачилгыг дэмжиж ажиллана.

**4.2 Тохижилт, ногоон байгууламж**

4.2.1. Сургалтын байгууллагын орчинд гэрэлтүүлэг, камержуулалт, ногоон байгууламж, тохижилтыг нэмэгдүүлнэ.

4.2.2. Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандарыг сайжруулж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг нэмэгдүүлнэ.

4.2.3. Иргэдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, иргэд олноор зорчдог хэсгийг камер, орц гарцны тэмдэглэгээ, гэрлэн дохио, хурд сааруулагчтай болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

4.2.4. Гэр хорооллын бүсийн хаягжилтын байдлыг сайжруулж, газар зүйн мэдээллийн сангийн систем баяжилт хийж, иргэдийн хайлт, байршил тогтоох хэрэглээг хялбарчилна.

4.2.5. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалтийг нэмэгдүүлж, хэвийн ажиллагааны арчлалт хамгаалал, хяналтыг сайжруулна.

4.2.6. Хороолол дундах сайжруулсан шороон замуудыг хатуу хучилттай болгож шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.2.7. Ил далд авто зогсоол, сул шороон талбайн хучилт, явган зам, гүүр, орц гарц хийх ажлуудыг иргэдийн санал үндэслэн үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.2.8. Орон сууцны байрнуудын фасад, дээвэр, орцны засварын ажлуудыг иргэдийн санал үндэслэн хэрэгжүүлнэ.

4.2.9. Өөрсдийн санаачлагаар амьдрах орчиндоо тохижилт, ногоон байгууламж шинээр бий болгосон иргэд, байгууллагыг дэмжиж хамтран ажиллана.

4.2.10. Дүүргийн хэмжээнд ногоон байгууламжийг 30 хувиар нэмэгдүүлнэ.

**4.3. Иргэнд ээлтэй, аюулгүй орчин**

4.3.1. Агаарын болон хөрсний бохирдлыг бууруулах иргэд, байгууллагуудтай хамтран ажиллаж, тэдний шинэ санал санаачлага, дэвшилтэд технологийг дэмжин ажиллана.

4.3.2. Нийтийн орон сууцны дор үйл ажиллагаа явуулж байгаа, стандартын шаардлага хангахгүй үйлчилгээний байгууллагуудыг цэгцлэнэ.

4.3.3. Сууц өмчлөгчдийн холбоодын хариуцлагыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь ил тод болгоход анхаарч ажиллана.

4.3.4. Гэр хорооллын иргэдийн санал санаачлагад үндэслэн "Жишиг гудамж-Манай гудамж" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

...НИЛСАН НАМ
СҮХБААТАР ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8486916 ХТО7576
УЛААНБААТАР ХОТ

**4.4 Дахин төлөвлөлт – Газар зохион байгуулалт**

4.4.1 Иргэдийн оролцоонд үндэслэн гэр хорооллын дахин төлөвлөлтийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

4.4.2 Нийслэлийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний хүрээнд гэр хороолол болон орон сууцыг дахин төлөвлөх, шинээр бий болгох ажлуудыг дэмжин холбогдох байгууллага, иргэдтэй хамтран ажиллана.

4.4.3 Гэр хорооллын мухар гудамж, зуслангийн орц гарц, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам талбайн газрын зөрчлийг арилгаж, түргэн тусламж, гал унтраах аврах ажиллагааг саадгүй явуулах боломжийг бүрдүүлнэ.

4.4.4 Улс, нийслэл болон гадны төсөл хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа инженерийн дэд бүтцэд гэр хорооллын айл өрхүүдийг холбох ажилд дэмжлэг үзүүлнэ.

4.4.5 “Сэлбэ – сэргэлт” төслийг Нийслэлтэй хамтран хэрэгжүүлж ажиллана.

4.4.6 Стандартын шаардлага хангаагүй орон сууцнуудыг иргэдийн саналыгүндэслэн дахин төлөвлөж шинэчлэх ажлыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлнэ.

## ТАВ
## ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХ, ГАДААД ХАРИЛЦААГ БЭХЖҮҮЛЭХ БОДЛОГО

**5.1. Хүний эрх – Хамгаалал**

5.1.1 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах ажлын хүрээнд өрх толгойлсон эцэг, эх болон зорилтод бүлгийн ахмад настан, хүүхдийг гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг хороодын ажлын алба, бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

5.1.2 Өрхийн амжиргааны түвшинг тогтоох аргачлалыг нарийвчилж, хяналтыг сайжруулж, нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтод бүлгийн иргэдэд оновчтой, чанартай үзүүлэх ажлуудыг дэмжинэ.

5.1.3 Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд, ахмадуудад урт хугацааны нөхөн
сэргээх үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.1.4 Хүүхдэд тулгарч буй үе тэнгийн дээрэлхэлт болон эрүүл мэнд, сэтгэл санааны бусад сорилт, бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн ажлуудыг хийнэ.

5.1.5 Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийн нийгмийн тусламж үйлчилгээ авах, эмчлүүлэх, хөдөлмөр эрхлэх, эрхээ хамгаалуулахад чиглэсэн ажлуудыг дэмжинэ.

**5.2. Гадаад харилцаа**

5.2.1. Гадаад харилцааг өргөжүүлэн уламжлалт харилцаатай улс орны хот, дүүрэгтэй хамтран ажиллах хамтын ажиллагааг бэхжүүлж, шинээр улс орны хот, дүүргүүдтэй эгч, дүүсийн харилцаа тогтооно.

5.2.2. Харилцаат хот, дүүргүүд рүү албан хаагчдыг албан айлчлал, сургалт, хурал, үзэсгэлэн, туршлага судлах аялалд хамруулж мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.

САН НАМ
СҮХБААТАР ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО

5.1.3 Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд, ахмадуудад урт хугацааны нөхөн
сэргээх үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.1.4 Хүүхдэд тулгарч буй үе тэнгийн дээрэлхэлт болон эрүүл мэнд, сэтгэл санааны бусад сорилт, бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн ажлуудыг хийнэ.

5.1.5 Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийн нийгмийн тусламж үйлчилгээ авах, эмчлүүлэх, хөдөлмөр эрхлэх, эрхээ хамгаалуулахад чиглэсэн ажлуудыг дэмжинэ.

**5.2. Гадаад харилцаа**

5.2.1. Гадаад харилцааг өргөжүүлэн уламжлалт харилцаатай улс орны хот, дүүрэгтэй хамтран ажиллах хамтын ажиллагааг бэхжүүлж, шинээр улс орны хот, дүүргүүдтэй эгч, дүүсийн харилцаа тогтооно.

5.2.2. Харилцаат хот, дүүргүүд рүү албан хаагчдыг албан айлчлал, сургалт, хурал, үзэсгэлэн, туршлага судлах аялалд хамруулж мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.

5.2.3. Найрсаг харилцаа, хамтын ажиллагаатай гадаад, дотоодын хот дүүргүүдтэй эмч, сувилагч, багш, сурагч солилцооны хөтөлбөрийг нэмэгдүүлнэ.

5.2.4. Дүүрэгт хэрэгжүүлж болох үр ашигтай гадаадын төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллана

ДЧИЛСАН НАМ
СҮХБААТАР ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7576
УЛААНБААТАР ХОТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 919

танай ___________-ны №___________-т

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
АРДЧИЛСАН НАМЫН
ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Хан-Уул дүүргийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа 2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Хан-Уул дүүргийн Ардчилсан намын Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дах хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хан-Уул дүүргийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөр /18 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Хан-Уул дүүргийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

C:\Users\zendmene.d\Desktop\2024\Word\Явсан бичиг\2024.08.06.HUD.AN.MH.docx

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ХАН-УУЛ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН

# “ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ - СТАНДАРТТАЙ ДҮҮРЭГ”

# МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Улаанбаатар хот
2024 он



АРДЧИЛСАН НАМ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
УЛААНБААТАР ХОТ

# АГУУЛГА

НЭГ. ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ - СТАНДАРТТАЙ ДҮҮРЭГ

ХОЁР. ХОТЫН СОЁЛТОЙ - НОГООН ДҮҮРЭГ

ГУРАВ. АЖИЛ, БИЗНЕС ЭРХЛЭХЭД ТААТАЙ ДҮҮРЭГ

ДӨРӨВ. ХАШААНДАА САЙХАН АМЬДАРЪЯ – ДЭД БҮТЭЦТЭЙ ДҮҮРЭГ

ТАВ. ЦАХИМ ЗАСАГЛАЛ 3.0 ДҮҮРЭГ



АРДЧИЛСАН НАМ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ... ХОРОО
УЛААНБААТАР ХОТ

# “ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ - СТАНДАРТТАЙ ДҮҮРЭГ” МӨРИЙН ХӨТӨЛБӨР

- Ажил, бизнес эрхлэхэд таатай орчин
- Бичил, жижиг дунд үйлбэрлэлийн ажлын байр
- Аялал жуулчлал, томоохон төслүүд
- Хот суурин газруудын мал аж ахуй, газар тариалан

- Тайван нийгэм
- Амьдрахад таатай, аюулгүй орчин
- Эрүүл мэнд, боловсролын чанартай үйлчилгээ
- Харилцаа холбоо,




- Нийгмийн дэд бүтэц
- Инженерийн дэд бүтэц
- Зам тээвэр
- “Ухаалаг хот”-ын суурь бүтээн байгуулалт

- Нээлттэй, хариуцлагатай, бүтээмжтэй ЗАСАГЛАЛ
- Иргэд, бизнест ээлтэй авлигагүй төрийн үйлчилгээ
- Нээлттэй, хариуцлагатай, бүтээмжтэй ЗАСАГЛАЛ
- Нээлттэй, хариуцлагатай, бүтээмжтэй ЗАСАГЛАЛ

# ӨМНӨТГӨЛ

Хан-Уул дүүргийн Ардчилсан нам нь 2008, 2012 онд хоёр ч удаа ХУД-ийн иргэдийн олонхын саналыг авч, сонгуульд ялалт байгуулан 8 жил дүүргээ удирдаж байсан туршлагатай нам билээ. Хан-Уул дүүргийн Ардчилсан нам эрх барьж байх хугацаанд улсын хэмжээнд анхдагч болохоор олон шинэлэг ажлыг санаачлан хэрэгжүүлж, иргэдийн талархлыг хүртэж байсан. Энэ удаад ч бид иргэдийнхээ итгэл, дэмжлэгийг авч чадвал төрийн ажлыг ил тод, шуурхай болгохоос гадна хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг нэмэгдүүлж, иргэдийн оролцоотойгоор хамтран шийдвэрлэнэ.

Хан-Уул дүүргийн удирдлагыг судалгаанд суурилсан шийдвэр гаргадаг, хариуцлагатай, нээлттэй болгох чиглэлээр:

“**Иргэндээ ээлтэй-Стандарттай дүүрэг**” мөрийн хөтөлбөр танилцуулж байна. Тэргүүлэх чиглэлд Хан-Уул дүүргийн иргэдэд зориулж, шударга, нээлттэй засаглалаа сайжруулж, Ахмадууд, Эмэгтэйчүүд, Хүүхэд залуучууд, Хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар дүүргийнхээ иргэдийн амьдралд илүү ойр бодлого шийдвэр гаргаж ажиллахыг энэхүү хөтөлбөрт чухалчилаа.

Дүүргийн удирдлагыг боловсронгуй болгох шинжлэх ухаан, судалгаа, хөгжлийн тинк танк төвийг байгуулж, түүнээс гарах судалгаа, төлөвлөгөө, тооцооллыг дүүргийн бүх шатны шийдвэр гаргах үйл ажиллагаанд тусгах зохицуулалт, зохион байгуулалтыг журам боловсруулж хэрэгжүүлнэ. Дүүргийн удирдлага аливаа суурь шийдвэр гаргахдаа судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, сонирхлын бүлгүүдийн санаачилгыг тусгаж, иргэдийн саналаар шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлнэ.

Дүүргийн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй болгох зорилгоор засаг захиргааны нэгжийг шинэчлэн зохион байгуулж, тухайн нэгж бие даан асуудлаа шийдвэрлэх эрхийг нэмэгдүүлэх бодлого баримтална.

**Дүүрэг маань хөгжлийн хурд, бүтээн байгуулалтын эрчээ улам нэмэх болтугай.**



АРДЧИЛСАН НАМ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
УЛААНБААТАР ХОТ

# НЭГ. ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ - СТАНДАРТТАЙ ДҮҮРЭГ

## 1.1. Иргэндээ ээлтэй дүүрэг

1.1.1 Хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгаалал, хандлага гэх 4 үндсэн чиглэлээр дэд хөтөлбөр боловсруулж, баталж, хэрэгжүүлж ажиллана.

1.1.2 Дүүргийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйлчилгээ, чанарыг нэг стандарттай болгож, сайжруулна.

1.1.3 Урьдчилан сэргийлэх үзлэгийн үйлчилгээг чанаржуулж, дүүргийн иргэн бүрийн хамрагдах боломжийг нэмэгдүүлнэ.

1.1.4 Алслагдсан хороодод эмийн сан, эмнэлгийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

1.1.5 Буруу хооллолт, эрүүл бус хүнсний хэрэглээ, эмийн зохисгүй хэрэглээ, дасгал хөдөлгөөний дутагдлаас үүдэлтэй өвчлөлийг багасгах, урьдчилсан сэргийлэх чиглэлээр дэд хөтөлбөр боловсруулж, ажиллана.

1.1.6 Дүүргийн ахмадуудад зориулсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэдний туршлагыг залуу үед өвлүүлэх, бие, сэтгэл зүйн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

1.1.7 Дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх, орлогын байнгын эх үүсвэрийг бий болгох, нийгмийн амьдралд оролцуулахад иргэн, аж ахуйн нэгжтэй хамтарч ажиллана.

1.1.8 Дүүргийн оюутан залуучуудад зориулсан “Мэдлэг, ур чадварыг урамшуулъя” тэтгэлэгт хөтөлбөрийг иргэн, аж ахуйн нэгжтэй хамтарч хэрэгжүүлж ажиллана. Мөн дүүргийн оюутан залуучуудын “ажиллангаа суралцах, суралцангаа хөдөлмөр эрхлэх” хөтөлбөр



АРДЧИЛСАН НАМ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
УЛААНБААТАР ХОТ

хэрэгжүүлж, цагийн болон долоо хоногийн цалингийн системийн зарчмаар ажил хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлнэ.

1.1.9 Дүүргийн өрх бүрт зориулсан "Амар тайван гэр бүл" хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах ба эцэг, эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх, хувийн орон сууцтай болгох дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажиллана.

1.1.10 Хороо бүрийн онцлогт тохирсон хөгжлийн хөтөлбөр боловсруулж, иргэдээр хэлэлцүүлэн баталж, хэрэгжүүлнэ.

1.1.11 Улс, нийслэлийн болон хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэхэд чиглэн ажиллана. Мөн ерөнхий боловсролын сургуулийн хичээллэх ээлжийн тоог бууруулж, анги дүүргэлтийн стандартыг мөрдүүлнэ.

1.1.12 Сургуулийн өмнөх боловсрол болон Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын тулгамдсан асуудлыг шийдэх замаар боловсролын хөгжлийг дэмжинэ. Багш нарын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, сургалтанд хамруулах, гадаадын улс орнуудад туршлага судлуулах ажлыг дэмжиж ажиллана.

1.1.13 Иргэний боловсрол олгох албан бус сургалтын үйл ажиллагааг дэмжинэ ажиллана.

1.1.14 ОУ-ын донор байгууллагууд, Дипломат төлөөлөгчийн газрууд, Гадаадын улс орнуудтай хамтарч хүн амын бүлгүүд рүү чиглэсэн тухайлсан төсөл хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ.

## 1.2 Стандарттай дүүрэг

1.2.1 Шуудан хүргэлтийн дэд бүтцийн бэрхшээлийг тогтоох, шийдэх, энэ ажлын хүрээнд дүүргийн хаягжилтыг тодорхой болгож, хаягжилтын стандартыг хэрэгжүүлж, сайжруулна.

1.2.2 Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, явган зам, нийтийн үйлчилгээний газруудад гэрэлтүүлэг, аюулгүй байдлын хяналтын



АРДЧИЛСАН НАМ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
9023041590
УЛААНБААТАР ХОТ

сүлжээ бий болгоход нийслэлийн төр захиргааны байгууллагатай хамтран ажиллана.

1.2.3 Эрүүл орчны стандартуудыг шинэчлэн хэрэгжүүлэх (агаар, хөрс, ус, орчны дуу чимээ онцгой анхааран) иргэдийн ая тухтай амьдрах нөхцлөөр ханган ажиллана.

1.2.4 Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар шаардлагатай газруудад нийтийн бие засах газрыг барьж байгуулах ажлыг дэмжинэж, стандарт мөрдүүлнэ.

1.2.5 Барилгын авто зогсоолын стандартыг сайжруулах, шинэчлэх, авто зогсоол хүртээмжэй байлгах орчныг бүрдүүлэхэд чиглэн ажиллана.

1.2.6 Төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугамд холбогдоогүй цэцэрлэг, сургуулиудыг холбох ажлыг зохих шатны байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.

1.2.7 Барилга байгууламжийн төвлөрсөн ил зогсоол, дотор авто зогсоол, орон сууцны хороолол дундах авто зогсоолыг стандартад нийцүүлэх ажлыг холбогдох төр захиргааны байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.

1.2.8 Хотын төлөвлөгдсөн бүсэд нийтийн орон сууцны хөтөлбөрийн хэрэгжилтийг стандартад нийцүүлэн хөгжүүлэхэд идэвхтэй оролцоно.

1.2.9 Айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, цахилгааны хүчдэл муутай айл өрхүүдийн цахилгааны хүчдэлийг стандартын түвшинд хүргэх ажлыг үргэлжлүүлнэ.

1.2.10 Явган хүний зам, дугуйн замыг стандартад нийцүүлэх ажлыг хангаж ажиллана.

1.2.11 Дүүрэг, хороодын ус, дулаан, цэвэр бохир ус дамжуулах шугам хоолойны насжилт болон стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг тодорхойлж, шугам сүлжээ тоноглолыг засах, сайжруулах, солих, шинэчлэх ажлыг төлөвлөж гүйцэтгэнэ.



АРДЧИЛСАН НАМ
ХАН-УУЛ ДҮҮ... НАМЫН ХОРОО
УЛААНБААТАР ХОТ

1.2.12 Тусгай зориулалтын зам, шат, хаалга, бие засах газрууд байгуулах ажлыг дэмжиж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй дүүрэг болгоно.

1.2.13 Хугацаа нь дуусч хүн амьдрах стандартын шаардлага хангахгүй байгаа орон сууцуудыг нийслэлээс хийсэн төлөвлөлтийн дагуу шинээр хороолол барих, хувийн хэвшлийг үргэлжлүүлэн дэмжиж ажиллана.

1.2.14 Үерийн ус зайлуулах сувгийг шаардлагатай хороодод нэмж барих ажлыг улс нийслэлийн төсвийн дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэнэ.



АРДЧИЛСАН НАМ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7581
УЛААНБААТАР ХОТ

# ХОЁР. ХОТЫН СОЁЛТОЙ - НОГООН ДҮҮРЭГ

## 2.1. Хотын соёлтой дүүрэг

2.1.1 Хог хаягдлын менежментийг байнга сайжруулж, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд цэвэр цэмцгэр байдлыг өдөр тутамд хэвшүүлэн ажиллана.

2.1.2 Гудамж, талбайд хүрэлцээтэй хогийн сав байршуулж, хог хаягдлыг зайлуулах орчин үеийн машин техникээр хангах ажлыг нийслэлийн төр захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

2.1.3 Дүүргийн хот тохижилтын байгууллага болон сууц өмчлөгчдийн холбоодтой хамтарч нийтийн эзэмшлийн талбай, ногоон байгууламжийг арчлах, хамгаалах ажлыг тогтмол хийлгэж хэвшүүлнэ.

2.1.4 Тоосжилтыг бууруулах зорилгоор сул шороон хөрс бүхий гудамж талбайг зүлэгжүүлэх, эко хатуу хучилттай болгох, дүүргийн шороон замуудыг хатуу хучилттай болгох ажлыг улс, нийслэлийн төсвийн хөрөнгийн дэмжлэгтэйгээр үргэлжлүүлэн хийнэ.

2.1.5 Нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр нийслэлийн төр захиргааны байгууллагатай идэвхтэй хамтран ажиллана.

2.1.6 Хуучин барилга байгууламжийн насжилтын судалгаа гаргаж, барилгын хийцийг хүчитгэх, дулаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дахин төлөвлөх зэрэг арга хэмжээнүүдийг нийслэлийн төр засгийн байгууллагатай хамтран шийдвэрлэнэ. Хуучин орон сууцны гадна фасад, дээврийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлэн хийнэ.

2.1.7 Иргэдийг байгалийн гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор гамшгийн үед байрлах, хоргодох цэгүүдийг тогтоож, онцгой байдлын алба саадгүй хүрч ажиллах орчинг бий болгоно.

1117145033
УХ40612 9877270

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
НАМЫН ХОРОО
9023041590
8480916 ХТО7561
УЛААНБААТАР ХОТ

## 2.2. Ногоон дүүрэг

2.2.1. МУ-ын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжүүлж буй "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд айл өрх, албан байгууллага бүр мод тарих аяныг өрнүүлж, дэмжиж ажиллана.

2.2.2. Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж буй үйлдвэрийг хотоос гадагш төвлөрүүлэн байгуулах шат дараалсан арга хэмжээг авна.

2.2.3. Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх орчин нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Арьс ширний үйлдвэрүүдээс гарч буй үнэрийг арилгах талаарх арга хэмжээг аж ахуйн нэгж байгууллагатай хамтран зохион байгуулна.

2.2.4. Гадаад, дотоодын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, ногоон дүүрэг болгох ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.2.5. Цэцэрлэгт хүрээлэн, амралт чөлөөт цагт зориулсан ногоон байгууламжийг хороо бүрт бий болгох ажлыг иргэн, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор гүйцэтгэнэ.

2.2.6. Усны нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах зорилгоор туул гол болон бусад гол, горхи, булаг, шандыг сэргээх, хамгаалах зорилгоор голын ай сав /булаг, шанд орчмын газар/ газруудад цэцэрлэгт хүрээлэн, ногоон бүс олноор бий болгоход анхаарч ажиллана.

2.2.7. Нөхөн сэргээх шаардлагатай хөрсний элэгдэл, эвдрэлд орсон газруудыг иргэн, аж ахуйн нэгжийн оролцоотой нөхөн сэргээж, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

2.2.8. Улс, нийслэлийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар хороо бүрт тоноглогдсон биеийн тамир, спортын талбай бий болгох, шинээр баригдах цэцэрлэгт хүрээлэнгүүдийг дугуй, гүйлтийн замтай болгохыг дэмжиж ажиллана.



АРДЧИЛСАН НАМ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
УЛААНБААТАР ХОТ

2.2.9. Хан-Уул дүүргийн захын хороодыг хүнсний үйлдвэрлэл, фермерийн аж ахуй эрхлэгчдийг бодлогоор дэмжин, дүүргийн ногоон бүс болгож хөгжүүлнэ.

2.2.10. Түүх соёлын дурсгалт газруудыг тодруулж, хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах зэрэг арга хэмжээнүүдийг авна. Соёлын биет болон биет бус өвийг сэргээн хөгжүүлэх, хадгалж хамгаалах, өвлүүлэх ажлыг зохион байгуулна. Дээрх замаар аялал жуулчлал, соёлын харилцааны хөгжлийг дэмжинэ.

2.2.11. Тогтвортой хөгжлийн бодлого боловсруулж иргэдийг оролцоог нэмэгдүүлж сургалт арга зүйгээр хангана.



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
6488916 ХТО7581
УЛААНБААТАР ХОТ

## ГУРАВ. АЖИЛ, БИЗНЕС ЭРХЛЭХЭД ТААТАЙ ДҮҮРЭГ

3.1. Ажил бизнес эрхлэхэд ээлтэй бодлого баримтлан ажиллаж, амьжиргааны орлогын эх үүсвэртэй болох иргэдийн санаачлагыг дэмжиж ажиллана.

3.2. Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор бизнес инкубаторын төвүүд, Хан-Уул дүүргийн бизнесийн зөвлөлтэй хамтран шинэ бизнесийг бойжуулна.

3.3. Ажил олоход бэрхшээлтэй эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зорилтот хөтөлбөрийн дагуу дэмжинэ.

3.4. Ажил олгогчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг бүрэн хангах мэргэжилтэн бэлтгэх нөхцөлийг бүрдүүлнэ.

3.5. Ажил хайгчдыг ажлын байранд нийцүүлэхийн тулд хиймэл оюун ухаан, дэвшилтэт техник, технологи ашиглана.

3.6. Инновацид суурилсан гарааны бизнесийг дэмжинэ,бойжуулж шат дараатай дэмжлэг тусламж үзүүлнэ. Гарааны бизнесийг дэмжих эко системийг бүрдүүлнэ.

3.7. Цагаар ажиллах, гэрээр ажиллах, зайнаас ажиллуулах, сүлжээний маркетинг бүхий бараа, үйлчилгээний борлуулалт хийх зэрэг хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэрийг дэмжих замаар эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

3.8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх бодлого,

1117145533
УХА0612 9077278

АРДЧИЛСАН НАМ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
... ХОРОО
...23041590
84...916 ХТО7581
УЛААНБААТАР ХОТ

зохицуулалтыг харилцан уялдуулсан ослын даатгалын тогтолцоог нэвтрүүлнэ.

3.9. Дүүргийн жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зээлийн батлан даалтын санг нэмэгдүүлэн, зээлийн хэмжээ, хугацаа, нөхцлийг сайжруулахад анхаарч ажиллана.

3.10. Хөдөлмөрийн бирж, ажлын байрны яармагийг аж ахуйн нэгж байгууллага болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулж, ажил эрхлэлтийг дэмжинэ.

3.11. Хөдөлмөрийн зах зээлийн харилцаанд оролцогч талуудын эрх ашгийн тэнцвэрийг хангах хөдөлмөр эрхлэлтийн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

1117145633
УХА0612 0077278



АРДЧИЛСАН НАМ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
... ХОРОО
9023 41590
8488916 ХТО7581
УЛААНБААТАР ХОТ

# ДӨРӨВ. ХАШААНДАА САЙХАН АМЬДАРЪЯ – ДЭД БҮТЭЦТЭЙ ДҮҮРЭГ

## 4.1. Хашаандаа сайхан амьдаръя

4.1.1. Гэр хорооллыг инженерийн дэд бүтэц (цэвэр ус, бохир ус ариутгах татуурга, интернэтийн шилэн кабель)-д холбож, хашаандаа сайхан амьдрах боломжийг бүрдүүлнэ.

4.1.2. Гэр хороолол болон орон сууцны халаалтыг цахилгаан эрчим хүчээр халаах технологийг дэмжиж эх үүсвэрийн тодорхой хэсгийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.

4.1.3. “Эрчим хүч үйлдвэрлэгч иргэд” хөдөлгөөнийг гэр хороололд өрнүүлж, иргэд хашаандаа нарны эрчим хүч үйлдвэрлэж илүүдэл эрчим хүчээ төвийн сүлжээнд борлуулах боломжийг бүхий л талаар дэмжинэ.

4.1.4. Гэр хорооллын цахилгаан, дулаан, цэвэр бохир усны инженерийн шийдлийг хот айлууд хамтран бүлэг бүлгээрээ бие даасан хэлбэрээр хэрэгжүүлэх технологийг хэрэгжүүлнэ.

4.1.5. Гэр хорооллын янданг цөөрүүлэх, утаа угаарыг багасгах бодлогыг дэмжин хувийн хэвшил, шинэ дэвшилтэт технологи, инновацийн шинэ санааг дэмжинэ.

4.1.6. Айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, цахилгааны хүчдэл муутай айл өрхүүдийн цахилгааны хүчдэлийг стандартын түвшинд хүргэх ажлыг үргэлжлүүлнэ.

4.1.7. Айл өрхийг инженерийн дэд бүтцэд холбох бүхий л санал санаачлагыг дэмжиж ажиллана.

4.1.8. Амралт, чөлөөт цаг өнгөрөөх тоглоомын талбай, бичил цэцэрлэгт хүрээлэнг гэр хорооллуудад олноор нь байгуулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.



АРДЧИЛСАН НАМ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
5483916 ХТО7581
УЛААНБААТАР ХОТ

4.1.9. Гэр хорооллын доторх замын сүлжээг сайжруулж, явган хүний зам, засмал зам тавих тухай төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэхийг дэмжинэ.

4.1.10. Сайжруулсан нүүрсийг хориглож цахилгаан, нарны эрчим хүчээр халаах шинэлэг технологийг нэвтрүүлнэ.

4.1.11. Гэр хороололд сургууль, цэцэрлэг, эмнэлэг, онцгой байдлын албаны хүртээмжийг сайжруулна.

4.1.12. Гэр хорооллын төлөвлөлттэй бүсүүдэд ногоон байгууламжтай болгож хашаандаа мод тарьсан айл өрхийг дэмжин ажиллана.

## 4.2. Бүрэн дэд бүтэцтэй дүүрэг

4.2.1. Нийслэлийн хот төлөвлөлтийн хүрээнд гэр хорооллын бүсчлэл тогтооно.

4.2.2. Гэр хорооллын төлөвлөлттэй бүсүүдэд дэд бүтцээр бүрэн холбоно.

4.2.3. Хот төлөвлөлттэй гэр хорооллыг бий болгохын тулд газрын маргааныг бүрэн шийдвэрлэнэ.

4.2.4. Төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугамд холбогдоогүй цэцэрлэг, сургуулиудыг холбох ажлыг зохих шатны байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.

4.2.5. Хот төлөвлөлттэй гэр хороололд үерийн усны хамгаалалтыг сайжруулж, шинэчлэн усан сан бүхий амралт зугаалгын бүстэй болгоно.

4.2.6. Яармагийн 3-р буудлаас дүүрэг хүртэл цахилгаан галт тэргээр үйлчилж, түгжрэлийг бууруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

4.2.7. Инженерийн шугам сүлжээний асуудлыг шийдвэрлэх ажлыг хэрэгжүүлнэ.



ХАН-УУЛ ДҮҮ... НАМЫН ХОРОО
9023041500
8488916 ХТО7581
УЛААНБААТАР ХОТ

4.2.8. Худаг, халуун ус, ахуйн үйлчилгээний төв зэргийг хэрэгцээтэй байгаа хороодуудад улс, нийслэлийн төсвийн хөрөнгө, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах замаар барьж байгуулна.

4.2.9. Гэр хорооллын төлөвлөлттэй бүсүүдэд дугуйн зам, гүйлтийн зам, усан бассейн, тоглоомын талбай болон бичил цэцэрлэгт хүрээлэнг олноор нь байгуулах ажлыг тасралтгүй хийж, сайжруулна.

4.2.10. Хот төлөвлөлттэй гэр хороололд нийтийн тээврийн хүртээмжийг эрс шинэчлэн сайжруулж ОУ-ын жишигт хүргэсэн **түгжрэлгүй бүс** болгоно.



АРДЧИЛСАН НАМ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
6488916 ХТО7581
УЛААНБААТАР ХОТ

# ТАВ. ЦАХИМ ЗАСАГЛАЛ 3.0 ДҮҮРЭГ

5.1. Хан-Уул дүүргийн иргэд, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг бүрэн цахимжуулна.

5.2. Дүүрэгт ил тод, шударга, ёс зүйтэй, иргэндээ ойрхон, чанартай үйлчилгээг хүргэдэг ухаалаг засаглалыг бий болгоно.

5.3. Дүүргийн сүлжээ, интернетийн серверийн хүчин чадлыг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах, иргэдийн цахим хэрэглээ, үйлчилгээг тэгш хүртээмжтэй болгох орчны хөгжүүлэлт хийнэ.

5.4. Дүүргийн тулгамдаж буй асуудлаар иргэдийн дунд цахимаар олон нийтийн санал асуулга явуулж, тэдний саналд үндэслэн шийдвэр гаргадаг болно.

5.5. Дүүргийн иргэдийн улсын бүртгэлийг бүрэн цахимжуулах, хөгжүүлэх, хаягжуулна.

5.6. Дүүргийн нэгдсэн эмнэлгийн үйлчилгээг хялбаршуулах, ачааллыг жигд хувиарлан бууруулах, цахим үйлчилгээг энгийн хялбар болгох, хэрэглээг сайжруулах, иргэдэд түгээж ажиллана.

5.7. Сургалтын тэгш хүртээмжийг хангах зорилгоор дүүргийн алслагдмал сургууль, цэцэрлэгийн сурагчдын цахим сургалтын хүртээмжийг нэмэгдүүлнэ.

5.8. Иргэдийн цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах хамгаалалтын системийг хөгжүүлэх, иргэдэд энэ талын мэдээ мэдээллийг төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран зохион байгуулж, түгээж ажиллана.

5.9. Олон нийтийн интернетийн сүлжээг ашиглан дүүргийн иргэдэд мэдээлэл түгээх, санал, гомдол, хүсэлт хүлээн авах ажлыг боловсронгуй болгоно.

5.10. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хараат бус хөндлөнгийн хяналт, үнэлгээний мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллана.



АРДЧИЛСАН НАМ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7581
УЛААНБААТАР ХОТ

5.11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш хүртээмжийг хангах зорилгоор тусгай зориулалтын цахим хуудас технологийн хэрэгцээг бүх шатны дүүргийн үйлчилгээнд нэвтрүүлэх.



АРДЧИЛСАН НАМ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7581
УЛААНБААТАР ХОТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 911

танай ____________-ны №____________-т

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Чингэлтэй дүүргийн Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа 2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Чингэлтэй дүүргийн “Ардчилсан намын хороо”-ны Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дах хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Чингэлтэй дүүргийн “Ардчилсан намын хороо”-ны сонгуулийн мөрийн хөтөлбөр / .17. хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Чингэлтэй дүүргийн сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

C:\Users\zendmene.d\Desktop\2024\Word\Явсан бичиг\2024.08.06.CHD.AN.MH.docx

ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

# “ЗӨВ БОДЛОГО-ЗӨВ ШИЙДЭЛ”
# ХОЙМОР ДҮҮРЭГТ

АРДЧИЛСАН НАМ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7575
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

# ӨМНӨТГӨЛ

2024 оны Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрт дараах үндсэн асуудлуудад чиглэсэн бодлого, үйл ажиллагааны чиглэлийг хэрэгжүүлж ажиллана. Мөрийн хөтөлбөрийг:

- Шударга ёс,төрийн албаны сайн засаглал
- Боловсрол, эмнэлэгийн хүртээмж, чанартай үйлчилгээ
- Ажилгүйдэл ядуурлыг эрс багасгах
- Иргэдийн амьдрах орчин, хүний хөгжил гэсэн зорилтуудын хүрээнд болвсруулах болно.

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны хууль бусад холбогдох хуулийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, гүйцэтгэлд чанарын хяналтын олон улсын тогтолцоог нэвтрүүлэн ажиллах болно.

Боловсрол, эмнэлэгийн хүртээмж, чанартай үйлчилгээ салбарын багш, эмч, техникийн ажилтан, бага тушаалын албан хаагчдын мэргэжил мэдлэгийг тасралтгүй дээшлүүлнэ. Ажиллах нөхцөл, ажлын ачаалалыг тэнцвэржүүлэн ажиллах нийгмийн асуудлыг шийдвэрлэхийн тулд гэр хороололд дахин төлөвлөлтөд хамрагдуулна.

Өрхийн аж ахуй эрхлэгчид, бичил үйлдвэрлэл эрхлэгчид, жижиг дунд үйлдвэр эрхлэгчидэд орон нутаг, нийслэл, улсын төсөв, олон улсын байгууллагын хөнгөлттэй зээлийг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар олгуулах ажлыг зохион байгуулж ажилгүйдэл болон ядуурлыг эрс багасгаж ажиллах болно.

Дүүргийн хэмжээнд хот төлөвлөлтийг Улаанбаатар хотын хөгжлийн 2020 он болон 2030 он хүртлэх Ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах ажлыг санаачилан мөрийн хөтөлбөр болгон хэрэгжүүлж ажиллана. Дээрхи төлөвлөлтөд "**ГЭР ХОРООЛЫН ЗӨВ ШИЙДЭЛ**" санаачлагыг дэмжиж ажиллах болно.

**Чингэлтэй дүүргийн Ардчилсан намын**

**дарга Д.БАЯНМӨНХ**

АГУУЛГА


НЭГ. <u>САЙН ЗАСАГЛАЛТАЙ ЧИНГЭЛТЭЙ</u>

1.1 Иргэдийн оролцоо, ил тод байдлыг сайжруулах чиглэлээр
1.2 Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй , хүртээмжтэй болгох чиглэлээр

ХОЁР. <u>АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ ЧИНЭЭЛЭГ ЧИНГЭЛТЭЙЧҮҮД</u>

2.1 Дүүргийн хөрөнгө оруулалт, төсөв санхүүгийн тогтвортой байдлыг хангах
2.2 Бизнес, хөдөлмөр эрхлэлтийн таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр
2.3 Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр

ГУРАВ. <u>ЗӨВ ШИЙДЭЛ, ЗӨВ ТӨЛӨВЛӨЛТТЭЙ ЧИНГЭЛТЭЙ</u>

3.1 Орчны тохижилтын чиглэлээр
3.2 Орон сууцны хорооллыг тохижуулах чиглэлээр
3.3 Гэр хороолын дахин төлөвлөлтийн чиглэлээр
9. Багануурын үйлдвэр технологийн паркийн мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, малын түүхий эд, нүүрс боловсруулах үйлдвэрийн төслүүдийг дэмжиж, үүнд гадаад дотоодын донор байгууллагын зээл тусламжийг татаж ажиллана
10. Гахай, шувуу, зөгий, загас үржүүлгийн аж ахуй эрхлэх, хөгжүүлэх санаачилгыг урамшуулах, дэмжих ажлыг зохион байгуулна.

1117145633
УХА0612 9077278

АРДЧИЛСАН НАМ
БАГАНУУР ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
УЛААНБААТАР ХОТ

11. Мах хадгалах хөргүүр, ногоо хадгалах зоорь барих иргэн аж ахуйн нэгж байгууллагуудыг дэмжиж ажиллана.
12.

## Гурав. Дэд бүтэц

1. Багануурын цахилгаан станцыг бүрэн ашиглалтад оруулахад бүх нөхцөл боломжоор хангаж, дэмжиж ажиллана
2. Сэргээгдэх эрчим хүч, байгаль орчинд ээлтэй дэд бүтцийн шийдлүүдийг дэмжинэ.
3. Зуслан, шинэ суурьшлын бүсийн газрын байршлыг тогтоон, дэд бүтцээр хангана
4. Дүүрэгт цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх цэг байгуулна.
5. Гэр хороололд өндөр хурдны интернэт сүлжээ, IPTV-г өргөжүүлнэ
6. Улаанбаатар-Багануур хооронд 4 зорчих эгнээтэй авто замыг дотоод болон гадны хөрөнгө оруулалтын дэмжлэгээр барина
7. Хот доторх авто замыг эвдрэлгүй байлгаж, засвар, арчлалтын ажлыг тогтмолжуулна
8. Гэр хорооллын авто замуудыг тойрог хэлбэрээр холбосон засмал зам барина
9. Авто зогсоолын тоог нэмэгдүүлнэ
10. Авто вокзал барих хувийн аж ахуй нэгжийг бүрэн дэмжиж, нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ
11. Такси болон тээврийн үйлчилгээнд цахим технологийг нэвтрүүлэн, иргэдэд хүртээмжтэй, соёлтой үйлчилгээ үзүүлэх зохицуулалтыг хийнэ

## Дөрөв.Хот, нийтийн аж ахуй

1. Хотын зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээнд олон улсын стандарт нормыг хангасан техник хэрэгслийг нэвтрүүлж, үйлчилгээний ажилчдын хөдөлмөрийг хөнгөвчлөн ажлын бүтээмжийг нэмэгдүүлнэ
2. Замын дагалдах дэд бүтэц болох ус зайлуулах шугам, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ
3. Орон сууцны айл өрхүүдэд цэвэр ус түгээх, хангах дундын өмчлөлийн шугам сүлжээг стандарт шаардлагад нийцүүлэн шинэчилж, зэвгүй ундны усаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ
4. Гудамж, замуудын нэвтрүүлэх чадамжийг дээшлүүлж, хяналтын камер, хурд хэмжигч, хурд сааруулагч байршуулна
5. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож хог хаягдлыг ангилан хаях ажлыг хэвшил болгоно

## Дөрөв. Ажилгүйдэл ядуурлыг бууруулах

1. Ажилгүй иргэд, ядуу өрхийн судалгааг шинээр хийж, ядуурлыг бууруулах хөтөлбөр боловсруулан, ДИТХ -ын шийдвэр гаргуулж хэрэгжүүлнэ

2. 50-с дээш ажлын байр шинээр бий болгох хувийн аж ахуйн нэгжид үйлдвэр технологийн парк болон бусад байршилд газрын асуудлыг нь хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэдэг болгоно.
3. Багануурт шинээр үйл ажиллагаа явуулж буй компани, аж ахуйн нэгжийн хоттой хамтран ажиллах гэрээнд орон нутгийн иргэдэд өгөөжтэй байх нөхцлийг тусгаж ажиллана.
4. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх аж ахуйн нэгж, иргэдийг төсөлд хамруулан төрийн тусгай сангуудын хөнгөлөлттэй зээл авахад нь хууль, журмын хүрээнд дэмжиж ажиллана.
5. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ
6. Хувийн хэвшилтэй хамтран "Түрээсийн орон сууц" тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

## Тав. Халамжаас хөдөлмөрт

1. Өдөр өнжүүлэх, хүүхэд харах үйлчилгээг өргөжүүлж, залуу гэр бүлийн ажиллах боломжийг хангана
2. Зорилтот бүлгийн өрхийн гишүүдийг мэргэжил олгох, чадавхжуулах сургалтад хамруулна
3. Эмэгтэйчүүдийн ажлын байрыг нэмэгдүүлнэ. Оёдол үйлдвэрийн барилга.
4. Хөдөлмөр зуучлалын цахим алба ажиллуулна
5. Ахмадын сувиллыг өргөтгөн, жилийн дөрвөн улиралд ажиллуулах нөхцөлийг бүрдүүлнэ

## Зургаа. Эрүүл мэндийн үйлчилгээ

1. Нийгмийн эрүүл мэндийн төвийг бие даасан статустай болгож, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэхэд чанарын дэвшил гаргана
2. Дүүргийн Эрүүл мэндийн төвийн шатлалыг ахиулж "Нэгдсэн эмнэлэг" болгож, бүх шатны эмнэлгүүдийн үйлчилгээний чанар, нэр төрөл, хүртээмж, ажиллагсдын ёс зүй, мэдлэг чадварыг дээшлүүлнэ, дагаад хууль журмын дагуу цалин хангамж нь нэмэгдэнэ.
3. Эмэгтэйчүүд, мэс засал, дуран, эрүү нүүр, чих хамар хоолой, хүүхдийн мэс засал, хагалгааны нэр төрлийг нэмэгдүүлнэ.
4. Нарийн мэргэжлийн эмч бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар хүний нөөцийн цогц хөтөлбөр хэрэгжүүлнэ
5. Хүүхдийн сэргээн засах сувилал, хүүхдийн эмнэлэг байгуулна
6. Өрхийн болон хувийн эмнэлгийг дэмжиж, тоо, чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ
7. Хүүхдийн шүдний эрүүлжилтийг 100 хувьд хүргэх зорилт тавьж, хувийн хэвшлийн шүдний эмнэлгийг дэмжиж ажиллана
8. Архи, сэтгэцэд нөлөөлөх бодист донтогсдыг эмчлэх, ажил эрхлүүлэх, нийгэмшүүлэх талаар тусгайлан хөтөлбөр гарган хэрэгжүүлнэ

1117145633
УХА8612 9077278

АРДЧИЛСАН НАМ
БАГАНУУР ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7577
УЛААНБААТАР ХОТ

## Долоо. Боловсролын чанар

1. Талын толгой, Нарийн нуур, Нугын талыг хамарсан бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор байгуулна
2. Оюуны эрин цогцолбор сургуулийн 1 дүгээр байранд өргөтгөл хийнэ
3. 200 сурагчийн дотуур байр барина
4. Нийгмийн хариуцлагын хүрээнд “Хүүхэд бүрд компьютер “ хөтөлбөр хэрэгжүүлэх санал, санаачилгыг дэмжинэ
5. Сургууль, цэцэрлэгийн удирдлагыг мэргэшсэн, тогтвортой, улс төрөөс хараат бус байх нөхцөлийг бүрдүүлж, удирдах албан тушаалтныг чөлөөлөх, томилох асуудалд дүүргийн иргэдийн төлөөллөөс бүрдсэн “Боловсролын зөвлөл”-ийн саналыг харгалздаг болно
6. Гэр хороолол дахь бага сургууль, цэцэрлэгийн багшлах боловсон хүчний чадвар, үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ
7. Их, дээд сургуулийн салбар, мэргэжлийн боловсролын байгууллага шинээр нээх санал санаачилгыг дэмжинэ
8. Сургуулийн хүүхдийн автобусны зардлыг тухайн сургуулийн зардалд тусган, маршрутын тоо давтамжийг нэмэгдүүлнэ
9. Багшийн хөгжлийн тэнхимтэй болж, багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэж ажиллана
10. Олон улсын хүүхдийн амралтын төв байгуулах төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ

## Найм. Нутгийн удирдлага

1. Нутгийн удирдлагын байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлнэ
2. ДИТХ-ын Төлөөлөгчдийн чадамжийг дээшлүүлэн, хуралдаанаас гарах бодлого шийдвэрийн өмнө иргэдийн саналыг заавал сонсож, тусгадаг болно
3. Дүүргийн удирдлага улирал тутам үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд нээлттэй тавьдаг болно.
4. Хууль тогтоомж, ДИТХ-ын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ
5. Дүүргийн иргэний баримтлах хэм хэмжээ, биеэ авч явах соёлын хэмжүүрийг тусгасан “Багануур хотын дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ.
6. Газар эзэмшил, ашиглалтын талаарх мэдээллийг нээлттэй цахим болгоно
7. Ажлын хариуцлага алдсан, ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон төрийн албан хаагчийг албан тушаалаас түдгэлзүүлэх, чөлөөлөх арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж, олон нийтэд мэдээлнэ
8. Нийгмийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрийг таслан зогсоож, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг нутгийн удирдлагын бодлого, шийдвэрт тусган, салбар хоорондын ажлын уялдаа холбоог зохицуулж ажиллана
9. Шийдвэр гаргах түвшинд залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ

1117145633
УХА0612 9077278

АРДЧИЛСАН НАМ
БАГАНУУР ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
УЛААНБААТАР ХОТ

10. Улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн гүйцэтгэгч нар тухайн төслийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтын шаардлага, чанар байдлын талаараа баталгаат хугацааныхаа жил тутам иргэдэд тайлагнадаг болгоно
11. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалт, менежментийг сайжруулна
12. Дүүргийн иргэдэд олгосон газруудын ашиглалтын менежментийг сайжруулана

## Ес. Авлигатай тэмцэх

1. Орон нутгийн удирдлага, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын удирдлагын ёс зүй, нэр хүнд, итгэл хариуцлагын талаарх судалгааг иргэд, ажилтан, албан хаагчдын дунд жил бүр зохион байгуулж, ДИТХ-аар хэлэлцүүлэн үнэлгээ дүгнэлт өгч ажиллана
2. ДИТХ-ын дэргэдэх Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажлыг эрчимжүүлнэ
3. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, тэдгээрийн хор уршиг, авлигаас урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг төрийн албан хаагчид, төрийн өмчит үйлдвэр аж ахуйн нэгжийн ажиллагсад, ард иргэд, сурагчдын дунд үе шаттайгаар тогтмол зохион байгуулна
4. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулж, тендер, төсөл сонгон шалгаруулалтад хүний оролцоог хязгаарлана
5. Хууль хяналтын болон татварын байгууллагуудын тайланг хагас жил тутам иргэдийн сонсгол хэлбэрээр иргэдэд тайлагнадаг болгоно

## Арав. Эрүүл, аюулгүй орчин

1. Гэр хорооллыг үерээс хамгаалах далан, сувгийг судалгааны үндсэн дээр сэргээн шинэчилж, гэр хорооллын болон хот доторх гудамж талбайн ус зайлуулах шугамыг өргөтгөж, нэмэгдүүлнэ.
2. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, камерын тоог нэмэгдүүлнэ.
3. Гэр хорооллыг инженерийн дэд бүтцэд холбож, инженерийн бүрэн хангамжтай амины орон сууцанд амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
4. Олон улсын ногоон зээлийн сангаар гэр хорооллын 1000 айлын нүхэн жорлонг шинэчлэх төсөл хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна
5. Залуучуудын хөгжлийн "Communty center"-ийг "Залуус төв"-ийн үйл ажиллагаанд шинэчлэл хийх замаар байгуулж, чөлөөт цагаа өнгөрөөх, хамтдаа хөгжих, суралцах орчныг бүрдүүлнэ
6. Спорт, фитнесийн 500 хүний суудалтай цогцолбор, 800 суудалтай соёлын ордныг ашиглалтад оруулна

1117145633
УХА0612 9077278

АРДЧИЛСАН НАМ
БАГАНУУР ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488915 ХТО7577
УЛААНБААТАР ХОТ

## Арван нэг. Хүрээлэн буй орчин

1. Хотын үерийн далангийн усыг ашиглах замаар усан сан, хөв цөөрөм байгуулж, загас үржүүлгийн аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэлд ашиглах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
2. Хуцаагийн голын даланг байнгын устай болгоно.
3. Хэрлэн голын бургасыг нөхөн сэргээх, хамгаалах, хашаандаа мод тарих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ
4. Оршуулгын газрыг суурьшлын бүсээс тусгаарлах ойн зурвасыг бий болгоно
5. Үйлдвэрийн бүс дэх хүнд үйлдвэрүүдэд байгаль орчны нөлөөллийн үнэлгээг дахин хийлгэж стандартын шаардлага хангуулна
6. Бага гүний нуурт судалгаа хийлгэж загас үржүүлгийн төсөл хэрэгжүүлнэ.

1117146633
УХА0612 9077278

АРДЧИЛСАН НАМ
БАГАНУУР ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
УЛААНБААТАР ХОТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 895

танай ____________-ны №____________-т

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ НАЛАЙХ ДҮҮРГИЙН
АРДЧИЛСАН
НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Налайх дүүргийн Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Налайх дүүргийн Ардчилсан намын хорооны Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дах хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Налайх дүүргийн Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр /..6. хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Налайх дүүргийн сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2024 он

# Налайх дүүргийн Ардчилсан намын 2024-2028 оны Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөр

1117145633
УХА0612 9077278

Налайх дүүргийн Ардчилсан намын хороо

АРДЧИЛСАН НАМ
НАЛАЙХ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7580
УЛААНБААТАР ХОТ

**Налайх дүүргийн Ардчилсан намын 2024-2028 оны**

**Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын**

**сонгуулийн мөрийн хөтөлбөр`**

1. **Дэд бүтцийн хөгжил**

**1.1. Зам, тээвэр**

1.1.1. Дүүргийн авто замын сүлжээнд иж бүрэн үнэлгээ хийж, автозамын сүлжээг нэмэгдүүлэх, уулзваруудыг шинэчилж нэвтрэх чадварыг сайжруулах замаар авто замын ачааллыг бууруулах ажлуудыг шат дараатай хийж гүйцэтгэх.

1.1.2. Замын бат бөх, аюулгүй байдлыг хангах үүднээс дүүрэгт төлөвлөгөөтэй хийгдэх авто замын засварын болон шинээр тавигдах замын инженерийн шугам сүлжээг стандартад нийцүүлэх, ус зайлуулах шугамтай болгох

1.1.3. Дүүрэг доторхи нийтийн тээврийн болон такси үйлчилгээний маршрутыг өргөжүүлэх, хүртээмжийг сайжруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх

**1.2. Инженерийн байгууламж**

1.2.1 Дулааны цахилгаан станцын техник эдийн засгийн үндэслэлийг хийлгэж, дулааны шугамыг шинэчлэх ажлын зураг төсвийг хийлгэх

1.2.2 Дүүргийн 1, 4, 5-р хорооны айл өрхүүдийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн төлөвлөгөөг боловсруулах, инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлэх

1.2.3 Ундны усны өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах, хуучирч муудсан шугам сүлжээг эрүүл ахуйн чанарын стандарт, шаардлагад нийцүүлэн шинэчлэх, инновацийн технологийг нэвтрүүлэх

1.2.4 Байгаль орчны тогтвортой байдлыг хангахын тулд бохир ус цэвэрлэх байгууламжид хөрөнгө оруулалт хийх, саарал ус ашиглах технологийг хэрэглээнд нэвтрүүлэх

1.2.5 Цахилгааны хүчдэлийн уналттай болон шинээр үүсч байгаа зуслан, суурьшлын бүсүүдэд тогтвортой эрчим хүчний эх үүсвэрээр хангах

1.2.6 Дүүргийн хэмжээнд үерийн эрсдлийн үнэлгээ хийлгэж, үерийн ус зайлуулах нэгдсэн инженерийн байгууламж бий болгох

1.2.7 Шинэ суурьшлын бүс үүсгэх газрын төлөвлөлтөнд

**1.3 Нийтийн эзэмшилийн талбай**

1.3.1 Дүүргийн хэмжээнд цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбай, явган хүний зам, ногоон байгууламжийг сайжруулж нэмэгдүүлэх, түүнчлэн тусгай хэрэгцээт иргэдийн эрх ашигт нийцүүлэн ажлын зураг, төсөв хийлгэж, тохижуулна

1.3.2 Дүүргийн иргэдийн идэвхитэй үйл ажиллагааг дэмжин нийтийн эзэмшлийн талбайг арчлах, хамгаалах, хэвшлийг бий болгох.
Нийгмийн харилцааг дэмжих зорилгоор нийтийн эзэмшлийн талбайд гадаа үйл ажиллагаа, амралт зугаалгын хөтөлбөр, арга хэмжээ зохион байгуулагдах боломжтой газруудыг тохижуулах, соёлын ордныг шинэчлэх

2. **Эдийн засгийн өсөлт ба ажил эрхлэлт**

**2.1 Орон нутгийн бизнесийг дэмжих**

2.1.1 Бизнес инкубатор төв байгуулж, гараааны бизнес, жижиг, дунд бизнесийг дэмжих,

2.1.2 Бизнес эрхлэгчдийн ашиг орлогыг нэмэгдүүлэх, амжилтад хөтлөх зорилгоор зөвлөх хөтөлбөрүүдэд хамруулах.

1117145633
УХА0612 9077278

АРДЧИЛСАН НАМ
НАЛАЙХ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7580
УЛААНБААТАР ХОТ

2.1.3 Налайх дүүргийг аялал жуулчлал болон ложистикийн төв болгон хөгжүүлж, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд ээлтэй дүүрэг болгон, бизнесийн гадаад болон дотоод харилцааг өргөжүүлэх

2.1.4 Орон нутгийн өмчит газрууд, жижиг, дунд, өрхийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дүүргийн хэрэгцээнд худалдан авдаг болно.

2.1.5 Хувийн хэвшлийн хийх боломжтой ажлуудыг төр хийдэггүй байх зарчмыг баримталж, дүүргийн хэмжээнд хувийн хэвшлийг татвар, санхүүгийн оновчтой бодлогоор дэмжинэ

**2.2 Ажлын байр бий болгох**

2.2.1 Тогтвортой эрчим хүч, эко аялал жуулчлал зэрэг Налайхын эдийн засгийн давуу тал дээр тулгуурлан, шинэ үйлдвэрүүдийг татах.

2.2.2 Дүүргийн иргэдийг ажлын байрны эрэлт хэрэгцээнд тулгуурлан ур чадвар эзэмшүүлэхийн тулд мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж, хамруулна.

2.2.3 Оюутан залуучуудыг дадлагажуулах боломжийг бүрдүүлэхийн тулд төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

2.2.4 Жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийг иргэдэд, нээлттэй, үр дүнтэй, оновчтой хүргэх

2.2.5 "Тусгай хэрэгцээт иргэдийн ажлын байр" хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ

2.2.6 "Налайх барилгын материал үйлдвэр технологийн парк"-ийн ажлыг эрчимжүүлнэ.

**3. Боловсрол ба залуучуудын хөгжил**

**3.1. Сургуулийн дэд бүтэц**

3.1.1. Сургууль, цэцэрлэггүй хороодод шинээр зайлшгүй хэрэгцээт сургууль цэцэрлэгийг барьж байгуулна. СӨБ-ийн хүртээмжийг сайжруулж 500 метр радиус дотор цэцэрлэгтээ иржочдог байхаар шийдвэрлэнэ.

3.1.2. Анги танхим, номын сан, спортын байгууламж зэрэг сургалтын таатай орчинг бүрдүүлэхийн тулд сургалтын тоног төхөөрөмжийг шинэчилнэ.

3.1.3. Сургуулиудад дижитал боловсрол, технологийн интеграцчлалын эх үүсвэрээр хангах.

3.1.4. ЕБС-ын үндсэн хичээлээс гадна сурагчдын оюун ухааныг хөгжүүлэх, мэдээллийн технологийн сүүлийн үеийн хандлага AI , кодчилол, гэх мэт сургалтыг нэмэлтээр заах нөхцлийг бүрдүүлнэ.

**3.2. Ур чадварын сургалт**

3.2.1. Өсвөр үеийнхэнд ажил мэргэжлийн чиглэлээ хайж олох, боловсролын боломжийг олж авахад нь туслах зорилгоор ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх төв байгуулна.

3.2.2. Сургалтын чанар дээшлүүлэх, багшийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхийн тулд багшийн хөгжлийн хөтөлбөрүүдийг дэмжиж, гадаадын болон дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулж ажиллана

3.2.3. Дагалдан суралцах, ажлын байран дээрх сургалтын хөтөлбөрүүдийг үр ашигтай болгохын тулд орон нутгийн бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллана.

3.2.4. Насанд хүрэгчдийн боловсрол, ур чадварыг давтан сургах хөтөлбөр зэрэг насан туршийн боловсролын санаачлагыг дэмжинэ.

3.2.5. "Англи хэлтэй Налайхын залуус", " Монгол бичигтэн Налайхын залуус", " Хос хэлтэй Налайхын залуус" зэрэг хөтөлбөрүүдийг үе шаттай хэрэгжүүлнэ.



АРДЧИЛСАН НАМ
НАЛАЙХ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7580
УЛААНБААТАР ХОТ

**3.3. Залуучуудын оролцоо**

3.3.1. Шийдвэр гаргах үйл явцад залуучуудыг татан оролцуулахын тулд залуучуудын зөвлөл эсвэл зөвлөлдөх зөвлөлийг бий болгох.

3.3.2. Манлайллын ур чадвар, иргэний хариуцлагыг төлөвшүүлэх зорилгоор залуучуудаар удирдуулсан олон нийтийн төсөл, арга хэмжээг зохион байгуулна.

3.3.3. Налайхын залуучуудын хүсэл сонирхолд нийцүүлэн амралт, соёлын арга хэмжээг нэмэгдүүлнэ.

3.3.4. Орон нутгийн бизнес эрхлэгчдийн нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөрүүдийг санаачлан хамтран ажиллана.

3.3.5. Залуусын start up хөтөлбөр, бизнес эрхлэлтийг төрийн бодлоготой уялдуулан дэмжиж ажиллана.

3.3.6. Залуусын орон байрны өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах, захын дүүрэгт шилжин суурьших залуусын тогтвортой, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх зорилгоор түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлнэ.

**4. Байгаль орчин ба тогтвортой байдал**

**4.1. Хог хаягдлын менежмент**

4.1.1. Хог хаягдлыг ангилах, цуглуулах, дахин боловсруулах санаачилгыг багтаасан хог хаягдлын менежментийн цогц стратегийг хэрэгжүүлж эхлүүлэх.

4.1.2. Байгальд хортой болон удаан задардаг хог хаягдлыг хариуцлагатай устгах үйл ажиллагааны талаарх мэдлэгийг дээшлүүлэх, дадал хэвшлийг суулгах, олон нийтийн оролцоог дэмжих.

4.1.3. Хуванцар хог хаягдлыг боловсруулах менежментийг хэрэгжүүлснээр, эдийн засгийн эргэлтэнд оруулах бодлогыг дэмжих, шинэлэг шийдлүүдийг турших зорилгоор бизнесийн болон ТББ-уудтай хамтран ажиллана.

4.1.4. Аялал жуулчлалын ногоон бүсэд үүссэн хог хаягдлыг цуглуулах төлбөрийн системийг нэвтрүүлж, иргэдийн оролцоотой ногоон байгууламжаа хамгаалах ажлыг эхлүүлнэ

**4.2. Ногоон санаачилга**

4.2.1. Агаарын чанарыг сайжруулах, дүүргийн хөрсний бохирдол, тоосжилт, хуурайшилт, хэт халалт, үер усны нөлөөг багасгахын тулд ногоон байгууламжийг иргэдийн оролцоотой нэмэгдүүлнэ.

4.2.2. Иргэд, оршин суугчдын дунд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг сурталчлан нэвтрүүлэх.

4.2.3. Хүнсний аюулгүй байдлын хяналтыг сайжруулах, эрүүл, тогтвортой амьдралын хэв маягийг дэмжих зорилгоор иргэдийн хүнсний ногооны болон өрхийн хүлэмжийн тариалалтын санаачлагыг дэмжинэ.

4.2.4. Усны нөөцийн хомсдол үүсэх эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор усны хэрэглээг зүй зохистой болгох талаар олон нийтэд сурталчлан хэрэгжүүлнэ.

**5. Агаар, орчны бохирдол**

**5.1 Агаарын чанар**

5.1.1. Гэр хорооллын яндангийн тоог багасгах, гэр, байшингийн дулаан хадгалах технологийг нэвтрүүлэх, тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зэрэг агаарын бохирдол үүсгэх эх үүсвэрийг багасгах зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж ажиллана.

5.1.2. Дүүргийн агаарын чанарыг сайжруулах асуудлыг шийдвэрлэхийн тулд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

**6. Хөдөө аж ахуй газар тариалан**

**6.1 Хөдөө аж ахуй**

1117145633

АРДЧИЛСАН НАМ
НАЛАЙХ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7580
УЛААНБААТАР ХОТ

6.1.1. Малчдын өвөлжөө, хаваржааны газрыг Монгол Улсын газрын тухай хуульд нийцүүлэн шийдвэрлэх.

**6.2 Газар тариалан**

6.2.1. Өвс, хадлан бэлтгэх, тэжээл тариалах ажлыг зэргэлдээх аймаг сумдын нутгийн захиргааны байгууллагуудтай гэрээлэх хэлбэрээр шийдвэрлэх.

6.2.2. Малчдын худаг усны асуудлыг шийдвэрлэх.

**7. Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг чанаржуулах**

**7.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж**

7.1.1. Дүүргийн оршин суугчдад нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэнэ.

7.1.2. Тусгай хэрэгцээт иргэдийг нийгмийн амьдралд идэвхитэй оролцох дэд бүтцийг бий болгоход онцгой анхаарна.

7.1.3. Урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээний хөтөлбөрийг боловсронгуй болгож, иргэдийн эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх

7.1.4. Налайхын хүн амын тулгамдсан асуудал болох хавдрын өвчлөлийн байдалд судалгаа хийж, өвчлөлийг бууруулах төсөл арга хэмжээг бодовсруулан хэрэгжүүлнэ

7.1.5. Дүүргийн эрүүл мэндийн төв эмнэлгийн эмч ажилчдын ур чадварыг сайжруулах, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалтанд хамруулж, эмчилгээ үйлчилгээг олон улсын стандартын түвшинд хүргэнэ.

**8. Нийгмийн дэмжлэг, аюулгүй байдал**

**8.1. Нийгмийн дэмжлэг**

8.1.1. Нийгмийн зорилтот бүлэг, тэр дундаа ахмад настан, тусгай хэрэгцээт иргэд, орлого багатай гэр бүлүүдэд үзүүлэх төрийн үйлчилгээг оновчтой болгох,

8.1.2. Хүүхдийн тоглоом, ахмадын амрах, чийрэгжүүлэх талбайг шинээр хороо бүрд шаардлагатай газарт байгуулна. “Хүүхдэд ээлтэй орон нутаг” төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ.

8.1.3. Орлогод нийцсэн төлбөр бүхий “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2028 онд 500 өрхийг түрээсийн орон сууцанд оруулсан байхаар зорьж ажиллана. Нэн тэргүүнд залуу гэр бүл, тусгай хэрэгцээт иргэд, ахмад настнуудыг дэмжих бодлого баримтлана. Гэр хорооллын 5 байршилд орон сууцжуулах төслүүдийг дулааны цахилгаан станцын шинэ эх үүсвэртэй холбож, иргэдээ орон сууцжуулна.

**8.2. Аюулгүй байдал**

8.2.1. Олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг идэвхжүүлж, хууль сахиулах байгууллагууд болон оршин суугчдын хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөршийн холбоог сэргээх.

8.2.2. Сургуулийн эргүүл төслийг үргэлжлүүлэх, сурагч хүүхдүүд сургуульдаа очих, гэртээ харих замдаа халдлагад өртөхгүй аюулгүй байх үүднээс e-kids цахим технологид хамрагдлыг нэмэгдүүлнэ..

8.2.3. Гудамжны гэрэлтүүлэг, хяналтын технологид хөрөнгө оруулалт хийж, олон нийтийн газар, гэр хороолол болон орон сууцны хорооллын аюулгүй байдлыг сайжруулах.

8.2.4. Хувиараа такси эрхлэгчдийг цахим сүлжээнд хамруулж, такси эрхлэгчдийн болон зорчигчдын аюулгүй байдлыг хамгаалах

**9. Соёлын хадгалалт, аялал жуулчлал**



АРДЧИЛСАН НАМ
НАЛАЙХ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7530
УЛААНБААТАР ХОТ

1117145633

**9.1. Өвийг хамгаалах**

9.1.1. Налайхын соёлын дурсгалт газрууд, түүхэн дурсгалт газрууд, уламжлалт зан үйлийг хамгаалах, сурталчлах.

9.1.2. Дүүргийн олон ястнуудын өв соёлыг харуулсан соёл урлагын наадам, үзэсгэлэнг уламжлал болгон зохион байгуулж, ардын авъяастан, өв тээгч нарыг бодлогоор дэмжих

9.1.3. Дүүргийн 4 дүгээр хорооны нутагт 1 га газарт Казак иргэдийн өв соёлын төв байгуулна.

**9.2. Аялал жуулчлал**

9.2.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр дэлхийн стандартад нийцсэн, аюулгүй, орчин үеийн тоглоом бүхий соёл амралтын хүрээлэн байгуулна.

9.2.2. Аялагчдын амрах, үдлэх, ариун цэврийн байгууламж зэрэг зам дагуух орчин нөхцлийг бүрдүүлэх

9.2.3. Өвлийн аялал, спорт амралтын цогцолбор байгуулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр бодлогоор дэмжиж ажиллана.

9.2.4. Дүүргийн аялал жуулчлалын бизнес эрхэлдэг иргэдийг орон нутгийн бодлогоор дэмжиж ажиллана.

**10. Ил тод байдал, засаглал**

**10.1. Ил тод байдал**

10.1.1. Дүүргийн ололт амжилт, тулгамдсан асуудлын талаар оршин суугчдад улирал бүр тайлагнаж мэдээлэх, жил бүр гүйцэтгэлийн аудит хийлгэх

10.1.2. Шилэн дансны тухай хуулийн одоогийн хэрэгжиж байгаа флатформийг иргэдэд ойлгомжтой байхаар мэдээллийг цаг хугацаанд нь оруулж хэвшинэ.

**10.2. Засаглал**

10.2.1. Дүүргийн газар нутгийн хилийн цэсийн маргаантай асуудлыг эцэслэн шийдвэрлэх.

10.2.2. Налайх дүүргийн 6 дугаар хорооны иргэдийн газрын өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх.

Энэхүү мөрийн хөтөлбөр нь Налайх дүүргийн оршин суугчдын олон талт хэрэгцээ, хүсэл тэмүүллийг шийдвэрлэх, тогтвортой хөгжил, эдийн засгийн хөгжил цэцэглэлт, нийгмийн тэгш байдал, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг дэмжих зорилготой юм. Хамтын ажиллагаа, ил тод байдал, инновацийг чухалчилснаар бид хувь хүн бүр цэцэглэн хөгжиж, дүүргийн эрч хүчтэй ирээдүйд хувь нэмрээ оруулах боломжтой уян хатан, хүртээмжтэй нийгмийг бий болгож чадна.

1117145633
УХА0612 9077278



АРДЧИЛСАН НАМ
НАЛАЙХ ДҮҮРГИЙН
НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7580
УЛААНБААТАР ХОТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 918

танай ____________-ны №____________-т

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа 2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Багахангай дүүргийн Ардчилсан нам нь Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дах хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Багахангай дүүргийн Ардчилсан намын мөрийн хөтөлбөр / .6. хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Багахангай дүүргийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

C:\Users\zendmene.d\Desktop\2024\Word\Явсан бичиг\2024.08.06.BHD.AN.MH.docx

Багахангай дүүргийн Ардчилсан Нам

# БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР 2024

## “СУМЫН ХӨГЖЛӨӨС ХОТЫН ХӨГЖИЛ РҮҮ” МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**АЛДАГДСАН 35**
**ЖИЛИЙН АЛДААГ ЗАСНА !**

АРДЧИЛСАН НАМ
БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7578
УЛААНБААТАР ХОТ

Өнгөрсөн 35 жил Багахангай дүүргийн хувьд хөгжих боломжоо булаалагасан он жилүүд байлаа. Ардчилсан нам нийслэлийг удирдсан 2012-2016, Багахангай дүүрэгт олон төлөөлөлтэй болж дүүргийн Засаг даргын орлогчтой ажиллаж байсан жилүүдэд төр засаг нь иргэдээ сонсдог, иргэнд тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэдэг, Нийслэлийн төр захиргааны үйлчилгээг иргэндээ ойртуулж, иргэдээ сонсож орон нутгийн хөгжлийн санг нэмэгдүүлсэн, төрийн байгууллагуудыг шилэн данстай болгож иргэдэд нээлттэй болгосон, Нийтийн тээврийн салбарын цогц шинэчлэл, төрийн үйлчилгээний цахим үйлчилгээг нэвтрүүлсэн зэрэг томоохон өөрчлөлт шинэчлэлийг та бүхэнтэй хамтран эхлүүлсэн билээ. Бид энэ удаа Багахангайнхаа иргэдийн төлөө дүүргийн захиргааг хариуцлагатай, иргэдээ чирэгдүүлдэггүй болгох, иргэдээ ажилтай орлоготой болгох, агаар, хөрс, тоосжилт, орчны бохирдлыг цогцоор нь шийдвэрлэх гэр хорооллын дахин төлөвлөлт зэрэг томоохон өөрчлөлтийн төслүүдийг санал болгож байна.

## Нэг. БАГАХАНГАЙ ХОТЖИЛТ

**Өнөөгийн нөхцөл байдал:**

Өнгөрсөн жилүүдэд бид дүүрэгт бус суманд амьдарч ирлээ. Нэг нам дангаараа олон жил засаглаж дүүргийн хөгжлийг гацааж хөгжих боломж олгосонгүй. Газрын наймаа гаарч дарга нар хувь хувьдаа газараа наймалцан иргэдэд хаалттай байлаа. Дүүргээс газар авч үйлдвэр, жижиг дунд бизнес эрхлэх гэсэн байгууллага хувь хүмүүст хаалттай байна.

**Бидний хийх ажлууд:**

Дүүргийн газар зохион байгуулалтыг шинээр батлан гаргах, улмаар олон жил татвараа төлөөгүй газар эзэмшигчдийг газар эзэмших эрхийг цуцлах. Үйлдвэр үйлчилгээ эрхлэх сонгирхолтой иргэд аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллаж татвар, эдийн засгийн таатай орчин бий болгох.

Дүүргийн удирдлагыг хариуцлагатай, шийдвэр гаргалтыг шуурхай, нээлттэй болгох.
Дагуул хот болох шаардлагыг бүрэн хангах.

- Дулааны станц баринао.
- 1,2-р хороог холбосон дулааны шугам сүлжээтэй болно.
- 1,2-р хороонд шинээр байшин хорооллыг бий болгоно.
- Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээтэй болгож, ая тухтай амьдрах боломжоор хангана.
- Үйлдвэрүүдийг цэвэр, бохир, дулааны шугам сүлжээнд холбоно.

**Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүртээмжтэй болгох чиглэлээр:**

- Төрийн бүхий л үйлчилгээг иргэдэд ойртуулж дүүрэг, хорооноосоо авдаг болгоно.
- Газар эзэмшил, ашиглалтын талаарх мэдээллийг нээлттэй цахим болгоно. Газрын биржийн үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар газар дагасан авилга хүнд суртлыг арилгана.

АРДЧИЛСАН НАМ
ДҮҮРГИЙН ХОРОО
УЛААНБААТАР ХОТ

- Төрийн үйлчилгээнд иргэдээс шаарддаг бичиг баримтыг цөөрүүлнэ. Төрд байгаа мэдээллийг иргэнээс нэхдэгийг болиулна.
- Дүүргийн төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ажлын гүйцэтгэлийг үнэлэх урамшууллын тогтолцоог боловсронгуй болгож хэрэгжүүлнэ.

**Иргэд, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:**

- Иргэдийн оролцоог хангах эрхзүй, дүрэм журмыг боловсронгуй болгож, үр нөлөөтэй тогтолцоо бий болгоно.
- Дүүрийн иргэний баримтлах хэм хэмжээ, биеэ авч явах соёлын хэмжүүрийг тусгасан " Багахангай дүүргийн дүрэм"-тэй болно.
- Дүүрэг хөгжүүлэх, тохижуулах асуудлаар шийдвэр гаргахдаа иргэдийн саналд үндэслэдэг болно.
- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлэх асуудлын хүрээнд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын саналыг харгалзан үздэг болно.

**ХОЁР: ГЭР ХОРООЛОЛД**

**Бидний хийх ажлууд:**

*Бид дүүргээ эдийн засгийн томоохон төвүүдийн нэг, санхүүгийн чадавх сайтай, хөгжлийн зорилтуудаа санхүүжүүлэх хөрөнгө оруулалтаа өөрөө бий болгож, татаж чаддаг, бизнес эрхлэхэд таатай, иргэд нь тогтмол ажилтай орлоготой дүүрэг болгоно.*

**Бизнес эрхлэхэд таатай орчин бүрдүүлэх чиглэлээр:**

- Хувийн хэвшлийн хийх боломжтой ажлуудыг төр хийдэггүй байх зарчмыг баримталж, дүүргийн хэмжээнд хувийн хэвшлийг татвар, санхүүгийн оновчтой бодлогоор дэмжинэ.
- Нийслэл, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийг нээлттэй, олон нийтийн өмчит хэлбэрт оруулж, нэгтгэж, менежментийг эрс өөрчилнө.
- Дүүргийн харьяа байгууллагууд жижиг дунд, өрхийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлж, дүүрэгт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан авдаг зарчимд шилжинэ.
- Дүүргийн харьяа байгууллагууд Монголдоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан авдаг байх зарчимд шилжинэ.

**ГУРАВ: АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ**

**Бидний хийх ажлууд:**

Жижиг дунд бизнес эрхлэх сонгирхолтой иргэдийг дэмжих, өрхийн үйлдвэрлэлийн би болгоход дэмжлэг үзүүлнэ.

- Өрхийн хүлэмж, нарий ногоо,
- Өрхийн мөөг тариалах
- Өрхийн ашиг шим өндөртэй мал аж ахуй
- Өрхийн ноос носон бүтээгдэхүүн эсгий урлал

1117145633
УХА0612 9077278

АРДЧИЛСАН НАМ
БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7578
УЛААНБААТАР ХОТ

**Дэд бүтэц, инженерчлэлийн чиглэлээр:**

- Гэр хорооллын иргэдэд төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны хангамжид холбогдсон амины орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлнэ.
- Сэргээгдэх эрчим хүч, байгаль орчинд ээлтэй дэд бүтцийн шийдлүүдийг хөнгөлөлттэй санхүүжилтээр дэмжинэ.
- Дүүргийн гудамж, байшингийн хаягжилтыг олон улсын жишигт нийцүүлж, хялбар чиглүүлэгчтэй болгоно.

- Сууц өмчлөгчдийн холбоодыг дэмжих, бэхжүүлэх, чадамжийг нь дээшлүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- Гэр хорооллын янданг цөөрүүлэх, утаа угаарыг багасгах бодлогыг дэмжин хувийн хэвшил, шинэ дэвшилтэт технологи, инновацын шинэ санааг дэмжинэ.
- Цахимаар газар өмчлөх ажлыг эрчимжүүлнэ.
- Цахимаар газар олгосон шинэ суурьшлын бүсийн байршилд инженер хангамжийн байгууламжуудыг үе шаттайгаар байгуулна.

## ДӨРӨВ: НОГООН ДҮҮРЭГ

**Бидний хийх ажлууд:**

Бид Багахангай дүүрэгтэй хүрээлэн буй орчин, байгаль экологитойгоо нягт шүтэлцээтэй, мод, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, ус, агаар, хөрсний бохирдлыг эрс бууруулж, нөөцийг хэмнэлттэй, ухаалаг зарцуулах тогтолцоонд шилжсэн тогтвортой хөгжилтэй дүүрэг байгуулна.

**Хүрээлэн буй орчныг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр:**

- Дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хөрсний чанарыг сайжруулах зорилгоор гэр хорооллын айл бүрт хашаандаа мод тарих, хүлэмжийн аж ахуй эрхлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгоно.
- Дүүргийн бүсэд харшил үүсгэгч шарилж зэрэг нэр бүхий зэрлэг ургамлыг устгаж, иргэдийн эрүүл таатай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

**Нөөцийг тогтвортой ашиглах, хог хаягдлын менежентийг сайжруулах чиглэлээр:**

- Хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах тогтолцоог дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих, цахилгаан сүлжээн дэх нийлүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- Эрчим хүчний хэмнэлтийг дэмжих, хэрэглээг зүй зохистой удирдах зорилгоор ухаалаг сүлжээг нэвтрүүлнэ.

## ТАВ: ЭЭЛТЭЙ БАГАХАНГАЙ

1117145633
УХА0612 9077278

АРДЧИЛСАН НАМ
БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ... ХОРОО

**Бидний хийх ажлууд:**

Бид дүүргээ иргэд нь сурч хөгжих, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ авах боломж бүрдсэн, спортлог, авьяаслаг иргэдтэй, урлаг, гоозүйн үнэт капиталыг хуримтлуулсан, өв соёлоо хойч үедээ өвлүүлсэн, иргэндээ ээлтэй дүүрэг болгоно.

Амьдрахад таатай, аюулгүй орчин бий болгох чиглэлээр:

- Онцгой байдал, гамшгийн менежментийн тогтолцоог боловсронгуй болгон хөгжүүлж шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана.
- Хүүхдэд ээлтэй дүүрэг болох цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.
- "Хашаандаа сайхан амьдаръя" төсөл хэрэгжүүлж орчноо тохижуулж мод зүлэг тарьж суулгасан иргэдийг дэмжиж ажиллана.
- Цагдаагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, "Миний Цагдаа намайг хамгаална" гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Зам тээврийн ослыг бууруулах зорилгоор нийтийн тээврийн жолоочдод тавигдах шаардлагыг олон улсын жишигт нийцүүлнэ.
- Хөршийн холбоо, олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг идэвхжүүлэн дэмжиж , орчны аюулгүй байдлыг сайжруулна.

Эрүүл мэнд, боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох дэд бүтцийг бий болгоход онцгойлон анхаарна.
- Эмч, багш нарын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулдаг индексийн урамшууллыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- ЕБС-ийн үндсэн хичээлээс гадна сурагчдын оюун ухааныг хөгжүүлэх, мэдээллийн технологийн орчин үеийн мэдлэг олгох зорилгоор хиймэл оюун ухааны, кодчлол, эд юмсын интернэт гэх мэт хичээл сургалтыг нэмэлтээр ордог болгоно.
- Хороо бүрт урьдчилсан сэргийлэх эмч ажиллуулж, иргэдийн эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, эрүүл мэнд, биеийн тамирын өрөө, талбайг тохижуулж спортоор хичээллэх боломжийг бий болгоно.
- Жирэмсэн эхчүүд, ахмад настны халамж, эмнэлгийн үйлчилгээг сайжруулах хөтөлбөр боловсруулна.

**Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар, соёл, урлагийн байгууламжуудыг хамгаалах чиглэлээр:**

- Соёлын өвийг хамгаалах төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж, аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлнэ.
- Иргэдийн амрах, зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх цэцэрлэгт хүрээлэн, авто машины зогсоол, саравч, хүүхдийн тоглоомын талбай, боловсон бие засах газар бүхий цэгүүд байгуулна.
- Орчин үеийн "Соёл урлагийн ордон" байгуулах ажлыг дэмжиж ажиллана.

111714563
УХА0612 9077278

АРДЧИЛСАН НАМ
...ХАЙ ДҮҮРГИЙН ...ХОРОО
9073041590
ХТО7578
УЛААНБААТАР ХОТ

## 9 ЗОРИЛТ АЖИЛ

1. Газар эзэмшил, ашиглалтын талаарх мэдээллийг нээлттэй цахим болгоно. Газар дагасан авилга хүнд суртлыг арилгана.

2. Дүүргийн газар авсан байгууллага, иргэдийг газраа зориулалтын дагуу ашиглах талаар байнга шаардлага зөвлөмж өгч ажилна.

3. Дулааны станц барьж гэр хороолол, орон сууц, үйлдвэрийн газаруудыг тав тухтай орчин нөхцлөөр хангах.

4. Залуу гэр бүлийг дэмжсэн Орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх.

5. “Хашаандаа сайхан амьдаръя” төсөл хэрэгжүүлнэ.

6. Дотоодын их, дээд сургууль, хувийн ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсрол олгох хувийн байгууллагуудыг дэмжиж ажилна.

7. Нийтийн тээврийн үйлчилгээг ШИНЭ түвшинд гаргана.

8. Гарааны бизнесийг дэмжих төвийг бий болгож дэлхийд өрсөлдөх чадвартай брэнд бий болгоход нь дэмжлэг үзүүлнэ.

9. ”Дагуул хот” төсөл хэрэгжүүлэх.

1117145633
УХА0612 9077278

АРДЧИЛСАН НАМ
...ДҮҮРГИЙН ...ХОРОО
...41590
...ХТО7578
...АТАР ХОТ